



**ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**



**ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ**

THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION

# **ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН БАРОМЕТРИЙН СУДАЛГАА 2021**



**ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**



**ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ**

THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION

# **ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН БАРОМЕТРИЙН СУДАЛГАА**

Судалгааг гүйцэтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт,  
Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны сектор

Судалгааг гүйцэтгэсэн багийн гишүүд:

Б.Батбаатар	ХНХСИ-ийн захирал
М.Алтансүх	ХНХСИ-ийн дэд захирал
С.Батхолбоо	ХЭБСС-ын эрхлэгч
Г.Мягмардулам	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
Н.Жаргалсайхан	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
Д.Алтангэрэл	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
С.Хүрэл-Эрдэнэ	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
М. Энхзориг	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
Ж.Өлзийсайхан	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо  
Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөрийн ордон, 5 давхар

Утас: 77121286

Вэб хуудас: [www.rilsp.gov.mn](http://www.rilsp.gov.mn)

## АГУУЛГА

АГУУЛГА .....	3
ӨМНӨХ ҮГ .....	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	7
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	9
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ .....	10
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ .....	13
<b>БҮЛЭГ 1. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....</b>	<b>17</b>
1.1. Хөдөлмөрийн зах зээлийн төлөв .....	18
1.2. Бүртгэлтэй ажилгүй иргэн.....	22
1.3. Ажлын байрны захиалга, ажилд зуучлал .....	23
1.4. Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэд.....	27
<b>БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН .....</b>	<b>29</b>
2.1. Ажил олгогчид, ажиллагчдын мэдээлэл .....	30
2.1.1. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллага.....	30
2.1.2. Ажиллагчдын бүтэц.....	32
2.1.3. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн .....	40
2.1.4. Нээлттэй ажлын байр .....	48
2.2. Хөдөлмөрийн зах зээлийн ажиллах хүчний эрэлт .....	52
2.2.1. Оны эхний хагас дахь ажиллах хүчний эрэлт /2022.01-2022.06/ ....	54
2.2.2. Оны сүүлийн хагас дахь ажиллах хүчний эрэлт /2022.07-2022.12/ ....	55
.....	55
2.2.3. 2022 оны ажиллах хүчний нийт эрэлт .....	55
2.3. Ажиллах хүчний цомхотгол.....	71
2.4. Ажиллах хүчний хомсдол .....	72
2.5. Ажил олгогчдийн хүний нөөцийн асуудал .....	76
2.6. Өмнөх судалгааны үр дүнгийн харьцуулалт .....	78
<b>ДҮГНЭЛТ.....</b>	<b>86</b>
<b>САНАЛ , ЗӨВЛӨМЖ.....</b>	<b>88</b>
<b>СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....</b>	<b>89</b>
1. Судалгааны танилцуулга .....	90
2. Судалгааны түүвэр, хамрах хүрээ.....	91
3. Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт.....	94
<b>ХАВСРАЛТ.....</b>	<b>96</b>

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны эрэлтийг тодорхойлох зорилго бүхий барометрийн судалгааг 12 дэх жилдээ гүйцэтгэн, үр дүнг танилцуулж байна. Судалгааны үр дүн нь хөдөлмөр эрхлэлтийн салбарын бодлогод төдийгүй энэ чиглэлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажилтнуудад судалгааны хэрэглэгдэхүүн болдогоороо ач холбогдолтой билээ.

Энэхүү судалгааг олон улсын аргачлалаар 2010 оноос эхлэн жил тутам хийсэн бөгөөд ингэснээр Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн талаар томоохон мэдээллийн сан бүрдэж, ажиллах хүчний эрэлтийн дунд хугацааны болон хэтийн тооцоололд ашиглагдахуйц өгөгдөл бий болж байгаа юм.

Энэ удаагийн судалгаагаар бид 2022 оны хөдөлмөрийн зах зээлийн ажиллах хүчний эрэлт хэрэгцээ, өнгөрсөн жилийн ажиллах хүчний хомсдолыг тодруулан, тайлагнаж байна. Хэдийгээр энэ жилийн хувьд коронавируст халдвар цар тахлаас шалтгаалсан хүчин зүйлийн нөлөөгөөр урьдчилан төсөөлж, төлөвлөх боломжгүй нөхцөл байдал удаан үргэлжилж, эдийн засаг, нийгмийн байдал тогтворгүй байгаа ч ажил олгогчид 2022 оныг харьцангуй эерэгээр харж, хүлээлт өндөртэй байна.

Улсын хэмжээнд 2022 онд 78.0 мянган ажлын байр бий болох ба өмнөх оны судалгааны дүнтэй харьцуулахад 25.0 гаруй мянган ажлын байр буюу 48.3 хувиар өссөн зэрэг эерэг төлөв ажиглагдсан үр дүн гарлаа.

Та бүхэн судалгааны дэлгэрэнгүй үр дүнтэй танилцан, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглахын зэрэгцээ судалгааны арга, аргачлалтай холбоотой санал хүсэлтээ бидэнд илгээж, хамтран ажиллахыг хүсье.

ЗАХИРАЛ



Б. БАТБААТАР

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Ажиллах хүчний зарим статистик үзүүлэлт, бүсээр, мянган хүн ..	19
Хүснэгт 2. Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар .....	20
Хүснэгт 3. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар .....	21
Хүснэгт 4. Бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, бүсээр, 2021 он.....	22
Хүснэгт 5. Ажлын байрны захиалга, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2015-2021 он.....	24
Хүснэгт 6. Ажилд зуучлагдсан иргэд, бүсээр, мянган хүн, 2015-2021 он.....	25
Хүснэгт 7. Ажилд зуучлагдсан иргэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн, 2015-2021 он.....	27
Хүснэгт 8. 2021 онд хөдөлмөр эрхэлж буй гадаад ажиллагчдын хувь, ажил мэргэжлийн үндсэн бүлгээр.....	28
Хүснэгт 9. Гадаад ажиллагчдын эзлэх хувь, байгууллагын өмчийн хэлбэрээр .....	28
Хүснэгт 10. Судалгаанд хамрагдсан ААНБ-ын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар, үйл ажиллагааны хэлбэрээр.....	30
Хүснэгт 11. Хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт, мян. хүн .....	33
Хүснэгт 12. Судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар .....	34
Хүснэгт 13. Ажиллагчид, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр, хувь .....	36
Хүснэгт 14. Байнгын ажиллагчид, салбар, ажил мэргэжлийн үндсэн бүлгээр, хувь.....	37
Хүснэгт 15. Түр ажиллагчид, салбар, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр, хувь.....	39
Хүснэгт 16. Шинэ ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар .....	41
Хүснэгт 17. Шинэ ажиллагчдын эзлэх хувь, ажил мэргэжлийн үндсэн бүлгээр .....	42
Хүснэгт 18. Шинэ ажиллагчдын эзлэх хувь, ажил мэргэжлээр .....	43
Хүснэгт 19. Халагдсан ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар .....	44

Хүснэгт 20. Шинэ болон халагдсан ажиллагчид, ажил мэргэжлээр.....	47
Хүснэгт 21. Нээлттэй зарлагдсан ажлын байрны түвшин, салбараар .....	48
Хүснэгт 22. Нээлттэй зарлагдсан ажлын байрны эзлэх хувь, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр .....	51
Хүснэгт 23. Нээлттэй зарлагдсан ажлын байрны эзлэх хувь, ажил мэргэжлийн ангиллаар.....	51
Хүснэгт 24. 2021 оны ажиллах хүчний эрэлт, салбар, хугацаагаар.....	59
Хүснэгт 25. Ажиллах хүчний эрэлт, ажлын байрны хэлбэр, салбараар.....	63
Хүснэгт 26. Ажиллах хүчний эрэлт, салбараар, ажлын байрны төрлөөр...	64
Хүснэгт 27. Ажиллах хүчний эрэлт, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлэг, хувиар.....	68
Хүснэгт 28. Эрэлттэй ажил мэргэжил, хувиар .....	68
Хүснэгт 29. Ажиллах хүчний хомсдол, бүсээр, хүйсээр.....	73
Хүснэгт 30. Ажиллах хүчний хомсдол, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар.....	74
Хүснэгт 31. Ажиллах хүчний хомсдол, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр, хувиар .....	75
Хүснэгт 32. Хомсдолтой ажил мэргэжил, дүнд эзлэх хувиар.....	75
Хүснэгт 33. Эрэлттэй ажил мэргэжил, оноор .....	82
Хүснэгт 34. Хомсдолтой ажил мэргэжил, оноор.....	84

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Монгол Улсын 15, түүнээс дээш насны хүн ам, мянган хүнээр, 2010-2021 он .....	18
Зураг 2. Ажиллах хүч, мянган хүн, 2010-2021 он.....	18
Зураг 3. Хөдөлмөр эрхлэлтийн зарим статистик үзүүлэлт, 2010-2021 он ...	19
Зураг 4. Бүртгэлтэй ажилгүй иргэн, насны бүлэг, хувиар.....	23
Зураг 5. Ажлын байрны захиалга, бүсээр, мянган хүнээр, 2015-2021 он... 23	
Зураг 6. Ажлын байрны захиалга, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр, мянган хүн .....	25
Зураг 7. Ажилд зуучлагдсан иргэд, ажил мэргэжлийн үндсэн ангиллаар, мянган хүн.....	27
Зураг 8. Гадаад ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар /хувь/ .....	28
Зураг 9. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын тоо, аймгаар .. .....	30
Зураг 10. Судалгаанд хамрагдсан ААНБ-ын хувь, үйл ажиллагааны хэлбэр, байршлаар .....	31
Зураг 11. Судалгаанд хамрагдсан ААНБ-ын хувь, өмчийн хэлбэр, байршлаар .. .....	32
Зураг 12. Ажиллагчдын эзлэх хувь, ажлын байрны хэлбэр, хүйсээр.....	35
Зураг 13. Байнгын болон түр ажиллагчдын боловсролын түвшин, хувь.....	35
Зураг 14. Сүүлийн 12 сард ажлаас гарсан ажиллагчдын хувь, байршлаар..... .....	46
Зураг 15. Сүүлийн 12 сард ажлаас гарсан ажиллагчдын хувь, ААНБ-ын ажиллагчдын тооны бүлгээр.....	46
Зураг 16. Нээлттэй ажлын байр, байршлаар, мян/хүн.....	50
Зураг 17. Нээлтэй ажлын байр, ажил олгогчийн ажиллагчдын тооны бүлгээр, мян/хүн.....	50
Зураг 18. 2022 онд ААНБ-ууд шинээр ажилтан авах эсэх, бүсээр, хувиар..... .....	53
Зураг 19. 2022 оны эхний 6 сарын ажиллах хүчний эрэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, хувиар.....	54
Зураг 20. 2022 оны сүүлийн 6 сарын ажиллах хүчний эрэлт, ЭЗҮА-ны салбарын ангилал, хувиар.....	55
Зураг 21. 2022 оны ажиллах хүчний эрэлт, салбарын ангилал, хувиар.....	56
Зураг 22. Ажиллагчдын тоо болон ажиллах хүчний эрэлт, салбарын ангиллаар, мянган хүн .....	58



Зураг 23. 2022 оны ажиллах хүчний эрэлт, бүсээр, хувиар .....	60
Зураг 24. Ажиллах хүчний эрэлт, ААНБ-ын өмчийн хэлбэр, ажлын байрны хэлбэрээр .....	62
Зураг 25. Ажиллах хүчний эрэлт, ААНБ-ын ажиллагчдын тооны бүлгээр, хувиар.....	62
Зураг 26. Ажиллах хүчний эрэлтийн эзлэх хувь, ажлын байрны төрөл, өмчийн хэлбэрээр .....	66
Зураг 27. Сул ажлын байр бий болсон шалтгаан, хувиар .....	66
Зураг 28. Ажил олгогчдын чухалчилдаг зөөлөн ур чадварын шаардлага ....	69
Зураг 29. Ажил олгогчдын чухалчилдаг мэргэжлийн ур чадварын шаардлага .....	70
Зураг 30. Шинэ ажиллагчдаас шаардах боловсролын доод түвшин, хувиар ... ..	71
Зураг 31. Шаардлагатай мэргэжилтэй ажилтан олдоогүйгээс ажилтан авч чадаагүй байдал, бүсээр, хувиар.....	72
Зураг 32. Ажиллагчдад чиглэсэн сургалт, арга хэмжээ, хувиар .....	76
Зураг 33. Шинэ ажилтан авахад ашигладаг мэдээллийн эх сурвалж, хувиар. ....	77
Зураг 34. Шинээр ажилтан авахад болон ажиллуулахад тулгардаг нийтлэг бэрхшээл, хувиар .....	34
Зураг 35. Ажиллах хүчний эрэлт, мянган хүнээр, 2013-2022 он .....	79
Зураг 36. Ажиллах хүчний эрэлт, тэргүүлэх салбараар, мянган хүнээр.....	79
Зураг 37. Ажиллах хүчний эрэлт, бүс нутгаар, мянган хүнээр.....	80
Зураг 38. Ажиллах хүчний эрэлт, хугацаагаар, хувиар.....	81
Зураг 39. Ажиллах хүчний эрэлт, ажлын байрны хэлбэрээр, хувиар .....	81
Зураг 40. Ажиллах хүчний эрэлт, ажлын байрны төрлөөр, хувиар.....	82
Зураг 41. Ажиллах хүчний хомсдол, мянган хүнээр, 2013-2021 он .....	84

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХНХСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БРС	Бизнес регистрийн сан
ХАА	Хөдөө аж ахуй
ИСИХ	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбар
ҮАМАТ	Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт
ISCO	Мэргэжлийн ангиллын олон улсын стандарт
ХЗЗ	Хөдөлмөрийн зах зээл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
САPI	Computer-assisted personal interview
САTI	Computer Assisted telephone interview
РАPI	Pen-and-Paper Personal Interview
САWI	Computer Assisted Web Interview

## ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

### **Эдийн засгийн үйл ажиллагаа**

Зах зээлд зориулж үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээ юм. Өөрөөр хэлбэл, үндэсний тооцооны системийн хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд худалдах, солилцох эсвэл өөрийн хэрэглээндээ зориулан өрхөд үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хамруулна. Харин өөрийн хэрэглээндээ зориулсан үйлчилгээ болон бусдын хэрэгцээнд зориулсан сайн дурын үйлчилгээг хамруулахгүй.

### **Хөдөлмөрийн насны хүн ам**

15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна (заалт 15, 65, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

### **Ажиллах хүч**

Тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм (заалт 11, 16, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

### **Ажиллах хүчнээс гадуурх хүн ам**

Сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас боломжит ажиллах хүчин (тодорхойлолт 2.16.3)-ийг тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр өргөтгөсөн ажиллах хүч илэрхийлэгдэнэ (заалт 16,55, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

### **Хөдөлмөрийн дутуу ашиглалт**

Хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно (заалт 40, 42 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг дараах үзүүлэлтээр хэмжинэ.

### **Хөдөлмөр эрхлэлт**

Цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа юм. Хөдөлмөр эрхлэлт гэсэн ажлын хэлбэр нь ажиллах хүчний статистикийн хамрах хүрээг тогтооно (заалт 7b, 11, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

### **Ажиллах хүчний эрэлт**

Ажил олгогчид хэрэгцээтэй хөдөлмөрийн үйлчилгээний хэмжээг;

### **Аж ахуйн нэгж**

Улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээд болон үндсэн үйл

ажиллагаа нь ашгийн бус боловч бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлж орлого олсон дотоод, гадаадын хуулийн этгээдийг;

### **Ажлын байр**

Иргэн, ажилтны гүйцэтгэх ажил үүрэгтэйгээ холбоотойгоор хүрэлцэн очих ёстой ажил олгогчийн шууд ба шууд бус хяналтын дор ажил гүйцэтгэх бүх байрыг;

### **Ажиллагч**

Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ.

Ажлын байран дээрх дадлага, туршлага, ур чадвар эзэмших

Тодорхой мэргэшил, мэргэжлийн үнэмлэх олгодог эсэхээс үл хамааран уламжлалт арга хэлбэрээр, албан болон албан бус хэлбэрээр ажлын 8 байран дээрээ туршлага, ур чадвараа дээшлүүлэхийг ойлгоно (заалт 33е, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-I).

### **Ажил олгогч**

Эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг бие даан гаргаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон ашиг буюу ашиг олох боломжоос шууд хамаарах бизнестээ урт хугацаагаар нэг буюу түүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн болон бусад гэрээ, тохиролцооны үндсэн дээр авч ажиллуулж буй эзэн, байгууллагын удирдлагыг;

### **Ажил хайгч**

Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг;

### **Байнгын ажлын байр**

Ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил үүргийг;

### **Байнгын ажилтан**

Байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн тухай болон төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг;

### **Түр ажлын байр**

Хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил, үйлчилгээг хөдөлмөрийн ба хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээг үйл ажиллагааны онцлогоос хамааран зургаан сар хүртэлх хугацаагаар байгуулж, тодорхой нэг ажил үүргийг гүйцэтгэснээр дуусгавар болдог, байнгын давтамжгүй, тохиолдлын шинж чанартай ажил үүрэг, албан тушаалыг;

### **Түр ажилтан**

Хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил, үйлчилгээг хөдөлмөрийн ба хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх

гэрээг үйл ажиллагааны онцлогоос хамааран зургаан сар хүртэлх хугацаагаар байгуулж, цалин хөлс, орлого олдог, эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарах, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг өөрөө бие даан хариуцаж төлдөг иргэнийг;

### **Улирлын ажлын байр**

Улирлын чанартай байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг ажил, үүрэг, албан тушаалыг;

### **Улирлын ажилтан**

Улирлын чанартай байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг;

### **Шинэ ажлын байр**

Эдийн засгийн үйл ажиллагааны хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох болон өргөтгөх замаар албан ба албан бус салбарт шинээр бий болсон ажил, үүрэг, албан тушаалыг;

### **Бүртгэлтэй ажилгүй хүн**

Өнгөрсөн долоо хоногт буюу түүнээс өмнө ямар нэг шалтгаанаар ажилгүй болсон эсвэл халагдсан, халагдсан тушаалаа бичгээр авч ажил зуучлагчийн газар бүртгүүлсэн ажил идэвхтэй хайж байгаа ажилд ороход бэлэн хүнийг;

### **Төрийн өмчит хуулийн этгээдийн ойлголт**

Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг;

### **Гадаад улсын хөрөнгө оруулалттай**

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, өөрийн хөрөнгө нь 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх төгрөгөөс дээш, түүний 25-аас доошгүй хувь нь гадаадын хөрөнгө оруулагчийн хувь хөрөнгөөс бүрдсэн аж ахуйн нэгжийг;

### **Мэргэжилтэй ажилтан**

Тодорхой ажил эрхлэх, мэдлэг ба зохих ур чадварыг зориулалтын сургалтаар олж авсан, эсвэл эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан мэргэжилтэй хүнийг;

### **Өөрийн хүсэлтээр халагдсан**

Хууль болон хөдөлмөрийн гэрээнд өөрөөр заагаагүй бол ажилтан хөдөлмөрийн гэрээ цуцлах тухай өргөдлөө ажил олгогчид өгсөн өдрөөс хойш 30 хоног өнгөрмөгц ажлын байраа орхих эрхтэй, энэ тохиолдолд хөдөлмөрийн гэрээ цуцлагдсанд тооцно.

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн баромерийн судалгаа нь Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны ажиллах хүчний эрэлтийг тодорхойлон боловсрол сургалт, хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, эрдэмтэн судлаачдыг шаардлагатай мэдээлэл, судалгааны хэрэглэгдэхүүнээр хангах, ажиллах хүчний эрэлтийн дунд хугацааны болон хэтийн тооцоололд ашиглагдахуйц өгөгдөл гаргадагаараа ач холбогдолтой.

Энэ удаагийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаагаар Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн нийт 2923 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, үр дүнг түүврийн эх олонлогт тархаан тооцож, 2022 оны ажиллах хүчний эрэлтийг тодорхойллоо. Судалгааны түүврийн 64.3 хувь буюу 1880 аж ахуйн нэгжийг Улаанбаатар хот, 35.7 хувь буюу 1043 ААНБ-ыг 21 аймгаас оролцууллаа.

### Ажиллах хүчний нийт эрэлт

Хэдийгээр энэ жилийн хувьд коронавируст халдвар /COVID-19/ цар тахлаас шалтгаалсан хүчин зүйлийн нөлөөгөөр урьдчилан төсөөлж, төлөвлөх боломжгүй нөхцөл байдал удаан үргэлжилж, эдийн засаг, нийгмийн байдал тогтворгүй байгаа ч ажил олгогчид 2022 оныг харьцангуй эерэгээр харж, хүлээлт өндөртэй байгаа нь ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүсэлтэй зогсонги байдал өөрчлөгдөж, үйл ажиллагаагаа хэвийн горимоор үргэлжлүүлэх бүрэн итгэлтэй байна.

Улсын хэмжээнд 2022 онд 78.0 мянган ажлын байр бий болох ба өмнөх оны судалгааны дүнтэй харьцуулахад 25.0 гаруй мянган ажлын байр буюу 48.3 хувиар өсч, цар тахлын нөхцөл байдлаас өмнөх үеийн хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий чиг хандлага хадгалагдах төлөв ажиглагдлаа. Ажиллах хүчний эрэлтийн хүрээнд хөдөлмөр эрхлэлт 6.9 хувиар өсөх боломжтой харагдаж байна.

2022 онд ажиллах хүчний эрэлт хамгийн их байх салбар нь өмнөх жилүүдийн адил бөөний болон жижиглэн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэл, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар болж байна.

Бөөний болон жижиглэн худалдааны салбарт жилийн нийт эрэлтийн 30.7 хувь буюу 23.9 мянган ажиллах хүчний эрэлт бий болох нь өмнөх жилийн судалгааны үр дүнгээс 79.5 хувиар өсөх үзүүлэлт юм. Барилгын салбарт 11.5 мянган ажиллах хүчний эрэлт бий болох нь нийт эрэлтийн 14.7 хувийг эзэлж, өмнөх жилийн судалгааны үр дүнгээс 5.9 хувиар, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 10.2 мянга буюу нийт эрэлтийн 13.1 хувь бий болж, 50.3 хувиар, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт 4.1 мянга буюу нийт эрэлтийн 5.2 хувь бий болж, мөн л 61.8 хувиар өсөх үзүүлэлттэй байна.

Энэ оны /2022/ хүлээгдэж буй ажиллах хүчний нийт эрэлтийн 29.2 хувь нь орон нутагт бий болно. Үүний 65.1 хувь нь шинэ ажлын байр байгаа нь орон нутгийн хөдөлмөрийн зах зээл мөн хэмжээгээр тэлэх боломж буйг харуулж байгаа юм. Орон нутгийн ажиллах хүчний эрэлтэд дараах эдийн

засгийн салбарууд гол нөлөөг үзүүлж байна. Тухайлбал, бөөний болон жижиглэн худалдааны салбарт орон нутгийн ажиллах хүчний эрэлтийн 24.6 хувь, барилгын салбарт 13.7 хувь, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт 9.0 хувь нь бий болох төлөвтэй байна.

### **Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн**

Хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчний салбарын дотоод болон салбар хоорондын шилжилт хөдөлгөөн их, үүнээс үүдэлтэй хөдөлмөр эрхлэлтийн тогтворгүй байдал их байдаг.

Сүүлийн 12 сарын хугацаанд аж ахуйн нэгж байгууллагын 24.7 хувь нь шинэ болон сул ажлын байрандаа ажилтан авч ажиллуулсан. Ингэснээр 72.3 мянган иргэн шинээр ажилд орсон бөгөөд эдгээр шинэ ажиллагчдын 74.3 хувь нь байнгын ажиллагч бол, 57.7 хувийг сул орон тоог нөхсөн ажиллах хүчин бүрдүүлж байна. Эдгээр ажиллагчдын 44.1 хувь нь эмэгтэйчүүд байжээ.

Сүүлийн 12 сард ажилд орсон нийт ажиллагчдын 12.7 хувь нь барилгын салбарт, 9.8 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 8.5 хувь нь боловсролын салбарт ажилд орсон нь сүүлийн 12 сард шинээр ажилд орсон нийт ажиллагчдын 31.0 хувь болж байна. Харин 24.8 хувь буюу хамгийн өндөр хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарт харьяалагдаж байна.

Ажил мэргэжлийн үндсэн бүлгээр харвал шинэ ажиллагчдын 23.9 хувь нь мэргэжилтэн, 22.3 хувь нь энгийн ажил мэргэжил, 15.1 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 11.7 суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 10.1 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан зэрэг ажил мэргэжлийн чиглэлд хамаарах ажлын байраар хангагджээ. Эмэгтэй ажиллагчдад эзлэх хувиар харвал эмэгтэйчүүдийн 79.9 хувь нь дээрх 4 чиглэлийн ажил мэргэжлийн ажилд оржээ.

Мэргэжилтэн бүлэгт хамаарах ажил мэргэжлийн чиглэлээр ажилд орсон иргэд нийт ажилд орсон эмэгтэй ажиллагчдын 33.4 хувь, байнгын ажиллагчдын 26.2 хувь, нийт сул ажлын байрны 25.1 хувийг тус тус бүрдүүлж байна. Шинэ ажиллагчдад эзлэх хувиар харвал 81.4 хувь нь байнгын ажлын байр, 60.6 хувь нь сул ажлын байраар хангагджээ.

Ажил олгогчид сүүлийн 12 сарын хугацаанд давхардсан тоогоор 72.3 мянган иргэнийг ажлын байраар хангаж, хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгосон хэдий ч мөн хугацаанд 138.2 мянган ажиллагчид ямар нэг шалтгаанаар ажлаас гарсан байна. Өнгөрсөн оны үр дүнтэй харьцуулахад шинээр ажилд орсон иргэдийн тоо өмнөх оноос 48.9 хувиар, ажлаас гарсан иргэдийн тоо 1.3 дахин өссөн нь ихээхэн анхаарал татаж байна. Энэ нь цар тахлаас үүдэлтэй давагдашгүй хүчин зүйлийн нөлөө нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд сөрөг үр дагавар үзүүлсэн төдийгүй хөдөлмөрийн зах зээлд ч хүчтэй нөлөө үзүүлж буйг харуулж байна.

Ажлаас гарсан ажиллагчдын 47.8 хувь нь өөрийн хүсэлтээр ажлаа орхисон бөгөөд 52.2 хувь нь хөдөлмөрийн гэрээ дуусах, халагдах, цомхотголд орох гэх мэт ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөр эрхлэлт нь дуусгавар болжээ.

Өөрийн хүсэлтээр ажлаас гарсан иргэдийн 40.7 хувь, ажил олгогчийн санаачилгаар ажлаас гарсан ажиллагчдын 15.8 хувь эмэгтэйчүүд байжээ.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар харвал нийт ажлаас гарсан иргэдийн 36.2 хувийг тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбар, 15.6 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбар, 10.4 хувийг барилга, 8.6 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбараас ажлаас гарсан ажиллагчид эзэлж нийт ажиллагчдын 70.9 хувийг бүрдүүлж байна.

### **Хүний нөөц**

Ажил олгогчид ажил мэргэжлийн ур чадвараас илүүтэй зөөлөн гэж нэрлэгддэг хувь хүний үндсэн зан чанарт суурилсан ур чадварыг чухалчилдаг. Хувь хүний үндсэн өгөгдөлт зан чанар, суурь хүмүүжил, ерөнхий хандлага, ес зүйг хамгийн чухал үзүүлэлт хэмээн үзсээр байгаа сүүлийн 5 жилийн хугацаанд огт өөрчлөгдөөгүй.

Зөөлөн ур чадвар /soft skills/-ын хувьд ач холбогдлоор нь эрэмбэлэн харвал ажил олгогчид шинэ ажилтан авахдаа ажил горилогчийн бие даан ажиллах чадвар, найдвартай, хариуцлагатай байдал, эерэг зөв хандлагатай байдал, харилцааны ур чадвар, цаг ашиглах чадварыг хамгийн ихээр чухалчилдаг. Эдгээр үзүүлэлтүүд жил бүрийн судалгааны үр дүнгээр тогтмол нэрлэгддэг төдийгүй энэ төрлийн бусад асуултад хамгийн өндөр давтамжтай нэрлэгдсээр байдаг. Түүнчлэн ачаалал даах, багаар ажиллах чадвар нь ажил олгогчдод чухал ач холбогдолтой, нэн тэргүүнд шаардах ур чадвар байсаар байна.

Шинээр ажилтан авахад тулгарч буй гол бэрхшээл нь дээр дурдсанчлан ажил горилогчийн хувь хүний хандлага, хариуцлагатай холбоотой асуудлууд байсаар байна. Энэ удаагийн судалгааны дүнгээр хамгийн түгээмэл тохиолддог бэрхшээлд ажиллагч тогтвортой ажиллахгүй байх, ажлын туршлагагүй байдал хэмээн дурдсан бөгөөд энэ нь жил бүрийн судалгааны дүнд тогтмол нэрлэгдсээр байна.

Сүүлийн 12 сарын хугацаанд ажил олгогчдын 19.7 хувь нь ажиллагчдадаа чиглэсэн сургалт арга хэмжээг зохион байгуулжээ. Ажил олгогчдын 19.7 хувь нь байгууллага дотооддоо сургалт зохион байгуулах, гадаад болон дотоодын сургалт, арга хэмжээнд хамруулсан нь өмнөх оны мөн үр дүнгээс 7.2 пунктээр буурсан үзүүлэлт болж байна.

Зохион байгуулсан гадаад, дотоодын нийт сургалт, арга хэмжээний 29.1 хувь нь ажилтныг ажил мэргэжлийн хувьд мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, 25.5 хувь нь хувь хүнийг хөгжүүлэх, 20.0 хувь нь мэргэжил дээшлүүлэх, 19.9 хувь нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлийн сургалт байсан бол 5.5 хувь нь мэргэжил олгох сургалт байна.

Өмнөх жилүүдийн адилаар цахим орчинд ажлын байрны мэдээлэл түгээх байдлаар ажилтнаа сонгон шалгаруулж, хүний нөөцөө бүрдүүлдэг арга аж ахуйн нэгж, байгууллагуудад зонхилсон хэвээр байна. Шинэ ажилтан авахад ашигласан мэдээллийн эх сурвалжийн 26.3 хувийг дээрх төрлийн эх сурвалж эзэлж, 19.3 хувийг албан бус байдлаар буюу хувийн харилцаа, холбоогоор, 17.1 хувь нь зар сурталчилгаа, мэдээллийн хэрэгслээр нийтлэх байдлаар сонгодог гэсэн бол ажил хайгч иргэд өөрөө ажил олгогчид хандах нь 11.7 хувийг эзэлж байна.



## **Ажиллах хүчний хомсдол**

Өнгөрөгч онд аж ахуйн нэгж байгууллагын 19.1 хувь нь шаардлагатай мэргэжилтэй ажилтан олдоогүйн улмаас төлөвлөсөн ажилтнаа авч чадаагүй буюу ажиллах хүчний хомсдолд өртсөн гэсэн нь өмнөх оноос 0.7 пунктээр өссөн үзүүлэлт болжээ.

Ажиллах хүчний хомсдолд өртсөн нийт ААНБ-уудын 35.0 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд ажиллах хүчний хомсдолын 29.2 хувийг тухайн салбарын хомсдол эзэлж байна. Үүнээс гадна барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажил олгогчид ажиллах хүчний хомсдолд өртсөн аж ахуйн нэгжүүдийн 21.4 хувийг эзэлж, эдгээр салбарын ажиллах хүчний хомсдол нийт хомсдолын 32.2 хувийг бүрдүүлж байна. Салбарын ажиллах хүчний хомсдолд эмэгтэйчүүдийн эзлэх хувиар харвал хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын ажиллах хүчний хомсдолын 73.9 хувь, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа салбарын 71.5 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын хомсдолын 64.6 хувьд эмэгтэй ажиллагчдын хэрэгцээ байжээ.

Ажил мэргэжил хувьд хамгийн их хомсдолтой байсан нь үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан, барилгын туслах ажилтан, ачигч, харуул, албан байгууллагын цэвэрлэгч гэх мэт энгийн ажил мэргэжлийн хомсдол 24.3 хувийг бүрдүүлж байна. Түүнчлэн тогооч, жолооч, зөөгч, засалчин, шаварчин, гагнуурчин, дэлгүүрийн кассчин, цахилгаанчин, өнгөлгөөний болон барилга угсралтын мужаан зэрэг ажил мэргэжлүүд 18.2 хувь, механик инженерийн техникч, цахилгааны инженер, сувилагч, арга зүйч, ахлах нягтлан бодогч, малын эмч зэрэг ажиллах хүчний хомсдол 5.6 хувийг эзэлжээ. Дээр дурьдагдсан ажил мэргэжлийн ажиллах хүчин хомсдол 2021 оны ажиллах хүчний хомсдолын 54.2 хувийг эзэлж байна.

# I БҮЛЭГ

## ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

## 1.1. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

Энэ хэсэгт Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий төлөв байдлыг товч танилцуулъя.

### Ажиллах хүч

Монгол Улсын хүн амын тоо тогтмол өсөлттэй байгаа хэдий ч хөдөлмөрийн насны хүн ам сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна. Хөдөлмөрийн насны хүн ам 2021 оны III улирлын байдлаар цар тахлын өмнөх үе буюу 2019 онтой харьцуулахад 0.7 хувиар өссөн байна. Тэдгээрийн 57.8 хувийг ажиллах хүч, үлдсэн хувийг ажиллах хүчнээс гадуурх хүн ам эзэлж байна. Хөдөлмөрийн насны хүн амд ажиллах хүчний эзлэх хувь 2019 оноос 2.7 пунктээр буурсан. Ажиллах хүч 2018 оноос тасралтгүй буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 1. Монгол Улсын 15, түүнээс дээш насны хүн ам, мянган хүнээр, 2010-2021 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2020 оны эцсийн байдлаар ажиллах хүч 1251.0 мянган хүн, үүнээс 87.7 мянган хүн ажилгүй байсан. Ажилгүй хүн өмнөх оны мөн үеэс 31.3 хувиар, ажилгүйдлийн түвшин 7.0 хувь болж 3.0 пунктээр буурчээ. Харин 2021 оны III улирлын байдлаар ажиллах хүч 1226.0 мянга болж бууран, ажилгүй хүн 90.9 мянгад хүрч өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 2. Ажиллах хүч, мянган хүн, 2010-2021 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2020 онд сүүлийн 10 жилийн хугацаан дах хамгийн их буурсан үзүүлэлт байсан бол 2021 оны III улирлын байдлаар 3.6 хувиар өссөн байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин нь хөдөлмөрийн насны хүн амд эзлэх ажиллах хүчний хувь, хэмжээг харуулдаг. Сүүлийн 10 жилийн хугацаанд тус үзүүлэлт 2012 онд хамгийн өндөр буюу 63.5 хувь байсан бол 2020 оны байдлаар 58.8 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.7 пунктээр буурсан үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт 2017 оноос жил бүр тасралтгүй буурсаар 2021 оны III улирлын байдлаар 57.9 хувьтай байна.

Зураг 3. Хөдөлмөр эрхлэлтийн зарим статистик үзүүлэлт, 2010-2021 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин нь хөдөлмөрийн насны хүн амд эзлэх ажиллагчийн хувь, хэмжээг илэрхийлдэг бөгөөд сүүлийн 10 жилийн хувьд тус үзүүлэлт 2012 онд хамгийн өндөр буюу 58.3 хувь байсан. 2016-2018 оны хооронд өсч байсан хэдий ч 2019 онд 54.4 хувь болж өмнөх оноос 1.9 пунктээр буурсан. Харин 2020 онд 54.6 хувь болж 0.2 пунктээр өссөн бол 2021 оны III улирлын байдлаар 53.6 хувь болж буурчээ.

Ажилгүйдлийн түвшин 2019 онд огцом нэмэгдэж 10.0 хувьд хүрч байсан ба 2020 онд 0.3 пунктээр буурсан бол 2021 оны III улирлын байдлаар 7.4 хувь болж 0.4 пунктээр өссөн байна.

Улсын хэмжээнд ажиллах хүчин 2020 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар буурсан байсан бөгөөд энэ нь орон нутагт хамааралтай байгааг бүх бүсүүдэд ажиллах хүчний хэмжээ буурсанаас харж болно. Улаанбаатар хотод нийт ажиллах хүчний 44.2 хувь нь хамаарч, өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байв. Харин 2021 оны III улирлын байдлаар Зүүн бүсээс бусад байршилд буурсан үр дүн харагдаж байна.

Хүснэгт 1. Ажиллах хүчний зарим статистик үзүүлэлт, бүсээр, мянган хүн

Бүс	Ажиллах хүч			Ажиллагчдын тоо			Ажилгүйдлийн түвшин	
	2019	2020	2021-III	2019	2020	2021-III	2019	2020
Улсын дүн	1,273.9	1,250.6	1,226.8	1,146.2	1,162.9	1,135.9	10.0	7.0
Баруун	167.2	153.8	178.5	147.6	138.3	165.1	11.7	10.1
Хангай	260.7	248.5	246.4	239.4	232.2	222.0	8.2	6.5
Төв	218.0	199.5	181.2	201.3	186.0	162.1	7.6	6.8

Зүүн	98.6	96.7	97.0	86.8	89.0	94.6	11.9	8.0
Улаанбаатар	529.5	552.1	523.6	471.0	517.4	492.1	11.0	6.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2020 оны нийт ажиллагчдын 44.5 хувь нь Улаанбаатарт ажиллаж байсан нь өмнөх оны мөн үеэс 9.9 хувиар өссөн бол Зүүн бүсээс бусад бүс, орон нутагт буурсан үзүүлэлттэй байсан. 2021 оны III улирлын байдлаар нийт ажиллагчид буурсан үр дүнтэй бөгөөд энэ бууралт Улаанбаатар хот болон Хангайн бүс, Төвийн бүсэд хамааралтай байна.

### Ажил олгогчид

ҮСХ-ны мэдээгээр 2020 оны IV улирлын байдлаар 96.0 мянган ААНБ идэвхтэй үйл ажиллагаа явуулж байсан нь 2019 оны мөн үеэс 1.6 хувиар өссөн бол 2021 оны III улирлын байдлаар 95.2 мянга болж буурчээ.

Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, мэдээлэл, холбоо, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, боловсрол, хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбараас бусад салбарт ажил олгогчийн тоо буурсан байна.

Хүснэгт 2. Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2019-IV		2020-IV		2021-III	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	3.8	4.1	3.5	3.6	3.2	3.4
Уул уурхай, олборлолт	1.3	1.4	1.3	1.4	1.1	1.2
Боловсруулах үйлдвэрлэл	6.4	6.7	6.4	6.7	5.9	6.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	0.2	0.3	0.3	0.3	0.3	0.3
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2
Барилга	7.4	7.9	7.8	8.1	7.5	7.8
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	37.7	39.9	38.5	40.2	36.8	38.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.7	1.7	1.9	2.0	2.1	2.2
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2.2	2.4	2.4	2.5	2.3	2.4
Мэдээлэл, холбоо	2.0	2.1	2.0	2.1	2.2	2.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2.4	2.6	2.4	2.5	2.3	2.4
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.0	1.1	1.2	1.2	1.2	1.3
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	5.2	5.5	5.5	5.7	5.7	6.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	3.5	3.8	3.3	3.5	3.6	3.8
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1.6	1.7	1.6	1.7	1.6	1.7
Боловсрол	4.5	4.8	4.6	4.8	4.6	4.9

Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2.7	2.9	2.8	2.9	2.8	2.9
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1.2	1.3	1.2	1.3	1.2	1.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	9.3	9.8	9.0	9.4	10.5	11.0
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа; өрхи	-	-	-	-	-	-
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийт	94.4	100	96.0	100	95.2	100

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ыг /2021 оны III улирал/ эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар нь авч үзвэл 38.6 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 11.0 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт, 7.8 хувь нь барилга, 6.2 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 6.0 хувь нь мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарт, 4.9 хувь нь боловсролын салбарт үйл ажиллагаа явуулж байна.

Хэдийгээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын тоо болон ажиллагчдын тоо 2020 оны эцсээр өссөн дүнтэй байсан ч, 2021 оны III улирлын байдлаар дээрх 2 үзүүлэлт буурсан байна. Тухайлбал 2020 оны байдлаар аж ахуй нэгжийн тоо 1.7 хувиар, ажиллагчдын тоо 1.5 хувиар өссөн бол 2021 оны III улирлаар ажил олгогчид 0.8 хувь, ажиллагчид 2.3 хувиар буурчээ.

Хүснэгт 3. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2019		2020		2021-III	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	290.2	25.3	276.5	23.8	282.3	24.9
Уул уурхай, олборлолт	57.9	5.1	51.6	4.4	57.8	5.1
Боловсруулах үйлдвэрлэл	90.4	7.9	89.7	7.7	82.7	7.3
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	19.3	1.7	14.4	1.2	19.9	1.8
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	10.8	0.9	8.3	0.7	6.1	0.5
Барилга	68.8	6.0	77.3	6.6	93.7	8.3
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	160.4	14.0	166.6	14.3	148.5	13.1
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	61.1	5.3	66.5	5.7	58.1	5.1
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	36.3	3.2	30.0	2.6	37.5	3.3
Мэдээлэл, холбоо	13.0	1.1	18.8	1.6	16.2	1.4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	24.3	2.1	29.4	2.5	27.8	2.4
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.2	0.1	3.4	0.3	2.5	0.2
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	18.0	1.6	11.6	1.0	13.9	1.2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	20.2	1.8	18.1	1.6	18.8	1.7

Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	86.0	7.5	83.4	7.2	87.2	7.7
Боловсрол	96.1	8.4	110.7	9.5	98.5	8.7
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	44.4	3.9	60.2	5.2	50.1	4.4
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	18.0	1.6	10.8	0.9	6.5	0.6
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	24.5	2.1	29.8	2.6	25.1	2.2
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	3.3	0.3	3.3	0.3	2.6	0.2
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	2.0	0.2	2.6	0.2	0.0	0.0
Нийт	1,146.2	100	1,162.9	100	1,135.9	100

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, уул уурхай, олборлолт, цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж, барилга, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбаруудад ажиллагчдын тоо буурахад голлон нөлөөлжээ.

## 1.2. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН

2021 онд ХХҮЕГ-т 18.6 мянган ажилгүй иргэн бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар өсчээ.

Байршлаар авч үзвэл 28.5 хувь нь Улаанбаатар хотод, 25.0 хувь нь Хангайн, 19.0 хувь нь Баруун, 16.3 хувь нь Төвийн, 11.3 хувь нь Зүүн бүсэд харьяалагдаж байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр үзвэл 0.9 хувь нь магистр, доктор, 24.8 хувь нь дипломын болон бакалаврын дээд, 10.9 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 53.7 хувь нь бүрэн дунд, үлдсэн 9.7 хувь нь суурь болон түүнээс доош боловсролтой иргэд байна.


Хүснэгт 4. Бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, бүсээр, 2021 он

Байршил	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр, доктор	Нийт
Баруун	0.1	0.1	0.3	1.7	0.3	0.2	1.0	0.0	3.5
Хангай	0.0	0.1	0.4	2.5	0.3	0.2	1.1	0.0	4.7
Төв	0.0	0.0	0.2	1.5	0.2	0.2	0.8	0.0	3.0
Зүүн	0.1	0.1	0.1	1.2	0.2	0.1	0.4	0.0	2.1
Улаанбаатар	0.1	0.0	0.2	3.1	0.2	0.2	1.4	0.1	5.3
Нийт	0.3	0.4	1.2	10.0	1.2	0.9	4.6	0.2	18.6

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны бүлгээр авч үзэхэд 17.0 хувь нь 15-24, 37.2 хувь нь буюу хамгийн их нь 25-34, 25.8 хувь нь 35-44, 4.6 хувь нь 55-аас дээш насныхан байна.

Зураг 4. Бүртгэлтэй ажилгүй иргэн, насны бүлэг, хувиар



Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар


Улаанбаатар хот болон Баруун бүс, Төвийн бүсийн бүртгэлтэй ажилгүй иргэдийн 36-аас дээш хувь нь 25-34 насныхан бол Зүүн бүсийн хувьд 28.3 хувийг бүрдүүлж байна.

### 1.3. АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, АЖИЛД ЗУУЧЛАЛ

ХХҮЕГ-аас гаргадаг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ болон хувийн хөдөлмөрийн биржүүдийн 2021 оны ажлын байрны захиалгын мэдээгээр 51.0 мянган ажлын байр нээлттэй зарлагдсан нь өмнөх оны мөн үеэс 12.1 хувиар буурч, сүүлийн жилүүдэд хамаарах хамгийн бага үзүүлэлт болж байна.

#### Ажлын байрны захиалга

Зураг 5. Ажлын байрны захиалга, бүсээр, мянган хүнээр, 2015-2021 он



Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Ажлын байрны захиалга Хангайн бүсэд 13.5 хувь, Төвийн бүсэд 13.0 хувь, Зүүн бүсэд 1.2 хувиар буурсан бол Баруун бүсэд энэ үзүүлэлт 22.7 хувь байгаа нь өндөр үзүүлэлт болж байна.



Нийт ажлын байрны захиалгын 30.1 хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын ажлын байр, 14.0 хувийг барилга, 7.9 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 7.3 хувийг ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын ажлын байрны захиалга эзэлжээ.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын хувьд санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, үйлчилгээний бусад үйл ажиллагаа, урлаг, үзвэр, тоглоом наадам, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, боловсрол, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, цахилгаан, хий, агааржуулалт, ус хангамжийн салбаруудаас бусад салбарын ажлын байрны захиалга өссөн байна.

Хүснэгт 5. Ажлын байрны захиалга, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2015-2021 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2015	2017	2018	2019	2020	2021
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	5.7	4.3	4.7	4.4	4.4	3.7
Уул уурхай, олборлолт	5.5	5.3	5.3	9.7	3.1	3.6
Боловсруулах үйлдвэрлэл	7.8	5.8	6.1	6.0	2.6	4.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.9	0.5	0.6	0.6	0.3	0.3
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.7	1.0	0.6	0.8	0.6	0.5
Барилга	13.4	4.4	6.9	6.9	7.0	7.1
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	4.2	2.5	2.4	3.4	1.6	2.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.6	0.7	0.8	0.8	1.0	0.8
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2.1	1.2	2.0	1.4	1.1	1.1
Мэдээлэл, холбоо	0.3	0.2	0.5	0.6	0.1	0.2
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0.7	0.6	1.0	1.2	0.4	0.4
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.1	0.1	0.0	0.0	0.0	0.0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0.1	0.1	0.1	0.1	0.0	0.1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.5	1.6	1.8	1.5	2.6	2.8
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2.4	2.8	1.3	1.9	3.3	1.8
Боловсрол	3.5	3.9	3.7	4.0	3.8	2.9
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1.6	1.9	3.6	2.0	1.6	3.0
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.4	0.4	0.5	0.4	0.6	0.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	25.2	24.1	21.9	24.8	23.3	15.4
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.8	1.2	0.5	0.6	0.5	0.6
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.1	0.1	0.1	0.3	0.0	0.1
Нийт	77.7	62.6	64.5	71.1	58.0	51.0

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Тухайлбал, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны ажлын байрны захиалга 87.0 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 57.9 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар

үйлчилгээний салбарын ажлын байрны захиалга 36.0 хувиар өссөн бол мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарын хувьд энэ үзүүлэлт хамгийн өндөр хувьтай байна.

Ажилмэргэжлийн ангиллынхувьд “Энгийнажилмэргэжил”, “Мэргэжилтэн”, “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан” “Худалдаа, үйлчилгээний ажилтан” бүлгийн ажил мэргэжлийн захиалга нийт захиалгад голлох жинтэй буюу нийт захиалгын 66.3 хувийг эзэлж байна. “Менежер”, “Контор, үйлчилгээний ажилтан”, “Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч”, “Техникч болон туслах /дэд мэргэжилтэн”-ээс бусад бүлгийн ажил мэргэжлийн ажлын байрны захиалга өнгөрсөн оны мөн үеэс буурчээ.

Зураг 6. Ажлын байрны захиалга, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр, мянган хүн



Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

### Ажилд зуучлал

Дээрх ажлын байрны захиалгын дагуу 2021 оны жилийн эцсийн байдлаар 29.9 мянган ажилгүй иргэн ажилд зуучлагдан орсон нь өнгөрсөн оны мөн үеэс 9.4 хувиар буурсан үзүүлэлт юм. 2021 оны ажилд зуучлагдсан нийт иргэдийн 37.9 хувь нь (11.3 мянга) Улаанбаатар хотод, 19.0 хувь нь (5.7 мянга) Хангайн бүсэд, 18.5 хувь нь (5.5 мянга) Төвийн, 14.8 хувь нь (4.4 мянга) Баруун, 9.9 хувь нь (3.0 мянга) Зүүн бүсэд харьяалагдаж байна.

Хүснэгт 6. Ажилд зуучлагдсан иргэд, бүсээр, мянган хүн, 2015-2021 он

Бүс	2015	2017	2018	2019	2020	2021
Баруун	6.0	6.5	5.6	5.7	4.5	4.4
Хангай	9.1	10.1	8.3	8.2	6.8	5.7
Төв	7.5	6.6	6.6	7.1	6.2	5.5
Зүүн	4.1	4.4	4.2	4.3	3.2	3.0
Улаанбаатар	23.0	18.0	18.4	18.7	12.3	11.3
Улсын дүн	49.7	45.7	43.1	44.1	33.0	29.9

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Ажлын байранд зуучлагдсан иргэдийн 27.2 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 10.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, 9.3 хувь нь ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 7.3 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 7.0 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт харьяалагдаж байгаа нь 60.9 хувийг эзэлж байна.

ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, барилга, боловсрол, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарас бусад салбарт зуучлагдсан иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс өссөн үр дүнтэй байна.

Дээрхээс бусад салбаруудад зуучлалын үйлчилгээ буурсан бөгөөд Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын зуучлал 39.1 хувь, боловсролын салбарын зуучлал 31.3 хувиар буурсан нь хамгийн өндөр хувийн бууралтыг харуулж байна.


Хүснэгт 7. Ажилд зуучлагдсан иргэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн, 2015-2021 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажилд зуучлагдсан иргэн					
	2015	2017	2018	2019	2020	2021
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур,	4.6	3.5	3.4	3.1	3.4	2.8
Уул уурхай, олборлолт	3.1	4	3.6	4.9	1.7	2.1
Боловсруулах үйлдвэрлэл	5.7	3.6	4.9	4.7	1.8	2.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.5	0.4	0.4	0.4	0.2	0.3
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.6	0.7	0.4	0.7	0.4	0.3
Барилга	6.8	2.8	3.6	4.1	3.6	3.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	3	2	2.8	2.7	1.0	1.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.1	0.6	0.5	0.5	0.5	0.4
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1.5	1	0.7	1.1	0.3	0.5
Мэдээлэл, холбоо	0.2	0.1	0.2	0.2	0.1	0.1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0.6	0.5	0.8	0.4	0.3	0.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0	0.1	0	0	0.0	0.0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0.1	0	0.1	0.1	0.0	0.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.5	1.4	1.5	1.4	2.3	2.2
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2	2.4	1.1	1.3	1.9	1.4
Боловсрол	2.9	3.4	2.9	3.3	3.1	2.2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1.2	1.6	1.2	1.5	1.0	1.9
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.3	0.3	0.3	0.5	0.2	0.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	14.2	16.5	14.2	12.3	10.6	8.1
Хүн хөлсөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.7	0.6	0.3	0.5	0.4	0.4
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.1	0.1	0	0.3	0.0	0.0
Нийт	49.7	45.7	43.1	44.1	33.0	29.9

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Ажилд зуучлагдсан иргэдийг ажил мэргэжлийн хувьд авч үзвэл 22.6 хувь нь “Мэргэжилтэн”, 19.4 хувь нь “Энгийн ажил мэргэжил”, 14.0 хувь нь “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан”, 11.5 хувь нь “Худалдаа, үйлчилгээний ажилтан” бүлгийн ажил мэргэжлийн ажлын байранд зуучлагдсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Техникч болон туслах, дэд мэргэжилтэн”, “Менежер”, “Зэвсэгт хүчний ажил, мэргэжил” зэргээс бусад бүлгийн ажил мэргэжлийн чиглэлээр зуучлагдсан иргэний тоо буурчээ.

Зураг 7. Ажилд зуучлагдсан иргэд, ажил мэргэжлийн үндсэн ангиллаар, мянган хүн.



Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Харин менежер чиглэлийн ажил мэргэжлээр зуучлагдсан иргэний тоо өнгөрсөн оны мөн үеэс 36.1 хувиар, техникч болон туслах, дэд мэргэжилтэнээр зуучлагдсан иргэний тоо 9.1 хувиар өссөн байна.

#### 1.4. МОНГОЛ УЛСАД ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БУЙ ГАДААД ИРГЭД

Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн хүрээнд Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэд хөдөлмөрийн зах зээл дэх ажиллагчдын тодорхой хувийг бүрдүүлдэг. Тухайлбал, 2017 онд 16.5 мянга, 2018 онд 10.7 мянга, 2019 онд 10.7 мянга, 2020 онд 4.0 мянган гадаад ажиллах хүч манай улсад хөдөлмөр эрхэлсэн бөгөөд 2021 оны эцэст 5.6 мянга болж өнгөрсөн оныхоос өссөн байна.


Манай улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж буй гадаад ажиллагчдын тоо сүүлийн 5 жилд төдийлөн өөрчлөгдөлгүй 10.0 мянга орчимд хэлбэлзэж байсан ч эдийн засгийн үйл ажиллагааны салбар хооронд нэлээд ялгаатай байдаг. Тухайлбал 2018 онд нийт гадаад ажиллах хүчний 3.5 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт ажиллаж байсан бол 2019 онд 26.9 хувь болж өссөн. Харин боловсруулах үйлдвэрлэлийн салбарын гадаад ажиллах хүчний эзлэх хувь 2018 онд 20.3 хувь, 2019 онд 9.2 хувь болж 11.1 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Хэдийгээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад гадаад ажиллагчдын тоо өссөн ч ЭЗҮА-ны салбараар үзвэл ихэнхэд нь буурчээ. Тухайлбал, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 10.9 пункт, боловсролын салбарт 6.3 пунктээр буурсан нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Харин барилгын салбарын хувьд энэ үзүүлэлт 16.5 пунктээр, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын хувьд 3.4 хувиар өссөн байна.

2021 оны эцэст идэвхтэй байгаа хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй гадаадын иргэдийн 36.1 хувь нь уул уурхай, олборлолтын, 28.5 хувь нь барилга, 8.8 хувь

нь боловсролын салбарт, 6.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 6.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, үлдсэн хувь нь бусад салбарт ажиллаж байна.

Зураг 8. Гадаад ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар /хувь/



Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны жилийн эцсийн байдлаарх хөдөлмөр эрхэлж буй гадаад ажиллагчдыг ажил мэргэжлийн ангиллын хувьд авч үзвэл мэргэжилтэн 44.8 хувь, техникч болон туслах/дэд мэргэжилтэн 19.6 хувь, үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан 11.3 хувь, менежер 10.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт 8. 2021 онд хөдөлмөр эрхэлж буй гадаад ажиллагчдын хувь, ажил мэргэжлийн үндсэн бүлгээр

	Ажил мэргэжлийн үндсэн бүлэг	Дүнд эзлэх хувь
1	Менежер	10.5
2	Мэргэжилтэн	44.8
3	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	19.6
4	Контор, үйлчилгээний ажилтан	0.9
5	Худалдаа, үйлчилгээний ажилтан	0.6
6	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	0.0
7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	11.3
8	Төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	9.2
9	Энгийн ажил, мэргэжил	3.0
10	Зэвсгэт хүчний ажил, мэргэжил	0.0

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж буй гадаад ажиллагчдын 88.9 хувь нь хязгаарлагдмал хариуцлагатай компанид, 5.9 хувь нь төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газарт ажиллаж байна.

Хүснэгт 9. Гадаад ажиллагчдын эзлэх хувь, байгууллагын өмчийн хэлбэрээр

	Өмчийн хэлбэр	Дүнд эзлэх хувь
	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	88.9
	Төсөвт байгууллага	0.2
	Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	5.9
	Төрийн бус байгууллага	2.9
	Хувьцаат компани	0.2
	Нөхөрлөл	0
	Бусад	1.8

# II БҮЛЭГ

## СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН


## 2.1. АЖИЛ ОЛГОГЧИД, АЖИЛЛАГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

### 2.1.1. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллага

Энэ удаагийн “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа”-нд Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн, ЭЗҮА-ны 18 салбарын 2923 аж ахуйн нэгж, байгууллагыг хамрууллаа.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын 64.3 хувь нь буюу 1880 нь Улаанбаатар хотын, үлдсэн 35.7 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ААНБ байна.

Зураг 9. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын тоо, аймгаар



Судалгаанд хамрагдсан ААНБ-ын 74.7 хувь нь байнгын үйл ажиллагаа явуулдаг бол 14.9 хувь нь улирлын чанартай, үлдсэн хувь нь үйл ажиллагаа нь тогтмол бус ААНБ байна.

Хүснэгт 10. Судалгаанд хамрагдсан ААНБ-ын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар, үйл ажиллагааны хэлбэрээр

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Нийт	Үйл ажиллагааны хэлбэр		
		Байнгын	Улирлын	Тогтмол биш
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	65	14	40	11
Уул уурхай, олборлолт	70	32	28	10
Боловсруулах үйлдвэрлэл	235	155	52	28
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	41	25	15	1
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	27	25	1	1
Барилга	282	117	134	31
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ	744	572	78	94
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	120	88	22	10
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	93	72	8	13
Мэдээлэл, холбоо	52	41	1	10
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	60	57	1	2

Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	45	39	2	4
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	154	114	30	10
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	103	74	6	23
Боловсрол	450	425	12	13
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	183	175	1	7
Урлаг, үзвэр, тоглоом наадам	49	44	1	4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	150	114	4	32
Нийт	2923	2183	436	304

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын хувьд ихэнх салбарын ААНБ-уудын 60-аас дээш хувь нь байнгын үйл ажиллагаа явуулдаг бол зарим салбарын онцлогоос шалтгаалан тухайн салбарт хамаарах үйл ажиллагаа эрхэлж буй ихэнх ААНБ-ууд улирлын чанартай үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал уул уурхай, олборлолтын салбарын ААНБ-уудын 40.0 хувь, барилгын салбарын 47.5 хувь, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын аж ахуйн нэгжүүдийн 61.5 хувийг улирлын чанартай үйл ажиллагааны хэлбэртэй аж ахуйн нэгжүүд эзэлж байв.

Зураг 10. Судалгаанд хамрагдсан ААНБ-ын хувь, үйл ажиллагааны хэлбэр, байршилаар



Судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүдийн 73.0 хувь, Хангайн бүсийн 78.9 хувь, Баруун бүсийн ААНБ-ын 76.7 хувь нь, Төвийн бүсийн ААНБ-ын 75.6 хувийг байнгын үйл ажиллагаатай аж ахуйн нэгжүүд эзэлж байгаа бол Зүүн бүсийн хувьд энэ үзүүлэлт хамгийн өндөр буюу судалгаанд оролцсон ААНБ-ын 82.8 хувь нь байнгын ажиллагаатай ажил олгогчид байна.

Ажиллагчдын тооны хувьд судалгаанд оролцсон ААНБ-ын 71.9 хувь нь 50 хүртэлх ажиллагчидтай бол 17.8 хувь нь 50-149 хүртэлх, 10.3 хувь нь 150-аас дээш ажиллагчидтай байв. 150-аас дээш ажилтантай буюу томоохон ААНБ-уудын хувьд энэ жилийн судалгаанд хамрагдалтын түвшин өнгөрсөн оноос өссөн ч удаан хугацаагаар үргэлжилж буй цар тахлын нөхцөл байдлын улмаас үйл ажиллагаагаа зогсоосон, судалгаанд оролцохоос татгалзсан тохиолдлууд их тохиолдож байсан.



Зураг 11. Судалгаанд хамрагдсан ААНБ-ын хувь, өмчийн хэлбэр, байршилаар



Судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын ААНБ-ын 81.9 хувь нь хувийн өмчийн, 3.4 хувь нь гадаад улсын буюу гадаадын хөрөнгө оруулалттай, 12.1 хувь нь төрийн өмчийн аж ахуйн нэгж байна. Орон нутгийн хувьд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувь Улаанбаатар хоттой харьцуулахад бага, эсрэгээрээ төрийн өмчийн ААНБ-ын эзлэх хувь илүү өндөр 30.0-446.3 хувийг бүрдүүлж байна. Харин хувийн өмчийн байгууллагуудын эзлэх хувь өндөр буюу Төвийн бүсийн 64.4 хувь, Хангайн бүсийн 54.5 хувь, Баруун бүсийн ААНБ-ын 55.3 хувь, Зүүн бүсийн 49.2 хувь хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд байна.

### 2.1.2. Ажиллагчдын бүтэц

#### Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Судалгааны мэдээлэл цуглуулалтын үе дэх ажиллагчдын тоо өнгөрсөн оны мөн үеэс 9.7 хувиар буурсан буюу сүүлийн 12 сарын хугацаан дахь хөдөлмөр эрхлэлт буурсан үзүүлэлттэй байна. Хэдийгээр нийт хөдөлмөр эрхлэлт буурсан ч салбарын хувьд авч үзвэл харилцан адилгүй байна. Тухайлбал Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын хөдөлмөр эрхлэлт өнгөрсөн оны мөн үеийнхээс 21.4 хувиар, барилгын салбар 9.8 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 9.3 хувиар, Мэдээлэл, холбооны салбар 5.4 хувь, Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбар 5.2 хувь, Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар 5.0 хувиар агшилт үүссэн. Үүнээс гадна ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар, Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ, Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбаруудад хөдөлмөр эрхлэлт бага хэмжээгээр буурсан бөгөөд боловсролын салбарт 0.1 хувийг эзэлж буй нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

Тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын хувьд энэ өөрчлөлт 51.6 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Энэ нь цар тахлын улмаас үүдэлтэй нөхцөл байдлын улмаас хот болон улс хоорондын ачаа тээврийн үйлчилгээ, үйл ажиллагаа доголдсонтой шууд холбоотой юм.

Хүснэгт 11. Хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт, мян. хүн

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Өнгөрсөн оны ажиллагчдын тоо	Энэ оны ажиллагчдын тоо	Ажиллагчдын тооны өөрчлөлт	
			Тоо	Хувь
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	10.4	9.9	-0.5	-4.7
Уул уурхай, олборлолт	26.6	27.6	0.9	3.5
Боловсруулах үйлдвэрлэл	52.6	47.7	-4.9	-9.3
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	14.3	14.5	0.1	1.0
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	10.0	7.9	-2.1	-21.4
Барилга	52.7	47.5	-5.2	-9.8
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ	124.6	121.0	-3.5	-2.8
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	88.9	43.0	-45.9	-51.6
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	21.0	20.0	-1.0	-5.0
Мэдээлэл, холбоо	13.1	12.4	-0.7	-5.4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	18.3	18.2	-0.2	-1.0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	8.1	7.9	-0.2	-1.9
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	28.2	27.2	-1.1	-3.7
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	17.3	16.4	-0.9	-5.2
Боловсрол	106.2	106.0	-0.1	-0.1
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	45.7	45.9	0.3	0.6
Урлаг, үзвэр, тоглоом наадам	9.9	10.0	0.1	1.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	26.4	25.6	-0.8	-3.1
Нийт	674.3	608.6	-65.7	-9.7

Харин эсрэгээрээ хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн хэдэн салбар байгаа нь Уул уурхай, олборлолтын салбарт өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.5 хувь, Урлаг, үзвэр, тоглоом наадам салбар 1.1 хувь, Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбар 1.0 хувь, Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын хөдөлмөр эрхлэлт 0.6 хувиар тус тус өссөн.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар харвал ажиллагчдын 19.9 хувь /121.0 мянга/ нь Бөөний болон жижиглэн худалдаа, 17.4 хувь /106.0 мянга / нь Боловсрол, 7.8 хувь /47.5 мянга/ нь Барилга, 7.8 хувь /47.7 мянга/ нь Боловсруулах үйлдвэрлэл, 7.5 хувь /45.9 мянга/ нь Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт тус тус харьяалагдаж байна.

Хүснэгт 12. Судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажиллагчдын тоо		
	Нийт	Байнгын	Түр
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	9.9	8.0	1.9
Уул уурхай, олборлолт	27.6	24.6	3.0
Боловсруулах үйлдвэрлэл	47.7	43.5	4.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	14.5	14.2	0.3
Ус хангамж сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	7.9	7.7	0.2
Барилга	47.5	38.8	8.7
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	121.0	109.8	11.2
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	43.0	40.4	2.5
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	20.0	18.7	1.2
Мэдээлэл, холбоо	12.4	11.6	0.8
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	18.2	16.6	1.5
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	7.9	7.7	0.2
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	27.2	24.1	3.1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	16.4	15.0	1.4
Боловсрол	106.0	103.8	2.2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	45.9	43.9	2.0
Урлаг, үзвэр, тоглоом наадам	10.0	9.1	0.9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	25.6	23.8	1.7
Нийт	608.6	561.4	47.3

### Байршил, ажлын байрны хэлбэр, хүйсээр


Бүс нутгийн хувьд Зүүн бүсэд хөдөлмөр эрхлэлт бага зэрэг өссөн бол бусад бүсүүдэд буурсан дүр зурагтай байна. Тухайлбал Зүүн бүсэд 0.5 хувиар өсч, Улаанбаатар хотод 12.9 хувь, Төвийн бүсэд 4.7 хувь, Баруун бүсэд 3.4 хувь, Хангай бүсэд 1.5 хувиар буурчээ.

Байгууллагын өмчийн хэлбэрийн хувьд төрийн өмчийн байгууллагууд, гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ-д хөдөлмөр эрхлэлт өссөн бол хувийн өмчийн ААНБ-д 15.1 хувиар хөдөлмөр эрхлэлт буурсан төлөвтэй байна.

Ажиллагчдын 92.2 хувь нь байнгын ажлын байранд, 7.8 хувь нь түр ажлын байранд ажиллаж байгаа нь байнгын ажлын байрны эзлэх хувь өмнөх оны судалгааны дүнгээс 6.3 пунктээр өсөж мөн хэмжээгээр түр ажлын байрны эзлэх хувь буурсан үзүүлэлттэй байна.

Нийт ажиллагчдын 51.9 хувь, байнгын ажиллагчдын 53.1 хувь нь эмэгтэй, түр ажиллагчдын 61.9 хувь нь эрэгтэйчүүд байна.

Зураг 12. Ажиллагчдын эзлэх хувь, ажлын байрны хэлбэр, хүйсээр



### Боловсролын түвшнээр

Ажиллагчдыг боловсролын түвшнээр харвал байнгын ажиллагчдын 57.0 хувь нь бакалавр болон түүнээс дээш, 21.7 хувь нь бүрэн дунд боловсролтой байна. Бага боловсролтой болон боловсролгүй ажилтны тоо хамгийн цөөн буюу 3.2 мянга байгаа нь нийт байнгын ажилтны 0.6 хувийг эзэлж байна.

Бакалаврын болон түүнээс дээш боловсролтой байнгын ажиллагчдын 60.7 хувь нь эмэгтэйчүүд бол бүрэн дунд боловсролтой ажиллагчдын 44.3 хувь нь эрэгтэйчүүд байна.

Зураг 13. Байнгын болон түр ажиллагчдын боловсролын түвшин, хувь



Түр ажиллагчдын 41.9 хувь нь буюу 19.8 мянга нь бүрэн дунд боловсролтой байгаагийн 32.0 хувийг эрчүүд эзэлж байна. Харин 12.9 хувь буюу 6.1 мянга нь техник мэргэжлийн дунд, 23.8 хувь буюу 11.2 мянга нь бакалавр зэрэгтэй, 11.9 хувь буюу 5.6 мянга нь техникийн болон мэргэжлийн түвшний боловсролтой байна. Үлдсэн 6.7 хувь нь бүрэн дундаас доош түвшний боловсролтой, эсвэл боловсролгүй ажиллагчид байна.

### Ажил мэргэжлийн чиглэлээр

Байнгын ажиллагчдын 19.5 хувь буюу 109.7 мянга нь “Менежер”, 29.1 хувь буюу 163.6 мянга нь “Мэргэжилтэн”, 10.4 хувь буюу 58.3 мянга нь “Худалдаа, үйлчилгээний ажилтан”, 11.0 хувь буюу 61.5 мянга нь “Энгийн ажил мэргэжил” ажил мэргэжлийн бүлэгт хамаарч байна. Харин түр ажиллагчдын 10.6 мянга (22.4 хувь) нь “Энгийн ажил мэргэжил”, 6.8 мянга (14.4 хувь) нь

“Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан”, 6.4 мянга нь (13.6 хувь) нь “Худалдаа, үйлчилгээний ажилтан”, 6.0 мянга (12.6 хувь) нь “Мэргэжилтэн”, 5.0 мянга (10.5 хувь) нь “Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч” бүлэгт хамаарах ажил мэргэжилтэй байна.

Хүснэгт 13. Ажиллагчид, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр, хувь

Үндсэн бүлгийн дугаар	Ажил мэргэжлийн ангилал	Байнгын ажиллагчид		Түр ажиллагчид	
		Нийт	Үүнээс: эмэгтэй	Нийт	Үүнээс: эмэгтэй
1	Менежер	19.5	18.6	7.6	10.4
2	Мэргэжилтэн	29.1	37.5	12.6	18.4
3	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	8.0	8.5	8.6	10.9
4	Контор үйлчилгээний ажилтан	6.6	7.0	7.4	7.7
5	Худалдаа, үйлчилгээний ажилтан	10.4	12.6	13.6	20.3
6	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	0.3	0.1	2.8	1.6
7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	6.7	3.5	14.4	10.8
8	Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	8.5	16.0	10.5	1.3
9	Энгийн ажил мэргэжил	11.0	10.3	22.4	18.6

Ажил мэргэжлийг “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт”-ын 4 оронтой нэгж бүлгийн дагуу авч үзсэн бөгөөд байнгын ажиллагчдын 9.6 хувийг “Захирал, гүйцэтгэх захирал”, 5.1 хувь нь дунд боловсрол олгох багш, 3.5 хувь нь “Нягтлан бодогч”, 2.9 хувь нь “Энгийн ажил, мэргэжил”, 2.8 хувь нь “Хүнд даацын машин, том тэрэгний жолооч”, 2.0 хувь нь “Конторын бусад туслах ажилтан”, 1.6 хувийг тус бүр “Иргэний барилга байгууламжийн инженер”, “Сургуулийн өмнөх боловсрол олгох багш, сурган хүмүүжүүлэгч” гэсэн ажил мэргэжлийн ажиллах хүчин эзэлж байсан.

Түр ажиллагчдын хувьд “Иргэний барилгын туслах ажилтан”, “Хүнд даацын машин, том тэрэгний жолооч”, “Барилга угсралтын туслах ажилтан”, “Зочид буудал, албан контор, бусад байгууллагын цэвэрлэгч”, “Дэлгүүрийн худалдааны туслах ажилтан”, “Шаварчин, засалчин” гэх ажил мэргэжлийн бүлгийн ажиллагчид нийт дүнд эзлэх хувь хамгийн өндөр буюу 30.5 хувийг бүрдүүлж байв.

Ажиллагчдын ажил мэргэжлийн чиглэлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харвал байнгын ажиллагчдын хувьд салбарын онцлогоос шалтгаалан харилцан адилгүй бүтэцтэй байна. Тухайлбал, хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний эрэлтэд голлон нөлөөлөх барилгын салбарын байнгын ажиллагчдын 25.5 хувийг “Мэргэжилтэн”, 21.5 хувийг “Менежер”, 16.3 хувийг “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан”, 12.0 хувийг “Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч”, 6.9 хувийг “Техникч болон туслах, дэд мэргэжилтэн”, 10.5 хувийг энгийн ажил мэргэжлийн ажиллагчид эзэлж байгаа нь тус салбарын байнгын ажиллагчдын 92.7 хувийг бүрдүүлж байна. Бөөний болон жижиглэн худалдааны салбарын хувьд байнгын ажиллагчдын 35.0 хувийг “Менежер”, 20.2 хувийг “Худалдаа,

үйлчилгээний ажилтан”, 14.7 хувийг “Мэргэжилтэн” бүлгийн ажиллагчид эзэлж байна. Боловсруулах үйлдвэрлэлийн хувьд “Менежер”, “Мэргэжилтэн”, “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан”, “Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч” гэсэн үндсэн бүлгийн ажиллагчид 60.1 хувийг бүрдүүлж, 18.1 хувийг энгийн ажил мэргэжлийн ажиллагчид эзэлж байна.

Харин тэвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын байнгын ажиллагчдын 42.9 хувийг “Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч” бүлгийн ажиллагчид бүрдүүлж буй бол боловсрол, мэдээлэл, холбоо, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбар, урлаг, үзвэр, тоглоом наадам, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын байнгын ажиллагчдын 40.0-60.0 хувийг тус бүр “Мэргэжилтэн” бүлэгт хамаарах ажил мэргэжлийн ажиллагчид дангаараа бүрдүүлж байна.

Хүснэгт 14. Байнгын ажиллагчид, салбар, ажил мэргэжлийн үндсэн бүлгээр, хувь

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлэг								
	Менежер	Мэргэжилтэн	Техникч болон туслах / дэд мэргэжилтэн	Контор үйлчилгээний ажилтан	Худалдаа, үйлчилгээний ажилтан	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	Энгийн ажил мэргэжил
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	31.2	13.4	5.4	3.1	6.6	11.1	12.1	5.7	11.4
Уул уурхай, олборлолт	12.3	18.7	5.5	4.5	3.4	0.1	12.1	28.6	14.8
Боловсруулах үйлдвэрлэл	19.4	11.5	6.5	12.0	3.3	0.0	15.5	13.7	18.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	4.7	15.0	21.3	7.6	2.3	0.1	22.4	6.3	20.4
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	4.5	13.2	10.5	3.0	2.4	1.2	13.0	14.6	37.7
Барилга	21.5	25.5	6.9	4.2	3.0	0.0	16.3	12.0	10.5
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	35.0	14.7	5.5	4.7	20.2	0.2	6.0	5.1	8.6
Тэвэр, агуулахын үйл ажиллагаа	9.0	12.6	11.1	14.3	3.7	0.0	2.1	42.9	4.3
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	20.5	9.0	12.9	2.9	31.2	0.1	7.9	0.9	14.7
Мэдээлэл, холбоо	32.3	39.6	10.7	5.3	2.2	0.0	2.9	3.2	3.8

Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	36.2	25.8	13.6	17.8	1.3	0.0	0.3	2.2	2.7
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	25.6	15.0	12.6	11.8	10.7	0.1	8.3	1.1	14.8
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	22.6	48.3	9.3	6.5	3.1	0.2	3.6	3.3	3.2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	31.3	17.8	4.5	6.3	21.7	0.0	4.7	6.0	7.7
Боловсрол	5.9	58.8	3.9	4.3	10.7	0.0	2.1	0.3	14.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	8.6	50.0	14.9	2.8	12.7	0.0	1.6	2.2	7.1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	13.7	46.6	6.2	8.5	9.7	0.0	2.7	1.2	11.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	31.6	22.2	8.2	10.9	6.2	0.8	6.5	2.3	11.4
Нийт	19.5	29.1	8.0	6.6	10.4	0.3	6.7	8.5	11.0

Дээрх үзүүлэлтийг түр ажиллагчдын хувьд авч үзвэл барилгын салбарын түр ажиллагчдын 72.1 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 56.2 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын 68.0 хувийг “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан” болон энгийн ажил мэргэжлийн ажиллагчид бүрдүүлж байна.

Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарын түр ажиллагчдын 51.1 хувь, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээны салбарын 78.3 хувийг “Худалдаа, үйлчилгээний ажилтан” болон энгийн ажил мэргэжлийн ажиллагчид байгаа бол ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын хувьд 70.6 хувийг “Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан” болон энгийн ажил, мэргэжлийн ажиллагчид бүрдүүлж байна.

Харин тэвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын түр ажиллагчдын 62.4 хувь, уул уурхай, олборлолтын салбарын 38.3 хувийг “Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч” бүлэгт хамаарах мэргэжлийн ажиллагчид дангаараа бүрдүүлж байна.

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа болон мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарын түр ажиллагчдын 30.0-40.0 хувийг тус бүр “Техникч болон туслах, дэд мэргэжилтэн” бүлэгт хамаарах мэргэжлийн ажиллагчид эзэлж буй бол боловсролын салбарын 58.5 хувь, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын 43.2 хувь нь “Мэргэжилтэн” бүлгийн ажил мэргэжлийн түр ажиллагчид байна. Мөн мэдээлэл, холбооны салбарын 48.9 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын түр ажиллагчдын 40.7 хувийг “Менежер” бүлэгт хамаарах ажил мэргэжлийн ажиллагчид эзэлж байна.

Хүснэгт 15. Түр ажиллагчид, салбар, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр, хувь

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлэг								
	Менежер	Мэргэжилтэн	Техникч болон туслах / дэд мэргэжилтэн	Контор үйлчилгээний ажилтан	Худалдаа, үйлчилгээний ажилтан	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	Суурин төхөөрөмж, машин механизмдын операторч, угсрагч	Энгийн ажил мэргэжил
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.0	2.4	2.2	4.6	5.9	26.8	6.8	7.5	43.8
Уул уурхай, олборлолт	6.2	17.7	7.7	7.9	1.7	0.0	5.9	38.3	14.6
Боловсруулах үйлдвэрлэл	4.0	4.2	1.7	10.8	4.2	15.1	30.1	3.8	26.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.0	4.8	2.5	0.0	3.7	0.0	21.9	21.1	46.0
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	1.6	4.8	32.3	0.0	14.5	0.0	1.6	12.5	32.6
Барилга	2.6	10.6	4.5	2.1	0.9	0.0	35.0	7.2	37.1
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	10.8	3.3	5.4	10.0	28.8	1.4	12.3	5.8	22.4
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	0.0	4.7	20.3	2.2	2.0	0.0	7.9	62.4	0.5
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	0.4	1.8	5.3	1.4	49.0	0.0	12.8	0.0	29.3
Мэдээлэл, холбоо	48.9	28.6	1.3	2.5	0.0	0.0	1.2	0.2	17.2
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	13.0	6.3	9.4	34.4	0.5	0.0	0.0	0.0	36.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	27.8	0.5	8.0	4.6	5.6	0.0	0.0	0.5	53.1
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.1	23.0	39.9	7.2	6.2	0.0	0.0	8.0	14.5
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	19.0	1.9	0.7	19.4	46.3	0.0	0.0	11.7	1.0
Боловсрол	0.4	58.5	5.6	1.2	22.7	0.0	2.0	0.1	9.6
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	5.6	43.2	17.5	7.9	10.1	0.0	2.1	0.3	13.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.0	19.6	0.0	8.7	33.3	0.0	11.2	14.0	13.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	40.7	19.0	9.0	2.0	13.0	0.0	12.5	2.0	1.7
Нийт	7.6	12.6	8.6	7.4	13.6	2.8	14.4	10.5	22.4



Салбар бүрийн түр ажиллагчдын бүтцэд “Энгийн ажил мэргэжил”-ийн чиглэлийн ажиллагчид багагүй хувийг бүрдүүлж байдаг. Тухайлбал, цахилгаан, хий, уур, агааржуулалтын ажиллагааны салбарын түр ажиллагчдын 46.0 хувь, ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын 43.8 хувийг эзэлж буй бөгөөд үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын түр ажиллагчдын 53.1 хувийг энгийн ажил мэргэжлийн ажиллагчид дангаараа бүрдүүлжээ.

### **2.1.3. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн**

Хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчний салбарын дотоод болон салбар хоорондын шилжилт хөдөлгөөн их, үүнээс үүдэлтэй хөдөлмөр эрхлэлтийн тогтворгүй байдал төдийлөн буурахгүй байгаа нь жил бүрийн судалгааны үр дүнгээс харагддаг бөгөөд энэ удаа ч дээрх үзүүлэлт давтагдсан үр дүн харагдлаа. Тухайлбал сүүлийн 12 сарын хугацаанд шинээр ажилтан авсан аж ахуйн нэгжүүдийн тоо 1.1 пунктээр өсч, ажилд орсон иргэдийн хувь өмнөх оны судалгааны дүнгээс 48.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гэвч дотоодын хөдөлмөрийн зах зээл сүүлийн 2 жилийн хугацаан дахь цар тахлаас үүдэлтэй урьдчилан таамаглах боломжгүй нийгмийн болоод эдийн засгийн онцгой нөхцөл байдлаас хамаарч байгааг онцлох хэрэгтэй юм.

### **Сүүлийн 12 сарын хугацаан дахь шинэ ажиллагчид**

Сүүлийн 12 сарын хугацаанд аж ахуйн нэгж байгууллагын 24.7 хувь нь шинэ болон сул ажлын байрандаа ажилтан авч ажиллуулсан бөгөөд эдгээрийн 11.9 хувь нь боловсролын салбарын, 9.0 хувь нь барилга, 8.2 хувь нь хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын аж ахуйн нэгжүүд бол 32.5 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарын ажил олгогчид эзэлж байна.

Ажиллагчдын тооны бүлгээр авч үзвэл шинээр ажилтан авсан нийт ажил олгогчдын 81.4 хувийг 30 хүртэлх ажилтантай жижиг аж ахуйн нэгжүүд эзэлж буй бол 80.2 хувь нь байнгын үйл ажиллагаатай аж ахуйн нэгжүүд байна. Мөн 65.9 хувь нь Улаанбаатар хотод бол 13.1 хувь нь Төвийн бүс, 10.2 хувь нь Хангайн бүсийн аж ахуйн нэгжүүд байна.

Сүүлийн 12 сард 72.3 мянган иргэн шинээр ажилд орсон бөгөөд эдгээр шинэ ажиллагчдын 74.3 хувь нь байнгын ажиллагч бол, 57.7 хувийг сул орон тоог нөхсөн ажиллах хүчин бүрдүүлж байна. Эдгээр ажиллагчдын 44.1 хувь нь эмэгтэйчүүд байжээ.

Сүүлийн 12 сард ажилд орсон нийт ажиллагчдын 12.7 хувь нь барилгын салбарт, 9.8 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 8.5 хувь нь боловсролын салбарт ажилд орсон нь сүүлийн 12 сард шинээр ажилд орсон нийт ажиллагчдын 31.0 хувь болж байна. Харин 24.8 хувь буюу хамгийн өндөр хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарт харьяалагдаж байгаа бөгөөд үүний 72.6 хувь нь байнгын ажлын байр байжээ.

Боловсролын салбарын шинэ ажиллагчдын 90.0 хувь, мэдээлэл, холбооны салбарын 89.4 хувь, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа болон ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын ажиллагчдын тус бүр 86.1

хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын 85.2 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын шинэ ажиллагчдын 84.8 хувь байнгын ажиллагчид эзэлж байгаа бөгөөд бусад ихэнх салбаруудын хувьд шинэ ажиллагчдын 60-аас дээш хувь байнгын ажлын байранд орсон байна.

Улсын хэмжээнд шинэ ажиллагчдын ажлын байранд эзлэх сул ажлын байрны түвшин буюу нэг ажиллагчийг нөгөөгөөр орлуулсан түвшин 57.7 хувь байгааг салбар бүрээр үзвэл үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын шинэ ажиллагчдын 89.4 хувь, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын 85.5 хувь, урлаг, үзвэр, тоглоом наадам салбарын 81.8 хувь, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын шинэ ажиллагчдын 78.1 хувь, боловсролын салбарын 74.7 хувь нь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа салбарын шинэ ажиллагчдын 74.5 хувь, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ салбарын шинэ ажиллагчдын 74.1 хувь нь тус тус сул ажлын байранд ажилд орсон байна.

Хүснэгт 16. Шинэ ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар,

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	Сүүлийн 12 сард ажилд орсон ажиллагчид			
	Нийт ажиллагчдын тоо	Үүнээс: Байнгын ажилтнаар	Үүнээс: Сул ажлын байранд	Орлуулах түвшин
	Тоо	Тоо	Тоо	Хувь
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.5	1.0	0.9	58.8
Уул уурхай, олборлолт	3.9	2.9	2.0	50.5
Боловсруулах үйлдвэрлэл	7.1	5.7	4.1	58.5
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1.1	0.9	0.7	67.6
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.9	0.8	0.8	85.5
Барилга	9.2	4.9	3.0	32.5
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	18.0	13.0	9.3	51.8
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	4.1	3.2	2.1	51.1
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	4.3	2.8	3.2	74.1
Мэдээлэл, холбоо	0.8	0.7	0.4	51.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2.3	2.0	1.8	78.1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.2	1.0	1.1	89.4
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2.4	1.8	1.6	67.5
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2.7	2.0	2.0	74.5
Боловсрол	6.2	5.5	4.6	74.7
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	4.2	3.4	2.3	55.6
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1.1	0.7	0.9	81.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.5	1.3	1.0	64.3
Нийт	72.3	53.7	41.7	57.7

Бусад салбаруудад ч шинэ ажиллагчдын 50-аас дээш хувь нь сул ажлын байранд орсон бол барилгын салбарын хувьд энэ үзүүлэлт 32.5 хувийг эзэлж байна.

Ажил мэргэжлийн үндсэн бүлгээр харвал шинэ ажиллагчдын 23.9 хувь нь мэргэжилтэн, 22.3 хувь нь энгийн ажил мэргэжил, 15.1 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 11.7 суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 10.1 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан зэрэг ажил мэргэжлийн чиглэлд хамаарах ажлын байраар хангагджээ. Эмэгтэй ажиллагчдад эзлэх хувиар харвал эмэгтэйчүүдийн 79.9 хувь нь дээрх 4 чиглэлийн ажил мэргэжлийн ажилд оржээ.

Мэргэжилтэн бүлэгт хамаарах ажил мэргэжлийн чиглэлээр ажилд орсон иргэд нийт ажилд орсон эмэгтэй ажиллагчдын 33.4 хувь, байнгын ажиллагчдын 26.2 хувь, нийт сул ажлын байрны 25.1 хувийг тус тус бүрдүүлж байна. Шинэ ажиллагчдад эзлэх хувиар харвал 81.4 хувь нь байнгын ажлын байр, 60.6 хувь нь сул ажлын байраар хангагджээ.

Хүснэгт 17. Шинэ ажиллагчдын эзлэх хувь, ажил мэргэжлийн үндсэн бүлгээр

Үндсэн бүлгийн дугаар	Ажил мэргэжлийн ангилал	Шинэ ажиллагчид			
		Нийт	Эмэгтэй	Байнгын ажлын байранд ажилд орсон	Сул ажлын байранд ажилд орсон
1	Менежер	4.0	4.5	5.0	4.4
2	Мэргэжилтэн	23.9	33.4	26.2	25.1
3	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	9.2	10.4	9.3	8.7
4	Контор үйлчилгээний ажилтан	3.3	5.2	3.7	3.7
5	Худалдаа, үйлчилгээний ажилтан	15.1	20.8	15.7	17.1
6	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	0.3	0.1	0.4	0.3
7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	10.1	5.7	9.0	9.1
8	Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	11.7	2.0	13.3	10.7
9	Энгийн ажил мэргэжил	22.3	17.9	17.3	20.8
	Дүн	100	100	100	100

Байнгын ажиллагчдад эзлэх хувиар харвал ажиллагчдын 26.2 хувь нь мэргэжилтэн, 17.3 хувь нь энгийн ажил мэргэжил, 15.7 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 13.3 хувь нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч ажил мэргэжлийн бүлэгт хамаарах ажиллагчид байна.

Харин ажил мэргэжлийн бүлэг тус бүрт эзлэх хувиар контор үйлчилгээний ажилтан бүлэгт хамаарах шинэ ажиллагчдын 84.7 хувь, менежер бүлгийн 91.0 хувь, мэргэжилтэн бүлгийн 81.4 хувь, суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч бүлэгт хамаарах ажил мэргэжлийн шинэ ажиллагчдын 84.4 хувь тус тус байнгын ажиллагчид бол хөдөө аж ахуй, ой, загас агнуурын

ажилтан бүлэгт хамаарах ажил мэргэжлийн шинэ ажиллагч бүр /100 хувь/ байнгын ажлын байранд буюу үндсэн ажилтнаар ажилд оржээ.

Сул орон тоог нөхсөн хувь буюу сул орон тоонд авсан ажиллагчдад эзлэх хувиар шинэ ажиллагчдын 25.1 мэргэжилтэн, 17.1 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 10.7 хувь нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 20.8 хувь нь энгийн ажил мэргэжлийн бүлгийн ажиллагчид эзэлж, сул ажлын байранд ажилд орсон иргэдийн 73.7 хувийг бүрдүүлж байна.

Шинэ ажиллагчдыг ажил мэргэжлийн ангиллын нэгж бүлгийн хувьд авч үзвэл нийт шинээр ажилд орогчдын 7.3 хувь нь үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан 5.5 хувь нь худалдагч, 3.3 хувь нь барилгын туслах ажилтан, 2.7 хувь нь тогооч, 2.6 хувь нь албан байгууллагын цэвэрлэгч, 2.5 хувь нь жолооч, тус бүр 2.4 хувь нь гэрээт албаны харуул, ачааны тэрэгний жолооч мэргэжлийн ажиллагчид эзэлж байгаа нь өндөр хувийг эзэлж байна.

Харин ажиллагчдын тус бүр 1.4 хувийг ахлах нягтлан бодогч, бага ангийн багш, тус бүр 1.0 хувийг хүний их эмч, насан туршийн боловсролын багш гэсэн дээд боловсролын түвшний мэдлэг, мэргэжил шаардах ажил мэргэжлийн ажиллагчид эзэлж байна.

Сүүлийн 12 сард шинээр ажилд орсон үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтны 64.2 хувь нь, худалдагчдын 81.7 хувь, тогоочийн 80.7 хувь, гэрээт албаны харуулын 88.1 хувь, жолооч нарын 85.7 хувь, ачааны тэрэгний жолооч нарын 87.8 хувь нь байнгын ажлын байранд орсон бол нягтлан бодогчийн 89.5 хувь, их эмчийн 83.1 хувь, бага ангийн багш нарын 94.8 хувь нь байнгын ажлын байранд ажилд оржээ.

Хүснэгт 18. Шинэ ажиллагчдын эзлэх хувь, ажил мэргэжлээр.

Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь	Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь
1	932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	7.3	11	234101	Багш, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн	1.4
2	521111	Мухлаг /лангууны худалдагч	5.5	12	513111	Зөөгч	1.2
3	931311	Туслах ажилтан, барилга угсралтын	4.5	13	523011	Дэлгүүрийн кассчин	1.1
4	343411	Тогооч	2.7	14	233030	Багш, насан туршийн боловсролын төвийн дунд, ахлах ангийн	1.0
5	911214	Цэвэрлэгч, албан байгууллагын	2.6	15	221101	Хүний их эмч, ерөнхий мэргэшил судлалын	1.0
6	832211	Жолооч, машины	2.5	16	911211	Цэвэрлэгч, албан тасалгааны	1.0
7	541411	Харуул, гэрээт албаны	2.4	17	265112	Зураач гүйцэтгэгч	1.0
8	833213	Жолооч, ачааны тэрэгний	2.4	18	341111	Эрх зүйн болон холбогдох бусад мэргэжилтэн	0.9

9	832214	Жолооч, бүхээгт машины	1.7	19	931112	Ажилтан, ил уурхайн	0.9
10	241112	Ахлах нягтлан бодогч	1.4	20	234201	Багш, цэцэрлэгийн бүлгийн	0.9

Харин ажлын байрны төрлөөр харвал багш нарын 76.0-77.0 хувь, жолоочийн 76.4 хувь, зөөгчийн ажлын байрны 76.2 хувь нь сул ажлын байр бөгөөд бусад ихэнх ажил мэргэжлийн хувьд энэ үзүүлэлт 40-өөс дээш хувийг эзэлж байна.

### Сүүлийн 12 сарын хугацаанд ажлаас гарсан иргэд

Ажил олгогчид сүүлийн 12 сарын хугацаанд давхардсан тоогоор 72.3 мянган иргэнийг ажлын байраар хангаж, хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгосон хэдий ч мөн хугацаанд 138.2 мянган ажиллагчид ямар нэг шалтгаанаар ажлаас гарсан байна. Өнгөрсөн оны үр дүнтэй харьцуулахад шинээр ажилд орсон иргэдийн тоо өмнөх оноос 48.9 хувиар, ажлаас гарсан иргэдийн тоо 1.3 дахин өссөн нь ихээхэн анхаарал татаж байна. Энэ нь цар тахлаас үүдэлтэй давагдашгүй хүчин зүйлийн нөлөө нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд сөрөг үр дагавар үзүүлсэн төдийгүй хөдөлмөрийн зах зээлд ч хүчтэй нөлөө үзүүлж буйг харуулж байна.

Ажиллагчдаа цомхотгосон ажил олгогчдын 10.1 хувь нь уг шийдвэрт COVID-19 цар тахлын нөхцөл байдал нөлөөлсөн гэжээ.

Ажлаас гарсан ажиллагчдын 47.8 хувь нь өөрийн хүсэлтээр ажлаа орхисон бөгөөд 52.2 хувь нь хөдөлмөрийн гэрээ дуусах, халагдах, цомхотголд орох гэх мэт ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөр эрхлэлт нь дуусгавар болжээ. Өөрийн хүсэлтээр ажлаас гарсан иргэдийн 40.7 хувь, ажил олгогчийн санаачилгаар ажлаас гарсан ажиллагчдын 15.8 хувь эмэгтэйчүүд байжээ.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар харвал нийт ажлаас гарсан иргэдийн 36.2 хувийг тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбар, 15.6 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбар, 10.4 хувийг барилга, 8.6 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбараас ажлаас гарсан ажиллагчид эзэлж нийт ажиллагчдын 70.9 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 19. Халагдсан ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	Сүүлийн 12 сард ажлаас халагдсан ажиллагчдын тоо			
	Сүүлийн 12 сард ажлаас гарсан хүний тоо	Ажил олгогчийн санаачилгаар ажлаас гарсан ажиллагчид	Өөрийн хүсэлтээр ажлаас гарсан ажиллагчид	Өөрийн хүсэлтээр ажлаас гарсан түвшин /хувь/
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	2.0	0.7	1.3	66.1
Уул уурхай, олборлолт	2.9	0.9	2.0	68.7
Боловсруулах үйлдвэрлэл	11.9	2.4	9.5	79.8
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.9	0.4	0.5	58.6

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	3.0	2.4	0.6	20.3
Барилга	14.4	4.2	10.2	70.8
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	21.6	5.1	16.5	76.4
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	50.0	45.8	4.2	8.4
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	5.3	1.6	3.7	69.3
Мэдээлэл, холбоо	1.5	0.6	0.9	60.5
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2.5	0.9	1.6	65.0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.3	0.3	1.0	74.6
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	3.5	0.8	2.7	77.1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	3.6	0.9	2.8	76.4
Боловсрол	6.3	2.8	3.5	54.8
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	3.9	1.3	2.7	67.9
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.9	0.3	0.6	65.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2.4	0.7	1.7	69.8
Нийт	138.2	72.1	66.0	47.8

Өөрийн хүсэлтээр ажлаас гарсан тохиолдлын 25.0 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарт, 15.4 хувь нь барилга, 14.4 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарынх бол ажил олгогчийн санаачилгаар ажлаас гарсан ажиллагчдын 63.5 хувийг тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын ажлаас гарсан ажиллагчид дангаараа бүрдүүлж байна.

Цар тахлын улмаас улс хоорондын зорчих хөдөлгөөн, ачаа тээврийн урсгал хаасантай холбоотой тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа доголдож, зарим ажил олгогчид үйл ажиллагаагаа зогсоох хэмжээнд хүрсэн нь салбарын хөдөлмөр эрхлэлт буурах гол шалтгаан болж байна.

Харин салбар бүрийн ажлаас гарсан ажиллагчдад эзлэх дүнгээр харвал тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын ажлаас гарсан ажиллагчдын 91.6 хувь, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын 79.9 хувь, боловсролын салбарын 45.2 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын 41.4 хувийг хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон, цомхотголд орсон, тэтгэвэрт гарсан гэх мэт ажил олгогчийн санаачилга, оролцоотой ажлаас гарсан тохиолдлууд эзэлж байна. Харин салбар бүрийн хувьд ажиллагч өөрийн хүсэлтээр ажлаас гарсан түвшин дунджаар 47.8 хувь болж өмнөх оны үр дүнгээс 4.6 пунктээр өссөн нь анхаарал татсан асуудал болж байна.

Байгууллагын үйл ажиллагааны хэлбэрээр харвал нийт ажлаас гарсан иргэдийн 78.3 хувь нь байнгын үйл ажиллагаатай байгууллагын ажиллагчид байжээ.

Ажлаас гарсан иргэдийн 84.0 хувь нь Улаанбаатар хотынх бөгөөд үүний 55.0 хувь нь халагдсан, цомхотголд орсон, хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон гэх ажил олгогчийн санаачлагаар ажлаас гарчээ.


Зураг 14. Сүүлийн 12 сард ажлаас гарсан ажиллагчдын хувь, байршлаар



Сүүлийн 12 сард ажлаас гарсан ажиллагчдын 8.1 хувь нь Төвийн, 3.6 хувь нь Хангайн, 2.8 хувь нь Баруун бүсэд харьяалагдаж, бүс тус бүрийн хувьд ажлаас гарсан ажиллагчдын 60-аас дээш хувь нь өөрийн хүсэлтээр ажлаас гарсан байна.

Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын тооны бүлгээр харвал улсын хэмжээнд ажлаас гарсан нийт ажиллагчдын 60-аас дээш хувь нь 30 хүртэлх ажиллагчидтай ААНБ-д ноогдож, ажил олгогчийн санаачилгаар ажлаас гарсан ажиллагчдын 81.3 хувь, өөрийн хүсэлтээр ажлаас гарсан ажиллагчдын 56.6 хувь нь дээрх бүлгийн ААНБ-ынх байгаагаас ажиллагчдын хөдөлгөөн жижиг ААНБ-уудад их байсан нь харагдаж байна.

Зураг 15. Сүүлийн 12 сард ажлаас гарсан ажиллагчдын хувь, ААНБ-ын ажиллагчдын тооны бүлгээр



Эсрэгээрээ томоохон ажил олгогчдод ажиллагчдын шилжилт хөдөлгөөн бага буюу ажлаас гарсан ажиллагчдын 12.5 хувь 150-аас дээш ажиллагчидтай ААНБ-д, 12.2 хувь нь 50-149 хүртэлх ажиллагчидтай ажил олгогчдод хамааралтай байгаа юм.

Сүүлийн 12 сарын хугацаанд ажлаас гарсан ажиллагчдыг ажил мэргэжлийн хувьд авч үзвэл суудлын болон ачааны машины жолооч /36.6 хувь/, барилга угсралтын туслах ажилтан /8.4 хувь/, үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан /4.7 хувь/, худалдагч /3.4 хувь/, цэвэрлэгч /1.5 хувь/, гэрээт албаны

харуул /1.3 хувь/, зөөгч /1.2 хувь/ ажил мэргэжил бүхий ажиллагчид 57.1 хувийг бүрдүүлж байна. Мөн ус хангамж, иргэний барилга, нефть, байгалийн хий, химийн боловсруулалтын инженерүүд, нягтлан бодогч, эрх зүйн холбогдох мэргэжилтэн зэрэг дээд боловсролын ажил мэргэжлийн ажиллагчид ч байжээ.

Сул ажлын байрны түвшин буюу нэг ажилтныг нөгөөгөөр орлуулсан хувийг хамгийн өндөр хувийн шилжилт хөдөлгөөн явагдсан ажил мэргэжлийн хүрээнд авч үзвэл дэлгүүрийн худалдагч /78.9 хувь/, зочид буудал, албан контор, бусад байгууллагын цэвэрлэгч, туслагч /71.9 хувь/, хамгаалалтын албаны ажилтан /67.1 хувь/, машин, такси болон бүхээгт тэрэгний жолооч /60.2 хувь/, үйлдвэрийн бусад ажилтнууд /59.5 хувь/ зэрэгт өндөр хувьтай төдийгүй бусад ажил мэргэжлийн хувьд ч энэ үзүүлэлт 35-аас дээш хувийг эзэлж байна.

Хүснэгт 20. Шинэ болон халагдсан ажиллагчид, ажил мэргэжлээр

ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Сүүлийн 12 сард ажилд авсан ажиллагчдын тоо			Сүүлийн 12 сард ажлаас гарсан ажиллагчид		
		Нийт	Сул ажлын байранд	Орлуулсан түвшин (%)	Ажил олгогчийн санаачилгаар ажлаас гарсан ажиллагчид	Өөрийн хүсэлтээр ажлаас гарсан ажиллагчид	Өөрийн хүсэлтээр ажлаас гарсан түвшин (%)
8322	Машин, такси болон бүхээгт тэрэгний жолооч	3.4	2.0	60.2	44.3	4.2	8.7
9313	Барилга угсралтын туслах ажилтан	0.9	0.3	38.3	4.0	7.6	65.6
9329	Энэ ангилалд ороогүй үйлдвэрийн бусад ажилтан	5.3	3.1	59.5	0.8	5.7	87.5
9112	Зочид буудал, албан контор, бусад байгууллагын цэвэрлэгч, туслагч	2.7	2.0	71.9	0.9	2.2	72.1
2142	Иргэний барилга байгууламжийн инженер	1.1	0.5	48.5	2.6	1.3	33.8
5221	Дэлгүүр ажиллуулагч	0.0	0.0	78.9	0.9	3.9	81.6
5414	Хамгаалалтын албаны ажилтан	1.9	1.3	67.1	0.8	1.7	67.8
3434	Тогооч	2.0	0.9	47.3	0.7	1.7	69.2
8332	Хүнд даацын машин, том тэрэгний жолооч	2.1	1.3	59.8	1.2	1.0	45.3
5211	Мухлаг, захын худалдаачин	4.0	2.7	68.2	0.0	0.0	93.5
2411	Нягтлан бодогч	1.5	0.9	57.3	0.5	1.6	76.4
9333	Ачаа зөөгч	1.5	0.8	51.1	0.3	1.3	81.5
9312	Иргэний барилгын туслах ажилтан	2.4	0.4	17.7	0.0	0.5	100
2310	Багш, дээд боловсрол олгох багш	1.1	0.8	76.3	0.6	0.8	59.3
5131	Зөөгч	0.9	0.7	76.0	0.5	1.1	67.9

Машин, такси болон бүхээгт тэрэгний жолооч нарын 91.3 хувь нь ажил олгогчийн шаардлагаар ажлаас гарсан бол ажилтан өөрийн хүсэлтээр ажлаас гарсан түвшин иргэний барилгын туслах ажилтан, мухлаг, захын худалдаачин, үйлдвэрийн бусад ажилтан, дэлгүүр ажиллуулагч, ачаа зөөгч ажил мэргэжлийн хүрээнд 80-аас дээш хувийг эзэлж байна.



Жил бүрийн судалгаанд ажиллах хүчний эрэлт ихтэй хэмээн нэрлэгддэг зарим ажил мэргэжлүүдийн хувьд дээрх үзүүлэлтүүд багагүй хувьтай байгаа нь тухайн ажил мэргэжлийн хүрээнд ажиллах хүчний хөдөлгөөн их, үүнээс үүдсэн хангагдаагүй эрэлт байсаар буйг илтгэж байна.

#### 2.1.4. Нээлттэй ажлын байр

Судалгааны мэдээлэл цуглуулах тухайн хугацаанд ажил олгогчдод нээлттэй зарласан ажлын байр байгаа эсэхийг тодруулдаг бөгөөд ААНБ-ын 16.3 хувь нь 37.6 мянган ажлын байранд ажиллагч сонгон шалгаруулж авахаар нээлттэй зарласан байв. Энэ нь өмнөх оны судалгааны дүнгээс ажлын байр нээлттэй зарласан аж ахуйн нэгж 2.3 пунктээр буурсан ч, ажлын байр нь 61.4 хувиар өссөн дүр зураг харагдаж байна. Тухайлбал бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарт 11.3 мянган нээлттэй ажлын байр байгаа нь өмнөх оноос 6.3 мянгаар, барилгын салбарт 5.3 мянга болж өмнөх оноос 1.8 мянга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 5.4 мянга буюу өмнөх оноос 2.0 мянгаар өссөн бөгөөд дээрх гурван салбарын ажиллах хүчний хэрэгцээ нийт нээлттэй ажлын байрны 58.7 хувийг бүрдүүлж байна. Харин санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын нээлттэй ажлын байр өнгөрсөн оны судалгааны дүнгээс буурсан үр дүнтэй байна.

Нээлттэй зарласан ажлын байрны 51.4 хувь нь сул ажлын байранд ажиллагч сонгон шалгаруулж авах зар эзэлж буй нь өмнөх оны судалгааны дүнгээс 2.6 пунктээр буурсан бол нээлттэй ажлын байрны түвшин<sup>1</sup> 5.8 хувь болж 0.8 пунктээр өссөн байна.

Хүснэгт 21. Нээлттэй зарлагдсан ажлын байрны түвшин, салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	Нээлттэй зарлагдсан ажлын байр			Нээлттэй ажлын байрны түвшин
	Нийт ажлын байр	Үүнээс: Сул ажлын байр	Орлуулах түвшин	
	Тоо	Тоо	Хувь	
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.8	0.2	30.0	7.1
Уул уурхай, олборлолт	0.7	0.7	94.9	2.5
Боловсруулах үйлдвэрлэл	5.4	2.7	50.2	10.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.3	0.2	65.0	2.1
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.3	0.2	58.3	4.2
Барилга	5.3	2.3	43.1	10.1
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	11.3	5.7	50.6	8.6
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	1.5	0.8	55.3	3.3
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2.2	1.7	75.5	10.0
Мэдээлэл, холбоо	0.7	0.2	23.9	5.2
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0.2	0.1	63.5	0.9

<sup>1</sup> Нээлттэй ажлын байрны түвшин = Нээлттэй зарласан ажлын байрны тоо / (ажиллагчдын тоо + нээлттэй зарласан ажлын байрны тоо)\*100

Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.4	0.2	44.0	4.5
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.4	0.6	44.8	4.9
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.9	0.5	55.9	5.0
Боловсрол	2.1	1.5	68.9	2.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	2.3	1.1	50.3	4.7
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.3	0.2	49.7	3.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.5	0.5	31.8	5.5
Нийт	37.6	19.3	51.4	5.8


Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбар, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, урлаг, үзвэр, тоглоом наадам гэх мэт салбаруудад тус бүр 0.3 мянган нээлттэй зарласан ажлын байр байгаа нь хамгийн бага үзүүлэлт буюу 2.7 хувийг эзэлж байна.

Салбарын нээлттэй зарласан ажлын байранд, сул ажлын байрны эзлэх хувь буюу орлуулах түвшнээр харвал уул уурхай, олборлолтын салбарын 94.9 хувь, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын нээлттэй ажлын байрны 75.5 хувь, боловсролын салбарын 68.9 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын 65.0 хувь, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын нээлттэй ажлын байрны 58.3 хувийг сул ажлын байр эзэлж байгаа нь эдгээр салбарт сул ажлын байрны түвшин буюу нэг ажилтныг нөгөөгөөр орлуулах түвшин өндөр байна. Мөн ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур болон барилга, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, мэдээлэл, холбоо, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаас бусад салбарт нээлттэй зарлагдсан ажлын байрны хувьд сул ажлын байрны түвшин 50-аас дээш хувийг эзэлж байна.

Нээлттэй ажлын байрны түвшин салбарын хувьд боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 10.2 хувь, барилгын салбарт 10.1 хувь, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт 10.0 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарт 8.6 хувь, ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт 7.1 хувь байгаа нь хамгийн өндөр хувийг үзүүлж байна. Харин уул уурхай, олборлолтын салбар, цахилгаан, хий, уур, агааржуулалт, боловсрол, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбаруудад дээрх үзүүлэлт хамгийн бага буюу 0.9-2.5 түвшинтэй байгаа юм.

Нээлттэй зарлагдсан ажлын байрны мэдээллийг байршлаар авч үзвэл нийт зарлагдсан ажлын байрны 78.8 хувь буюу 29.6 мянга нь Улаанбаатар хотод байгаа ба үүний 48.4 хувийг сул ажлын байр эзэлж байна. Харин орон нутаг нээлттэй ажлын байрны хувь бага, Төвийн бүсэд 3.9 мянга /10.4 хувь/, Хангайн бүсэд 1.9 мянга /5.1 хувь/, Баруун бүсэд 1.3 мянган /3.4 хувь/, Зүүн бүсэд 0.9 мянга /6.8 хувь/-н ажлын байр нээлттэй байжээ.


Зураг 16. Нээлттэй ажлын байр, байрилаар, мян /хүн



Төвийн бүсийн нээлттэй ажлын байрны 72.1 хувь, Зүүн бүсийн нээлттэй ажлын байрны 75.4 хувь, Хангайн бүсийн 55.1 хувийг сул ажлын байр эзэлж байна.

Уг үзүүлэлтийг ажил олгогчийн /ажиллагчдын тооны бүлэг/ хувьд харвал нээлттэй ажлын байрны 38.3 хувь буюу 14.4 мянга нь 1-9 хүртэлх ажиллагчтай аж ахуй нэгж, 24.5 хувь буюу 9.2 мянга нь 10-29 ажиллагчтай аж ахуй нэгжид бий болох ба нээлттэй ажлын байрны 62.8 хувийг эзэлж буй бол 10.4 хувь буюу 3.9 мянга нь 150 болон түүнээс дээш ажиллагчтай ААНБ-уудад бий болжээ.

Зураг 17. Нээлттэй ажлын байр, ажил олгогчийн ажиллагчдын тооны бүлгээр, мян /хүн



30-аас дээш ажиллагчтай аж ахуйн нэгжүүдэд хамааралтай нээлттэй ажлын байрны 60-аас дээш хувь нь сул ажлын байр бол, ажиллагчдын тоо бага, жижиг ААНБ-ын хувьд 42.0-46.0 хувийг бүрдүүлж байна.

Нээлттэй зарласан ажлын байрны 28.9 хувь нь “Энгийн ажил мэргэжил”, 19.7 хувь нь “Мэргэжилтэн”, 16.2 хувь нь “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан”, 12.5 хувь нь “Худалдаа, үйлчилгээний ажилтан” зэрэг ажил мэргэжлийн үндсэн бүлэгт хамаарч байгаа нь 77.4 хувийг эзэлж байна.

Хүснэгт 22. Нээлттэй зарлагдсан ажлын байрны эзлэх хувь, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр

Үндсэн бүлгийн дугаар	Ажил мэргэжлийн ангилал	Дүнд эзлэх хувь
1	Менежер	3.8
2	Мэргэжилтэн	19.7
3	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	7.6
4	Контор үйлчилгээний ажилтан	1.4
5	Худалдаа, үйлчилгээний ажилтан	12.5
6	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	0.7
7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	16.2
8	Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	9.1
9	Энгийн ажил мэргэжил	28.9
	Нийт	100

Нэгж ажил мэргэжлийн хувьд авч үзвэл нийт нээлттэй ажлын байрны 8.7 хувийг үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан, 6.4 хувийг барилгын туслах ажилтан, 4.1 хувийг худалдагч, 4.0 хувийг албан байгууллагын цэвэрлэгч, 3.0 хувийг жолооч, 3.2 хувийг тогооч, 3.0 хувийг жолооч зэрэг ажил мэргэжлийн ажлын байр эзэлж, нээлттэй ажлын байрны 29.3 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 23. Нээлттэй зарлагдсан ажлын байрны эзлэх хувь, ажил мэргэжлийн ангиллаар

Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь	Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь
1	932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	8.7	11	711411	Арматурчин	1.7
2	931311	Туслах ажилтан, барилга угсралтын	6.4	12	513111	Зөөгч	1.6
3	521111	Мухлаг /лангууны худалдагч	4.1	13	523011	Дэлгүүрийн кассчин	1.5
4	911214	Цэвэрлэгч, албан байгууллагын	4.0	14	541411	Харуул, гэрээт албаны	1.4
5	343411	Тогооч	3.2	15	941211	Гараар аяга таваг угаагч	1.3
6	832211	Жолооч, машины	3.0	16	222102	Сувилагч, ерөнхий мэргэжлийн	1.2
7	941212	Гал тогооны туслах ажилтан	2.4	17	524212	Борлуулагч	1.1
8	711515	Мужаан, засварын	2.2	18	711511	Барилга угсралтын мужаан	1.0
9	712314	Шаварчин засалчин, засал чимэглэлийн	2.2	19	731121	Засварчин, багажны /нарийн/	1.0
10	933315	Ачигч, агуулахын	2.1	20	951012	Машин угаагч	0.9

Мөн 1.7 хувийг арматурчин, 1.2 хувийг ерөнхий мэргэжлийн сувилагч зэрэг ажил мэргэжлийн нээлттэй ажлын байр эзэлж байна.

Жил бүрийн судалгааны үр дүнгээр ажлаас гарсан, шинээр ажилд орсон, нээлттэй зарлагдсан ажлын байр бүрт үйлдвэрлэл аж ахуйн болон барилгын туслах ажилтан, тогооч, жолооч, худалдагч, харуул гэх мэт ажил мэргэжлүүд түгээмэл тохиолддог бөгөөд эдгээр ажил мэргэжлийн ажиллагчдын хүрээнд явагдаж буй ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн төдийлөн буурахгүй байгааг харуулж байна. Энэ нь богино хугацааны ажиллах хүчний эрэлтэд ч нөлөөлж, ажил мэргэжлээрх эрэлт буюу эрэлттэй ажил мэргэжлийн үзүүлэлтэд ч хомсдолтой ажил мэргэжлийн хүрээнд ч мөн өндөр хувийг эзэлсээр байна.

Сул ажлын байрыг олон нийтэд нээлттэй зарлаад дунджаар 5 долоо хоног, хамгийн багадаа 1 долоо хоног, хамгийн ихдээ 8 долоо хоног болж байгаа бол, цаашид үргэлжлэх хугацаа дунджаар 5 долоо хоног, хамгийн ихдээ 7 долоо хоног болохоор байна. Зарим ажил олгогчдын хувьд тухайн ажлын байранд тохирох ажилтныг авах хүртэл үргэлжлүүлэн зарласаар байдаг гэжээ.

Ажлын байранд шаардах боловсролын түвшин ажлын байрны шаардлага, гүйцэтгэх ажил үүргийн хүрээнээс хамаарч харилцан адилгүй хэдий ч бакалаврийн түвшний боловсролтой байх шаардлага хамгийн ихээр, бүрэн дунд боловсролтой байх шаардлага түгээмэл дурьдагдсан байна. Харин ажлын байрны ур чадварын шаардлагыг харвал 2-оос дээш жилийн ажлын туршлага, тогтвортой ажиллах, багаар ажиллах, ачаалал даах чадварыг түлхүү шаардахаас гадна ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалан гадаад хэл, болон компьютерийн мэдлэг, ангиллын болон мэргэжлийн үнэмлэх, мэргэжлийн зэрэг, тусгай зөвшөөрөл зэргийн илүү дурьдсан байна.

## **2.2. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЭРЭЛТ**

Улсын хэмжээний хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, богино хугацааны ажиллах хүчний эрэлтийн төлөв байдлын талаарх мэдээллийг хүргэх зорилгын хүрээнд энэхүү судалгаа нь жил тутам хийгдсээр даруй 10 гаруй жил болжээ.

Судалгааны үндсэн үр дүнг жил бүрийн судалгааны нэгэн адил түүврийн эх олонлогт тархаан тооцсон болно. Хөдөлмөрийн зах зээлийн ажиллах хүчний эрэлтийг оны эхний ба сүүлийн хагас жилээр ангилан, ажлын байрны хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлээр задлан тайлбарладаг өмнөх загварыг хадгалан үр дүнг нэгтгэлээ.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгааны судлах гол асуудал нь хөдөлмөрийн зэх зээл дэх ажлын байрны өсөлт, хүний нөөцийн чиглэлээрх ажил олгогчдын төлөвлөгөө, төсөөлөл юм. Энэхүү төсөөлөл нь эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байршил болон цаг хугацаанаас хамааран харилцан адилгүй байдаг хэдий ч тодорхой хэд хэдэн салбарын ажиллах хүчний эрэлт тогтмол эерэг өөрчлөлтийг үзүүлж, ажиллах хүчний шингээлт өндөртэй байдаг нь жил бүрийн ажиллах хүчний эрэлтийн мэдээллээс харагддаг.

Хэдийгээр энэ жилийн хувьд коронавируст халдвар /COVID-19/ цар тахлаас шалтгаалсан хүчин зүйлийн нөлөөгөөр урьдчилан төсөөлж, төлөвлөх боломжгүй нөхцөл байдал удаан үргэлжилж, эдийн засаг, нийгмийн байдал тогтворгүй байгаа ч ажил олгогчид 2022 оныг харьцангуй эерэгээр харж,


хүлээлт өндөртэй байгаа нь ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүсэлтэй зогсонги байдал өөрчлөгдөж, үйл ажиллагаагаа хэвийн горимоор үргэлжлүүлэх бүрэн итгэлтэй байна.

Ээлжит судалгааны хувьд өмнөх жилүүдийн адил тодорхой хэдэн салбарууд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд голлон нөлөөлж, ажиллах хүчний өсөлт, хөдөлмөр эрхлэлтийн эерэг өөрчлөлтийг харуулдаг зүй тогтол хэвээр байна. Харин ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, цахилгаан хий, агааржуулалтын үйл ажиллагаа зэрэг салбарын тухайд салбарын онцлог, цар хүрэнээс хамааран ажиллах хүчний эрэлт бага байдаг бөгөөд энэ жилийн хувьд ч адил үр дүн гарлаа. Хүн ам, суурьшлийн төвлөрөлөөс шалтгаалж орон нутагт нийслэлтэй харьцуулахад ажиллах хүчний эрэлт бага байдаг бөгөөд энэ жил ч энэхүү чиг хандлага хэвээр хадгалагдлаа.

Энэ удаагийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгааны дүнгээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын 29.0 хувь нь шинэ болон сул ажлын байранд ажилтан авахаар төлөвлөсөн нь өмнөх жилийнхээс 2.4 пунктээр буурах төлөвтэй ч эдгээр ажил олгогчдын хүрээнд бий болох ажиллах хүчний эрэлт нь өмнөх оны дүнгээс өссөн байна.

Хангайн бүсийн ААНБ-ын 29.7 хувь, Зүүн бүсийн 28.1 хувь ажиллах хүч авахаар төлөвлөсөн нь өмнөх оны судалгааны үр дүнгээс буурсан үзүүлэлттэй бол Баруун бүсийн ажил олгогчдийн 28.2 хувь, Төвийн бүсийн ААНБ-ын 28.4 хувь нь ажилтан авахаар төлөвлөсөн нь өмнөх онтой харьцуулахад өссөн үзүүлэлт болж байна. Улаанбаатар хотын ажил олгогчдын 29.2 хувь нь ирэх онд ажиллах хүчээ нэмэгдүүлэх хэрэгцээ байгааг илэрхийлсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 2.0 пунктээр буурах төлөвтэй байна.

Зураг 18. 2022 онд ААНБ-ууд шинээр ажилтан авах эсэх, бүсээр, хувиар



Ирэх 1 жилийн хугацаанд ажилтан авах ажил олгогчдын 37.4 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарын аж ахуйн нэгжүүд дангаараа бүрдүүлж байгаа бол 87.2 хувь нь хувийн өмчийн, 72.6 хувь нь байнгын үйл ажиллагаатай ажил олгогчид байна. Харин ажиллагчдийн тооны бүлгээр харвал 9-өөс доош ажиллагчидтай аж ахуйн нэгжүүдийн 25.9 хувь, 30-49 ажиллагчтай аж ахуйн нэгжүүдийн

37.9 хувь нь 2022 онд ажилтан авах төлөвлөгөөтэй гэсэн бол 50-аас дээш ажиллагчидтай болон томоохон ажил олгогчдын 40-өөс дээш хувь нь ажиллах хүчний хэрэгцээтэй хэмээсэн байна.

2022 онд хөдөлмөрийн зах зээлд 78.0 мянган ажиллах хүчний эрэлт, хэрэгцээ бий болохоор байгаа нь өнгөрсөн оны судалгааны үр дүнгээс 48.3 хувиар өсөх төлөвтэй байна. Ажиллах хүчний эрэлтийн 72.9 хувь нь 2022 оны эхний хагаст, үлдсэн 27.1 хувь нь оны сүүлийн хагас жилд бий болох төлөвтэй байна.

### 2.2.1. Оны эхний хагас дахь ажиллах хүчний эрэлт /2022.01-2022.06/

Энэ онд хөдөлмөрийн зах зээлд бий болох ажиллах хүчний нийт эрэлтийн 56.8 мянга буюу 72.9 хувь нь оны эхний хагаст бий болох төлөвтэй байгаа нь өмнөх оны судалгааны дүнгээс 2.0 пунктээр буурах үр дүнтэй байна.

Оны эхний хагаст бий болох ажиллах хүчний эрэлтийг салбараар авч үзвэл бөөний болон жижиглэн худалдааны салбарт 15.9 мянга буюу оны эхний хагаст бий болох ажиллах хүчний эрэлтийн 31.4 хувь, барилгын салбарт 6.7 мянга буюу 15.3 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 4.0 мянга буюу 8.2 хувь, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт 3.1 мянга буюу 6.0 хувь, тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарт 2.4 мянга буюу 5.9 хувь нь бий болох төлөвтэй байна. Харин цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, урлаг, үзвэр, тоглоом наадам, ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, мэдээлэл холбооны салбаруудад ажиллах хүчний эрэлт бага байхаар байна.

Зураг 19. 2022 оны эхний 6 сарын ажиллах хүчний эрэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, хувиар



Оны эхний хагас жилд бий болохоор хүлээгдэж буй ажиллах хүчний эрэлтийн 48.8 мянга буюу 85.9 хувь нь байнгын ажлын байр бол 8.0 мянга нь түр ажлын байр байна. Эрэлтийн 78.6 хувь нь Улаанбаатар хотод, 9.2 хувь нь Төвийн бүсэд бий болох дүр зураг гарчээ.

### 2.2.2. Оны сүүлийн хагас дахь ажиллах хүчний эрэлт /2022.07-2022.12/

Энэ оны сүүлийн хагаст улсын хэмжээнд 21.2 мянган ажлын байр буюу ажиллах хүчний нийт эрэлтийн 27.1 хувь нь бий болохоор байна.

Ажиллах хүчний сүүлийн хагас жилийн эрэлтийн хүрээнд бий болох ажлын байрны 80.1 хувь нь байнгын, үлдсэн 19.9 хувь нь түр ажлын байр байх төлөвтэй.

Байршлаар 75.6 хувь нь Улаанбаатар хотод, 9.2 хувь нь Баруун бүсэд бий болох хүлээлттэй байна.

*Зураг 20. 2022 оны сүүлийн 6 сарын ажиллах хүчний эрэлт, ЭЗҮА-ны салбарын ангилал, хувиар*



Оны сүүлийн хагаст бий болох ажиллах хүчний эрэлтийн 28.6 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарт, 26.1 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 13.2 хувь нь барилга, 4.8 хувь нь боловсролын салбарт бий болох төсөөлөлтэй байна. Эдгээр нь сүүлийн 6 сарын нийт эрэлтийн 72.6 хувийг бүрдүүлж байна.

Өмнөх судалгааны үр дүнгээр жилийн сүүлийн хагаст ажиллах хүчний эрэлт нийт эрэлтийн 25.1 хувийг эзэлж байсан бол энэ жилийн тухайд сүүлийн хагас дахь ажиллах хүчний эрэлт 2.0 пунктээр өсөх төлөвтэй бөгөөд энэхүү чиг хандлага сүүлийн 2 жилийн судалгаанд давтагдаж байна.

### 2.2.3. 2022 оны ажиллах хүчний нийт эрэлт

Улсын хэмжээнд 2022 онд 78.0 мянган ажлын байр бий болох ба өмнөх оны судалгааны дүнтэй харьцуулахад 25.0 гаруй мянган ажлын байр буюу 48.3 хувиар өсч, цар тахлын нөхцөл байдлаас өмнөх үеийн хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий чиг хандлага хадгалагдах төлөв ажиглагдлаа. Ажиллах хүчний эрэлтийн хүрээнд хөдөлмөр эрхлэлт 6.9 хувиар өсөх боломжтой харагдаж байна.



## Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаарх ажиллах хүчний эрэлт

2022 онд ажиллах хүчний эрэлт хамгийн их байх салбар нь өмнөх жилүүдийн адил бөөний болон жижиглэн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэл, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар бөгөөд 2022 онд хөдөлмөрийн зах зээлд гол эерэг нөлөөг үзүүлэх салбарууд болж байна.

Бөөний болон жижиглэн худалдааны салбарт жилийн нийт эрэлтийн 30.7 хувь буюу 23.9 мянган ажиллах хүчний эрэлт бий болох нь өмнөх жилийн судалгааны үр дүнгээс 79.5 хувиар өсөх үзүүлэлт юм. Барилгын салбарт 11.5 мянган ажиллах хүчний эрэлт бий болох нь нийт эрэлтийн 14.7 хувийг эзэлж, өмнөх жилийн судалгааны үр дүнгээс 5.9 хувиар, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 10.2 мянга буюу нийт эрэлтийн 13.1 хувь бий болж, 50.3 хувиар, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт 4.1 мянга буюу нийт эрэлтийн 5.2 хувь бий болж, мөн л 61.8 хувиар өсөх үзүүлэлттэй байна.

Ажиллах хүчний эрэлт өндөр байх бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын эрэлт 2022 оны ажиллах хүчний эрэлтийн 58.4 хувийг бүрдүүлж байна.

Зураг 21. 2022 оны ажиллах хүчний эрэлт, салбарын ангилал, хувиар



Өмнөх оны судалгааны дүнгээр үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын ажиллах хүчний эрэлт өсөх үр дүн гарч байсан бол энэ удаагийн үр дүнгээр дээрх салбаруудын эрэлт буурах хандлагатай байна. Тухайлбал үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт 81.3 хувь, ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын ажиллах хүчний эрэлт 35.4 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалт салбарт 24.9 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх

үйл ажиллагаа салбарын ажиллах хүчний эрэлт 12.3 хувиар буурах төлөвтэй бөгөөд эдгээр нь ажиллах хүчний эрэлтийн 5.8 хувийг бүрдүүлж байна.

Дээрх салбаруудаас бусад салбаруудын ажиллах хүчний эрэлт өмнөх жилийн үр дүнгээс өсөх бөгөөд санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, урлаг, үзвэр, тоглоом наадам, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, тээвэр, агуулахын үйл ажиллагаа, боловсрол, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбаруудад энэ хандлага өндөр хувьтай байх төлөвтэй байна. Тухайлбал санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын эрэлт 6 дахин, урлаг, үзвэр, тоглоом наадам салбарын эрэлт 5.2 дахин, боловсролын салбар 2.5 дахин, тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбар 2.2 дахин, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар 2.1 дахин өсөх үр дүн гарчээ.


Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарын ажиллах хүчний эрэлт 2022 оны эрэлтийн 3.3 хувийг бүрдүүлж байгаа хэдий ч өмнөх жилийн ажиллах хүчний эрэлтээс 67.4 хувь, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын ажиллах хүчний эрэлт 3.5 хувийг бүрдүүлж, өмнөх онтой харьцуулахад 58.1 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар ажиллах хүчний эрэлтийн 3.3 хувийг бүрдүүлж буй ч 42.3 хувь, уул уулрхайн олборлолтын салбарын эрэлт нийт эрэлтийн 2.2 хувийг бүрдүүлж, 38.1 хувь, мэдээлэл, холбооны салбарын эрэлт 1.9 хувийг эзэлж буй хэдий ч 9.7 хувиар тус тус өсөх үр дүн харагдаж байна.

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамжийн үйл ажиллагаа, урлаг үзвэр, тоглоомнаадам, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбаруудад ажиллах хүчний эрэлт хамгийн бага байх төлөвтэй бөгөөд эдгээр салбаруудад 2.3 мянган ажлын байр бий болж, нийт эрэлтийн 2.9 хувийг эзэлж байна. Жил бүрийн судалгааны дүнгээр ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамжийн үйл ажиллагаа, урлаг үзвэр, тоглоом наадам салбарын эрэлт хамгийн бага хувийг эзэлж байдаг.

2022 оны хүлээгдэж буй ажиллах хүчний эрэлтийг тухайн салбарын ажиллагчдын тоо<sup>2</sup>-той харьцуулан авч үзвэл мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарын ажиллах хүчний эрэлт тухайн салбарын ажиллагчдын 18.5 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарын 16.1 хувь, урлаг, үзвэр, тоглоом наадам салбарын 14.7 хувь, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбар 14.4 хувь, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын эрэлт тухайн салбарын ажиллагчдын 13.6 хувьтай тэнцүү байна.

<sup>2</sup> УСХ, 2021 оны III улирлын ажиллагчдын тоо

Зураг 22. Ажиллагчдын тоо болон ажиллах хүчний эрэлт, салбарын ангиллаар, мянган хүн



Боловсруулах үйлдвэрлэл, ус хангамж, барилга, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбаруудын ажиллах хүчний эрэлт нь тухайн салбар бүрийн ажиллагчдын 12.0 хувьтай тэнцүү байна.

2022 оны хөдөлмөрийн зах зээлд бий болох ажиллах хүчний эрэлтэд өмнөх жилүүдийн адил улирлын нөлөө хадгалагдсаар байна. Тухайлбал, оны эхний хагаст ажиллах хүчний нийт эрэлтийн 72.9 хувь нь бий болж, сүүлийн 6 сарын ажиллах хүчний эрэлтээс 2.7 дахин их байхаар харагдаж байгаа хэдий ч өмнөх оны үр дүнгээс 2 пунктээр буурах төсөөлөлтэй байна. Оны эхний хагаст хамаарах эрэлтийн 85.9 хувийг байнгын ажлын байрны ажиллах хүчний эрэлт эзэлж байгаа ч, оны нийт түр ажиллах хүчний эрэлтийн 65.7 хувь нь эхний хагас жилд бий болох төсөөлөлтэй байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар тус бүрээр авч үзвэл тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарын эрэлтийн 90.1 хувь, мэдээлэл, холбооны салбарын эрэлтийн 87.9 хувь, урлаг, үзвэр, тоглоомнаадамсалбарын эрэлтийн 87.4 хувь, уул уурхай, олборлолтын салбарын эрэлтийн 86.9 хувь, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын 84.5 хувь, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын 83.0 хувь, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын 80.5 хувь нь оны эхний хагас жилд бий болох төлөвтэй.

Ажиллах хүчний эрэлтийн голлох хувийг бүрдүүлдэг бөөний болон жижиглэн худалдаа, барилгын салбарын эрэлтийн 74.0-75.0 хувь нь оны эхний хагаст хамаарч байна. Мөн үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, боловсролын салбаруудын

ажиллах хүчний эрэлтийн 71.0-77.0 хувь нь оны эхний хагаст төлөвлөгдсөн байна.

Хүснэгт 24. 2021 оны ажиллах хүчний эрэлт, салбар, хугацаагаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажиллах хүчний нийт эрэлт /мян.хүн/	Эхний 6 сар		Сүүлийн 6 сар	
		/мян.хүн/	Хувь	/мян.хүн/	Хувь
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.5	1.0	64.3	0.5	35.7
Уул уурхай, олборлолт	1.7	1.5	86.9	0.2	13.1
Боловсруулах үйлдвэрлэл	10.2	4.7	45.8	5.5	54.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.2	0.1	58.5	0.1	41.5
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.8	0.6	75.6	0.2	24.4
Барилга	11.5	8.7	75.7	2.8	24.3
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	23.9	17.9	74.7	6.0	25.3
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	3.7	3.4	90.1	0.4	9.9
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	4.1	3.4	83.0	0.7	17.0
Мэдээлэл, холбоо	1.5	1.3	87.9	0.2	12.1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	3.8	3.0	80.5	0.7	19.5
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.4	0.3	73.7	0.1	26.3
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2.6	1.7	66.0	0.9	34.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2.4	1.7	72.0	0.7	28.0
Боловсрол	3.5	2.5	71.1	1.0	28.9
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	2.8	2.3	84.5	0.4	15.5
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1.0	0.8	87.4	0.1	12.6
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2.6	2.0	77.4	0.6	22.6
Нийт	78.0	56.8	72.9	21.2	27.1

Харин боловсруулах үйлдвэрлэлийн салбарын салбарын ажиллах хүчний эрэлтийн 54.2 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын 41.5 хувь оны сүүлийн хагаст бий болохоор байна.

Оны эхний хагасын ажиллах хүчний эрэлтэд бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ, барилгын салбарын ажиллах хүчний эрэлт гол нөлөөг үзүүлж байгаа бол оны сүүлийн хагасын ажиллах хүчний эрэлтэд ч дээрх салбарууд, болон боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажиллах хүчний эрэлт голлох хувийг эзэлж байна.

### Байршлаарх ажиллах хүчний эрэлт

Энэ онд хөдөлмөрийн зах зээлд бий болох ажиллах хүчний эрэлтийг байршлаар тодруулбал, нийт эрэлтийн 70.8 хувь буюу 55.2 мянга нь Улаанбаатар хотод, 12.7 хувь буюу 9.9 мянга нь Төвийн бүсэд, 8.0 хувь буюу 6.2 мянга нь Хангайн бүсэд, 6.0 хувь буюу 4.7 мянга нь Баруун бүсэд, үлдсэн хувь нь Зүүн бүсэд бий болох төлөвтэй байна.

Улаанбаатар хотын ажиллах хүчний эрэлт өмнөх оны үр дүнгээс 0.1 пунктээр, Төвийн бүсийн эрэлт 6,8 пунктээр өсөх бол Хангайн бүс болон Зүүн бүсэд хамаарах ажиллах хүчний эрэлт буурах төлөвтэй байна. Баруун бүсийн хувьд өөрчлөлтгүй байхаар харагдаж байна.

Зураг 23. 2022 оны ажиллах хүчний эрэлт, бүсээр, хувиар



Улаанбаатар хотод хамгийн олон тооны ажлын байр буюу 55.2 мянган ажиллах хүчний эрэлт бий болохоос 83.7 хувь нь байнгын ажлын байранд ажиллах хүч авах эрэлт бол 70.2 хувь нь шинэ ажлын байр байна. Улаанбаатар хотод бий болох ажиллах хүчний эрэлтэд бөөний болон жижиглэн худалдааны салбар, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд голлох эерэг нөлөө үзүүлсэн хэвээр байгаа юм. Тухайлбал Улаанбаатар хотод бий болох ажиллах хүчний эрэлтийн 33.2 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 15.1 хувь барилгын салбарт, 15.9 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт үүсэх төлөвтэй байна.

Хэдийгээр нийслэлд бий болох ажиллах хүчний эрэлтэд бага хувийг эзэлж байгаа ч тухайн салбарын ажиллах хүчний эрэлтэд Улаанбаатар хотод бий болох ажиллах хүчний эрэлт өндөр байх салбарууд ч байна. Тодруулбал санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын 99.5 хувь нь, мэдээлэл холбооны салбарын эрэлтийн 91.5 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын эрэлтийн 69.0 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагаа болон үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын ажиллах хүчний эрэлтийн тус бүр 64.8 хувь нь Улаанбаатар хотод бий болж ажиллах хүчний өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Түүнчлэн боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажиллах хүчний эрэлтийн 86.2 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарын 76.6 хувь, барилгын салбарын 72.9 хувь нь Улаанбаатар хотод бий болохоор байна.

Энэ оны /2022/ хүлээгдэж буй ажиллах хүчний нийт эрэлтийн 29.2 хувь нь орон нутагт бий болно. Үүний 65.1 хувь нь шинэ ажлын байр байгаа нь орон нутгийн хөдөлмөрийн зах зээл мөн хэмжээгээр тэлэх боломж буйг харуулж байгаа юм. Орон нутгийн ажиллах хүчний эрэлтэд дараах эдийн засгийн салбарууд гол нөлөөг үзүүлж байна. Тухайлбал, бөөний болон жижиглэн худалдааны салбарт орон нутгийн ажиллах хүчний эрэлтийн 24.6 хувь, барилгын салбарт 13.7 хувь, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт 9.0 хувь нь бий болох төлөвтэй байна.

Харин салбарт эзлэх ажиллах хүчний эрэлтээр харвал хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын нийт эрэлтийн 83.3 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын эрэлтийн 76.9 хувь, уул уурхай, олборлолтын салбарын ажиллах хүчний эрэлтийн 73.9 хувь нь орон нутагт бий болохоор байна.

Төвийн бүсэд ажиллах хүчний эрэлт бусад бүсээс өндөр байх ба 9.9 мянган шинэ болон сул ажлын байр бий болох төлөвтэй байна. Мөн Баруун болон Хангайн бүсэд 6.0-8.0 мянган ажиллах хүчний эрэлт үүсэх төлөвтэй байна.

Төвийн бүсийн ажиллах хүчний эрэлтэд бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбар, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын ажиллах хүчний эрэлт өндөр хувийг эзэлж, тухайн бүс нутгийн ажиллах хүчний эрэлтийн 43.6 хувийг бий болгох төлөвтэй.

Хангайн бүс нутагт бөөний болон жижиглэн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэл, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын ажиллах хүчний эрэлт 66.5 хувийг бүрдүүлж байна.

Баруун бүсэд барилга, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар, бөөний болон жижиглэн худалдаа, боловсролын салбарын ажиллах хүчний эрэлт өндөр хувийг эзэллээ.

Хэдийгээр Зүүн бүс нутаг нь бусад бүстэй харьцуулахад ажиллах хүчний эрэлт харьцангуй бага байх төлөвтэй байгаа ч 2.0 мянган шинэ болон сул ажлын байр бий болохоор байна.


Зүүн бүсэд ажиллах хүчний эрэлт бага байхаар тооцоологдсон ч тухайн бүсийн ажиллах хүчний эрэлтэд бөөний болон жижиглэн худалдааны салбар, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, уул уурхайн олборлолтын салбарын ажиллах хүчний эрэлт голлох нөлөө үзүүлэхээр байгаа бөгөөд ажиллах хүчний нийт эрэлтийн 68.9 хувийг дээрх салбаруудын эрэлт эзэлж байна.

Орон нутагт мэдээлэл, холбоо, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа гэх мэт салбар ажиллах хүчний эрэлт хамгийн бага байх эсвэл эрэлтийг огт үүсгэхгүй байх төсөөлөлтэй байна.

### **ААНБ-ын өмчийн хэлбэр, ажиллагчдын тооны бүлгээр**


Ажиллах хүчний нийт эрэлтийн 88.1 хувь нь хувийн хэвшлийн ААНБ-д, 8.3 хувь нь төрийн үйлчилгээний байгууллагад, үлдсэн хувь нь хувийн хамтарсан болон гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ-уудад бий болохоор байна. Өөрөөр хэлбэл тухайн жилийн ажиллах хүчний нийт эрэлтийн 10 ажлын байрны 8 нь хувийн хэвшлийн ААНБ-д хамааралтай байна.

Зураг 24. Ажиллах хүчний эрэлт, ААНБ-ын өмчийн хэлбэр, ажлын байрны хэлбэрээр



Хувийн өмчийн ААНБ-уудад бий болох ажиллах хүчний эрэлтийн 83.3 хувь нь байнгын ажлын байр байна. Энэ үзүүлэлт төрийн өмчийн байгууллагын хувьд 92.9 хувь, хувийн хамтарсан өмчийн хэлбэрийн нэгжид 92.5 хувь, гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ-уудын хувьд 86.1 хувьтай байгаа нь өнгөрсөн оны үр дүнтэй харьцуулахад өсөх үр дүн гарчээ. Өөрөөр хэлбэл өмчийн бүх хэлбэрийн ААНБ-уудад бий болох ажиллах хүчний эрэлт нь байнгын ажилтны тоог нэмэгдүүлэх боломжтой байна.

Зураг 25. Ажиллах хүчний эрэлт, ААНБ-ын ажиллагчдын тооны бүлгээр, хувиар



Аж ахуйн нэгжийн ажиллагчдын тооны бүлгээр харвал ажиллах хүчний эрэлтийн 52.3 хувь нь 1-9 хүртэлх ажиллагчидтай аж ахуйн нэгжид, 20.7 хувь нь 10-29 ажиллагчидтай ААНБ-д бий болох төлөвтэй байгаа нь нийт эрэлтийн 73.0 хувийг эзэлж байна. Үүнийг үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын дунд 30 хүртэлх ажиллагчидтай ААНБ-ын эзлэх хувь өндөр байдагтай холбон тайлбарлаж болох юм. Харин 50-аас дээш ажиллагчидтай ААНБ-д нийт ажиллах хүчний эрэлтийн 20.7 хувь үүсэхээр байгаа нь өмнөх жилийн үр дүнгээс 12.1 пунктээр өсөх төлөвтэй байна.

### Ажлын байрны хэлбэрээр

Хөдөлмөрийн зэх зээлд 2022 онд бий болох ажиллах хүчний эрэлтийг ажлын байрны хэлбэрээр дэлгэрүүлэн үзвэл нийт эрэлтийн 84.3 хувь буюу 65.7 мянга нь байнгын ажиллах хүчний эрэлт байна. Өөрөөр хэлбэл ирэх онд бий болохоор хүлээгдэж буй 10 ажлын байр тутмын 8 нь байнгын ажлын байр байгаа нь өмнөх оны үр дүнгээс 10.1 пунктээр өсөх үзүүлэлт байна. Харин түр ажлын байр өмнөх оныхоос 1.3 мянгаар буурах төлөвтэй бөгөөд ажиллах хүчний эрэлтийн 15.7 хувийг эзэлж байна.

2022 оны хүлээгдэж буй 65.7 мянган байнгын ажиллах хүчний эрэлтийн 87.1 хувь буюу 57.2 мянга нь хувийн өмчийн ААНБ-уудад, 9.1 хувь буюу

6.0 мянга нь төрийн өмчийн, үлдсэн 3.8 хувь нь буюу 2.5 мянга нь хувийн хамтарсан болон гадаад улсын хөрөнгө оруулалттай ААНБ-д бий болохоор байна. Түр ажлын байрны хувьд ч 93.9 хувь нь хувийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагад бий болж үлдсэн хувь нь бусад өмчийн хэлбэрийн ажил олгогчдод бий болох төлөвтэй бөгөөд байнгын ажлын байрны 74.2 хувь нь, түр ажлын байрны 65.7 хувь нь оны эхний хагас жилийн хугацаанд бий болох хандлагатай байна.

Байнгын ажиллах хүчний эрэлтэд гол нөлөө үзүүлж буй салбар нь бөөний болон жижиглэн худалдаа болон барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд юм. Тухайн салбаруудын байнгын ажиллах хүчний эрэлт нийт байнгын ажлын байрны эрэлтийн 57.1 хувийг, түр ажиллах хүчний нийт эрэлтийн 65.6 хувийг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 25. Ажиллах хүчний эрэлт, ажлын байрны хэлбэр, салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажиллах хүчний эрэлт /мян.хүн/		Эзлэх хувь	
	Байнгын	Түр	Байнгын	Түр
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.4	0.1	2.1	1.2
Уул уурхай, олборлолт	1.5	0.2	2.3	1.4
Боловсруулах үйлдвэрлэл	9.2	0.9	14.0	7.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.1	0.1	0.2	0.9
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.7	0.1	1.0	0.5
Барилга	8.3	3.1	12.7	25.7
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	20.0	3.9	30.4	32.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2.7	1.0	4.2	8.0
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	3.7	0.3	5.7	2.7
Мэдээлэл, холбоо	1.2	0.3	1.8	2.7
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	3.6	0.2	5.5	1.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.3	0.0	0.5	0.3
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2.4	0.2	3.6	1.4
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.4	1.0	2.1	8.5
Боловсрол	3.3	0.2	5.1	1.5
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	2.7	0.1	4.0	0.8
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.9	0.0	1.4	0.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2.2	0.3	3.4	2.6
<b>Нийт</b>	<b>65.7</b>	<b>12.2</b>	<b>100</b>	<b>100</b>

Энэ удаагийн судалгааны дүнгээр эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын бүх хэлбэрт байнгын ажилтан авах хэрэгцээ өндөр хувьтай бөгөөд энэ нь хөдөлмөр эрхлэлтэд эерэг үр дүн үзүүлэх юм.



Тухайлбал, урлаг, үзвэр, тоглоомнаадамсалбарын эрэлтийн 97.7 хувь, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын эрэлтийн 96.4 хувь, боловсролын салбарын 94.8 хувь, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын нийт эрэлтийн 94.7 хувийг байнгын ажиллах хүчний эрэлт эзэлж байна. Түүнчлэн ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар, уул уурхай, олборлолт, боловсруулах үйлдвэрлэл, ус хангамж, сувагжилтын систем, хол хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын ажиллах хүчний эрэлтийн 90.0-ээс дээш хувийг байнгын ажиллах хүчний эрэлт бүрдүүлж байна. Энэ үзүүлэлт бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ болон үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 80.0-аас дээш хувь, Барилгын салбарт 72.5 хувийг эзэлж буй бол Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт 56.6 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын эрэлтийн 53.3 хувийг байнгын ажиллах хүчний эрэлт эзэлж байна.

Хэдийгээр ажлын байр нь түр боловч, түр ажиллах хүчний эрэлт нийт эрэлтэд багагүй хувийг эзэлсэн хэвээр байна. Түр ажиллах хүчний нийт эрэлтэд эзлэх хувиар харвал бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарын эрэлтийн 32.3 хувь, барилгын салбарын 25.7 хувийг түр ажиллах хүчний эрэлт эзэлж буй бөгөөд удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт дээрх үзүүлэлт 8.0-8.5 хувьтай байна.

Харин эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын хувьд цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын эрэлтийн 46.7 хувь нь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын 43.4 хувь, барилгын салбарын ажиллах хүчний эрэлтийн 27.5 хувь нь түр ажиллах хүчний эрэлт байхаар байна.

### Ажлын байрны төрлөөр

Хөдөлмөр эрхлэлтийн цэвэр өсөлтийг харуулах нэг үзүүлэлт нь шинээр бий болох ажлын байр бөгөөд 2022 онд бий болох нийт ажиллах хүчний эрэлтийн 54.4 мянга буюу 69.8 хувь нь шинэ ажлын байранд ажилтан авах эрэлт байгаа нь хөдөлмөрийн зах зээл энэ хэмжээгээр тэлэх боломжтойг харуулж байна. Нийт эрэлтийн 23.6 мянга буюу 30.2 хувь нь сул ажлын байр байгаа нь өмнөх оныхоос буурч нийт эрэлтэд эзлэх хувь ч 16.3 пунктээр буурсан үзүүлэлт болжээ.

Хүснэгт 26. Ажиллах хүчний эрэлт, салбараар, ажлын байрны төрлөөр


Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажиллах хүчний эрэлт / мян.хүн /		Дүнд эзлэх хувь	
	Шинэ	Сул	Шинэ	Сул
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.9	0.6	1.7	2.5
Уул уурхай, олборлолт	0.6	1.1	1.0	4.7
Боловсруулах үйлдвэрлэл	7.6	2.6	13.9	11.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.1	0.1	0.2	0.6

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.3	0.5	0.5	2.0
Барилга	8.5	3.0	15.6	12.7
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ	17.3	6.6	31.8	28.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2.8	0.9	5.2	3.7
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2.4	1.7	4.3	7.3
Мэдээлэл, холбоо	1.3	0.2	2.4	0.7
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2.9	0.8	5.4	3.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.3	0.0	0.6	0.1
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.6	1.0	3.0	4.1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.8	0.6	3.3	2.7
Боловсрол	2.1	1.4	3.9	5.9
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1.6	1.2	2.9	5.0
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.5	0.4	1.0	1.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.8	0.8	3.3	3.3
Нийт	54.4	23.6	100	100

Ажиллах хүчний эрэлтийн хүрээнд бий болох шинэ ажлын байрны 31.8 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 15.6 хувь нь барилгын салбарт, 13.9 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт тус тус бий болох бол сул ажлын байрны ажиллах хүчний эрэлтийн 51.9 хувь нь мөн эдгээр салбаруудад бий болохоор харагдаж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын хувьд үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын эрэлтийн 93.8 хувь, мэдээлэл, холбооны салбарын 89.6 хувь нь шинээр бий болох ажлын байранд ажилтан авах эрэлт байгаа нь хамгийн өндөр хувийг харуулж байна. Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын эрэлтийн 77.7 хувь, тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын 76.5 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 74.5 хувь, барилгын салбарын 73.8 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын 73.7 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарын 72.3 хувийг шинэ ажлын байрны ажиллах хүчний эрэлт дангаараа бүрдүүлж байгаа нь эерэг чиг хандлага харагдаж байна. Дээрх салбаруудаас гадна үйлчилгээний бусад үйл ажиллагаа, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, боловсролын салбаруудын ажиллах хүчний эрэлтийн 60.0-69.0 хувийг шинэ ажиллах хүчний эрэлт эзэллээ. Харин сул ажлын байрны ажиллах хүчний эрэлтийн хувьд уул уурхай, олборлолтын салбар, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбаруудад эрэлт хамгийн өндөр буюу салбарын эрэлтийн 62.0-66.0 хувийг бүрдүүлж байна.

Зураг 26. Ажиллах хүчний эрэлтийн эзлэх хувь, ажлын байрны төрөл, өмчийн хэлбэрээр




Өмчийн хэлбэрт эзлэх хувийн жингээр харвал төрийн өмчийн ажил олгогчдод үүсэх ажиллах хүчний эрэлтийн 63.1 хувь, хувийн өмчийн ажил олгогчдын 70.2 хувь, хувийн хамтарсан өмчийн ААНБ-ийн 73.0 хувь, гадаад улсын хөрөнгө оруулалттай ажил олгогчдод бий болох ажиллах хүчний эрэлтийн 76.0 хувь нь шинэ ажлын байр байгаа нь өмчийн бүх хэлбэрийн хувьд өмнөх оны үр дүнгээс өсөх төсөөлөлтэй байна.

Өнгөрсөн оны судалгааны үр дүнгээр сул ажлын байрыг нөхөх ажиллах хүчний эрэлт 24.1 мянга байсан бол энэ удаагийн судалгааны үр дүнгээр 23.6 мянга болж буурах тооцоо гарсан ч сул ажлын байрыг нөхөх зорилготой ажиллах хүчний эрэлт нийт эрэлтийн багагүй хувийг эзэлдэг хэвээр байна.

Судалгааны хүрээнд сул ажлын байр бий болж буй шалтгааныг тодруулдаг бөгөөд ажил олгогчид хөдөлмөрийн харилцаанд оролцогч иргэн буюу ажил горилогчийн хувь хүний төрөлхийн зан төлөв, зөөлөн ур чадвартай холбон тайлбарладаг хэвээр байна. Энэ талаар тодруулсан асуултад ажил олгогчид голлох шалтгаан нь хувь хүний хандлага ёс, хувийн зохион байгуулалттай холбоотой шалтгаануудыг нэрлэж, хамгийн түгээмэл нь ажил хөдөлмөр эрхлэх хүсэл, эрмэлзлэлгүй байгаа талаар байнга дурьдсаар байна. Ажиллагч тогтвор суурьшилтай ажиллахгүй байх, өөрийн хүсэлтээр ажлаас гарах, тодорхойгүй шалтгаанаар ажлаа орхих үзэгдэл түгээмэл байсаар байгааг энэ жилийн үр дүн дахин давтлаа. Жил бүр сул ажлын байр бий болж буй шалтгааны хамгийн өндөр хувийг дээрх шалтгаанууд эзэлсэн хэвээр байна. Энэ удаад эдгээр нь сул ажлын байр бий болох шалтгааны 68.1 эзэлжээ.

Зураг 27. Сул ажлын байр бий болсон шалтгаан, хувиар



Өөрийн хүсэлтээр ажлаас гарсан тохиолдолд 46.6 хувийг бүрдүүлж буй нь өмнөх оны үр дүнгээс 18.3 пунктээр өссөн үзүүлэлт бол тогтвортой ажиллахгүй байх шалтгаан 14.2 хувь болж 17.5 пунктээр буурсан байна.

Хувь хүний хөгжиж, боловсрох болон нийгмийн халамж, хамгааллын хэрэгцээний улмаас үүсэх хоёрдогч шалтгаан болох тэтгэвэр, тэтгэмжид хамрагдах, жирэмсний амралтаа авах, суралцах тохиолдол нь 21.8 хувийг бүрдүүлж байгаа бол ажил олгогчийн санаачилгаар ажиллагч халагдах тохиолдол нийт шалтгааны 3.9 хувийг эзэлж буй нь 0.2 пунктээр буурсан үзүүлэлт болж байна.

Ажил олгогчид ажиллагчдаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхэд анхаарч байгууллагын зүгээс тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Сүүлийн жилүүдэд цар тахлын улмаас үүссэн эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж ажил олгогчдод үйл ажиллагааны болон хөрөнгө санхүүгийн хүндрэл үүсч, урьдчилан тооцож, таамаглах боломжгүй нөхцөл бий болсон нь ажиллагчдаа чиглэсэн үйл ажиллагааны болон бусад зардлыг багасгах зайлшгүй нөхцөл болсон хэдий ч тодорхой хэсэг нь энэ чиглэлд анхаарч ажилласан гэжээ. Нийт авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд эзлэх хувиар харвал 24.9 хувийг ажиллагчдын цалин, урамшууллыг нэмэх, 12.6 хувийг мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх сургалтад хамруулах арга хэмжээ эзэлж байгаа бол 45.8 хувь нь одоогоор ямар нэг ажил хийж амжаагүй байна гэсэн хариулт эзэлж байна. Тодорхой хэсэг нь ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхээр анхаарч ажилласан гэсэн нь 16.6 хувийг эзэлж байна.

### **Ажил мэргэжлээрх ажиллах хүчний эрэлт**

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгааны үндсэн үр дүнгийн нэг нь ХЗЗ-ийн ажиллах хүчний эрэлтийн ажил мэргэжлийн бүлгээрх тооцоолол байдаг.

2022 оны ажиллах хүчний эрэлтийг ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр авч үзвэл ажиллах хүчний нийт эрэлтийн 26.3 хувийг “Энгийн ажил мэргэжил” буюу IX бүлгийн, 21.0 хувийг “Мэргэжилтэн” буюу II бүлгийн ажил мэргэжил, 14.7 хувийг “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан” буюу VII бүлгийн ажил мэргэжил, 13.0 хувийг “Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч”, 11.8 хувийг “Худалдаа, үйлчилгээний ажилтан” буюу V бүлгийн ажил мэргэжлийн бүлгийн эрэлт эзэлж байна. “Менежер” болон “Техникч болон туслах мэргэжилтэн”, “Контор үйлчилгээний ажилтан”, “Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан”, “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан” гэсэн үндсэн бүлэгт хамаарах ажил мэргэжлийн эрэлтийн ажиллах хүчний нийт эрэлтэд эзлэх хувийн жин өмнөх оныхоос буурах бол бусад бүлэгт хамаарах ажил мэргэжлийн ажиллах хүчний эрэлт өсөх төлөвтэй байна.

Хүснэгт 27. Ажиллах хүчний эрэлт, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлэг, хувиар

Үндсэн бүлгийн дугаар	Ажил мэргэжлийн ангилал	Дүнд эзлэх хувь
1	Менежер	4.6
2	Мэргэжилтэн	21.0
3	Техникч болон туслах / дэд мэргэжилтэн	5.4
4	Контор үйлчилгээний ажилтан	2.1
5	Худалдаа, үйлчилгээний ажилтан	11.8
6	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	1.1
7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	14.7
8	Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	13.0
9	Энгийн ажил мэргэжил	26.3
	Нийт	100.0

Хөдөлмөрийн зах зээлд 2022 онд бий болох ажиллах хүчний эрэлтийг ажил мэргэжлийн хувьд авч үзвэл өмнөх жилүүдийн адил тухайн жилд ажиллах хүчний эрэлт өндөр байх салбарт харьяалагдах ажил мэргэжлээрх эрэлт илүү өндөр байх чиг хандлага өөрчлөгдөөгүй байна. Мөн тусгайлсан мэргэжил, боловсрол, ур чадвар шаардахгүй энгийн ажил мэргэжлийн эрэлт өндөр хэвээр байна. Тухайлбал, ажиллах хүчний нийт эрэлтийн 7.5 хувийг үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан, 6.7 хувийг барилгын туслах ажилтан, 2.1 хувийг албан байгууллагын цэвэрлэгч, тус бүр 1.3 хувийг дэлгүүрийн туслах ажилтан, ачигч зэрэг ажил мэргэжлүүд эзэлж байна. Эдгээр ажил мэргэжлийн эрэлт жил бүрийн ажил мэргэжлээрх эрэлтэд багагүй хувийг эзэлдэг бөгөөд энэ оны нийт эрэлтийн 20.0 гаруй хувийг бүрдүүлж байна. Түүнчлэн гэрээт албаны харуул, худалдагч, аяга таваг угаагч зэрэг энгийн ажил мэргэжил, жолооч, тогооч, барилга угсралтын мужаан, борлуулагч, зөөгч, гагнуурчин зэрэг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэдэг ажил мэргэжлийн эрэлт өндөр байгаа бол дээд боловсролын хувьд даатгалын тооцооллын шинжээч, ерөнхий мэргэжлийн сувилагч зэрэг ажил мэргэжлүүд эрэлттэй ажил мэргэжлийн хүрээнд нэрлэгдэж байна.

Хүснэгт 28. Эрэлттэй ажил мэргэжил, хувиар

Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь	Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь
1	932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	7.5	11	524212	Борлуулагч	1.5
2	931311	Туслах ажилтан, барилга угсралтын	6.7	12	513111	Зөөгч	1.4
3	833213	Жолооч, ачааны тэрэгний	4.2	13	522313	Дэлгүүрийн туслах ажилтан	1.3
4	212021	Шинжээч, даатгалын тооцооллын	2.5	14	711411	Арматурчин	1.3
5	521111	Мухлаг /лангууны худалдагч	2.5	15	933316	Ачигч, дэлгүүрийн	1.3

6	911214	Цэвэрлэгч, албан байгууллагын	2.1	16	721214	Гагнуурчин	1.2
7	343411	Тогооч	2.0	17	941211	Гараар аяга таваг угаагч	1.1
8	711511	Барилга угсралтын мужаан	1.9	18	816012	Операторч, талх жигнэх машины	1.1
9	541411	Харуул, гэрээт албаны	1.5	19	911118	Үйлчилгээний болон энгийн ажлын зохион байгуулагч	1.0
10	933315	Ачигч, агуулахын	1.5	20	222102	Сувилагч, ерөнхий мэргэжлийн	1.0

Дээрх нэр бүхий ажил мэргэжлийн эрэлт нийт ажиллах хүчний эрэлтийн 44.5 хувийг бүрдүүлж байна.


### Ур чадварын шаардлага

Энэхүү судалгааны хүрээнд ажил олгогчид ажлын байрандаа ажиллах хүч сонгон шалгаруулж авах, хүний нөөцөө бүрдүүлэхдээ мэргэжлийн болон харилцаа хандлагын хувьд нэн тэргүүнд шаарддаг, чухалчилан үзэх ур чадварын талаар асууж тодруулдаг уламжлалтай.

Ажил олгогчид ажил мэргэжлийн ур чадвараас илүүтэй зөөлөн гэж нэрлэгддэг хувь хүний үндсэн зан чанарт суурилсан ур чадварыг чухалчилдаг хэвээр байна. Хувь хүний үндсэн өгөгдөлт зан чанар, суурь хүмүүжил, ерөнхий хандлага, ес зүйг хамгийн чухал үзүүлэлт хэмээн үзсээр байгаа нь энэ удаа ч давтагдсан үзүүлэлт болж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд энэ чиг хандлага огт өөрчлөгдөөгүй байдаг.

Зураг 28. Ажил олгогчдын чухалчилдаг зөөлөн ур чадварын шаардлага

/Ач холбогдлын зэргээр, 1- огт чухал биш, 2-чухал биш, 3-чухал, 4-маш чухал/




Зөөлөн ур чадвар /soft skills/- ын хувьд ач холбогдлоор нь эрэмбэлэн харвал ажил олгогчид шинэ ажилтан авахдаа ажил горилогчийн бие даан ажиллах чадвар, найдвартай, хариуцлагатай байдал, эерэг зөв хандлагатай

байдал, харилцааны ур чадвар, цаг ашиглах чадварыг хамгийн ихээр чухалчилж байгааг харж болох юм. Эдгээр үзүүлэлтүүд жил бүрийн судалгааны үр дүнгээр тогтмол нэрлэгддэг төдийгүй энэ төрлийн бусад асуултад хамгийн өндөр давтамжтай нэрлэгдсээр байдаг. Түүнчлэн ачаалал даах, багаар ажиллах чадвар нь ажил олгогчдод чухал ач холбогдолтой, нэн тэргүүнд шаардах ур чадвар байсаар байна.

Мэргэжлийн ур чадварын шаардлагын хувьд ажлын ёс зүй, ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдлэг, түүнтэй холбоотой чадвар нь онцгойлон авч үзэх ур чадвар тул ажил олгогчид мэргэжлийн ур чадваруудаас хамгийн чухал ач холбогдолтой ур чадварын нэгээр нэрлэсэн байна.

Зураг 29. Ажил олгогчдын чухалчилдаг мэргэжлийн ур чадварын шаардлага



Харин гадаад хэлний мэдлэг, шинжлэх ухаан технологийн мэдлэг, математик сэтгэлгээ, тооцоолон бодох чадвар, задлан шинжлэх чадвар, компьютерийн мэдлэг, баримт бичиг боловсруулах чадвар зэрэг мэргэжлийн хувьд шаардах ур чадварыг шинэ ажилтнаасаа төдийлөн шаардахгүй хэвээр байгаа нь үзүүлэлт тус бүрт эзлэх чухал биш гэсэн хариулт 36.0-53.0 хувь байгаагаас харж болно. Харин зөөлөн ур чадварын шаардлагын хувьд энэ үзүүлэлт хамгийн ихдээ 21.2 хувийг эзэлж байна.

Ажил олгогчид зөв харилцаа, төлөвшилтэй ажилтанд ажил мэргэжлийн ур чадварыг байгууллагын хүний нөөцийн бодлого, шинэ ажиллагчдад чиглэсэн сургалт, дэмжлэгээр хөгжүүлэх боломжтой гэж үздэг бөгөөд энэ нь байгууллагын дотоод соёл болсон нь түгээмэл байдаг байна. Ажиллах хүчний эрэлттэй аж ахуйн нэгжийн 68.6 хувь нь шинэ ажилтнаа өөрийн хөрөнгөөр сургах төлөвлөгөөтэй байгаагаас харж болно. Улаанбаатар хотын ажил олгогчдын 73.7 хувь нь шинэ ажилтнаа сургана гэжээ.


Ажил олгогчдын зүгээс шаардаж буй ур чадварын шалгуур, шаардлагыг судалгааны асуулгад өгөгдсөн дээрх үзүүлэлтүүдийн хүрээнд тодорхойлохоос гадна тухайн ажил олгогчдод шаардлагатай ажиллах хүчний хувьд шаардах боловсролын түвшин, мэргэжлийн ур чадварыг тодруулсан бөгөөд ажил мэргэжлийн онцлогоос үл хамааран ажлын туршлагатай байх, ажлын ачаалал

даах, тууштай ажиллах гэсэн шаардлагыг эрэлттэй байх ажил мэргэжил бүрийн хүрээнд дурьдагдсан байна.

Салбарын онцлог, нарийвчилбал ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалан ажил мэргэжил бүрийн ажиллах хүчинд шаардагдах мэргэжлийн ур чадвар болон боловсролын шаардлага нь харилцан адилгүй бөгөөд мэргэжлийн дагуу тусгай эрх, зөвшөөрөлтэй байх, мэргэжлийн программ хангамж дээр ажиллах чадвартай байх зэрэг шалгуурыг голчлон тавьжээ.

Барилгын болон үйлдвэрлэл аж ахуйн туслах ажилтан, ачигч, харуул хамгаалалтын ажилтанд тавьж буй гол шаардлага нь ажлын ачаалал даах чадвар болон хамгийн багадаа 1-2 жилийн ажлын туршлагыг хамгийн их дурьджээ. Жолооч, тогооч, гагнуурчин гэх ажил мэргэжлийн хувьд ажил олгогчид мэргэжлийн үнэмлэхтэй байхыг шаардаж байгаа бөгөөд тогооч, гагнуурчин ажил мэргэжлийн хувьд үүнээс гадна мэргэжлийн зэрэгтэй байх нь давуу талтай гэж үздэг хэвээр байна.

Зураг 30. Шинэ ажиллагчдаас шаардах боловсролын доод түвшин, хувиар



Харин ажил мэргэжил бүрд шаардах боловсролын доод түвшний хувьд ажил мэргэжлийн 42.1 хувьд бакалавр болон түүнээс дээш боловсролтой байх шаардлагатай гэж үзсэн бол 31.8 хувьд бүрэн дунд болон түүнээс дээш, 8.2 хувьд техник мэргэжлийн дунд болон түүнээс дээш, 9.1 хувьд техникийн болон мэргэжлийн боловсрол шаардлагатай бол боловсрол шаардахгүй тохиолдол 2.9 хувийг эзэлж байна.

### 2.3. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЦОМХОТГОЛ

Цаг үеийн нөхцөл байдал, бусад шалтгааны улмаас ажил олгогчдод ажиллах хүчний эрэлт бий болохоос гадна ажиллагчдаа цомхотгох шаардлага үүсдэг. Энэ жил ажил олгогчдын маш бага хэсэг буюу 1.6 хувь нь ажиллагчдаа цомхотгох төлөвлөгөөтэй байгаа гэсэн ч өмнөх жилийн судалгааны дүнгээс 0.3 пунктээр өсөх төлөвтэй байна. Үүнээс үүдэн 5.2 мянган ажилтан ажлаас халагдах эрсдэлд байна. Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын хувьд бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбар, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа салбарт цомхотгол голлон явагдах төлөвтэй.

Ажиллагчдаа цомхотгол ААНБ-ын 62.3 хувь нь Улаанбаатар хотод харьяалагдаж буй бол 13.1 хувь нь Баруун бүсэд, 12.1 хувь нь Зүүн бүсэд хамааралтай байна. Ажиллагчдын тооны бүлгээр 89.5 хувь нь 1-9 хүртэлх ажиллагчидтай ААНБ-ууд байна.



Цомхотголын улмаас ажлаас халагдах эрсдэл бүхий 5.2 мянган ажиллагчдын 36.8 хувь нь ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарт 16.2 хувь нь барилгын салбарт, 14.9 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарт харьяалагдаж байна.

Цомхотголын шалтгааныг тодруулбал 32.4 хувийг коронавируст халдвар, цар тахлын улмаас байгууллага үйл ажиллагаагаа зогсоосон, 36.3 хувийг хөрөнгө санхүүгийн хомсдолтой холбоотой хүндрэл эзэлж, 23.9 хувь нь үйл ажиллагаагаа зогсоосон гэсэн бол байгууллагын бүтэц зохион байгуулалттай холбоотой хүндрэл маш багахан хувийг бүрдүүлж байна.

## 2.4. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХОМСДОЛ

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгааны нэг зорилт нь судалгаа явагдсан нэг жилийн хугацааны хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний хомсдолыг илрүүлэх явдал бөгөөд эдийн засгийн салбар ба бүсүүдэд эрхэн тархаж буйг тодорхойлдог.

Өнгөрөгч онд аж ахуйн нэгж байгууллагын 19.1 хувь нь шаардлагатай мэргэжилтэй ажилтан олдоогүйн улмаас төлөвлөсөн ажилтнаа авч чадаагүй буюу ажиллах хүчний хомсдолд өртсөн гэсэн нь өмнөх оноос 0.7 пунктээр өссөн үзүүлэлт болжээ. Ажиллах хүчний хомсдолыг эх олонлогт тархааж үзвэл жилийн хугацаанд 36.9 мянган ажиллах хүчний хомсдол үүссэн нь 14.3 мянгаар өссөн үзүүлэлт болжээ. Түүнчлэн ААНБ-ын 24.4 хувь нь COVID-19 цар тахлын нөлөөгөөр ажиллах хүчний хомсдолд өртсөн гэжээ.

### Байршлаар

Улаанбаатар хотын ажил олгогчдын 19.2 хувь нь ажиллах хүчний хомсдолд өртсөн ба эдгээр ААНБ-уудад 26.3 мянган ажлын байр байсан нь нийт хомсдолтой ажиллах хүчний 71.2 хувийг эзэлж байна. Цар тахлын улмаас ажиллах хүчний хомсдолд өртсөн ААНБ-ын 69.8 хувь Улаанбаатар хотын ажил олгогчид байгаа бөгөөд 12.4 хувь нь Төвийн, 7.8 хувь нь Хангайн бүсийн ажил олгогчид байна.

Зураг 31. Шаардлагатай мэргэжилтэй ажилтан олдоогүйгээс ажилтан авч чадаагүй байдал, бүсээр, хувиар



Төвийн бүсийн ажил олгогчдын 24.1 хувь, Зүүн бүсийн 24.0 хувь, Хангайн бүсийн 17.8 хувь, Баруун бүсийн ажил олгогчдын 10.4 хувь нь ажиллах

хүчний хомсдолд өртжээ. Баруун бүс болон Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын ажиллах хүчний хомсдолд өртсөн хувь өмнөх оны судалгааны дүнгээс буурсан байна. Харин Төв болон Хангайн, Зүүн бүсийн ажил олгогчдын хувьд уг үзүүлэлт өссөн байгаа бөгөөд энэ хэмжээгээр эдгээр бүсийн ажил олгогчид бүрэн хүчин чадлаар ажиллах боломжоо алдсан байна.

Өнгөрсөн жилийн хугацаанд улсын хэмжээнд үүссэн ажиллах хүчний хомсдолын 28.8 хувь буюу 10.6 мянга нь орон нутгийн хэмжээнд байжээ. Хангайн бүсэд 6.6 хувь буюу 2.4 мянга, Баруун бүсэд 4.9 хувь буюу 1.8 мянга, Зүүн бүсэд 4.0 хувь буюу 1.5 мянган ажиллах хүчний хомсдол байжээ.

Хүснэгт 29. Ажиллах хүчний хомсдол, бүсээр, хүйсээр

Бүс	Хомсдолтой ажиллах хүчний тоо /мян.хүн/		Дүнд эзлэх хувь	
	Нийт	Үүнээс: эмэгтэй	Нийт	Үүнээс: эмэгтэй
Баруун	1.8	0.7	4.9	5.5
Хангай	2.4	0.9	6.6	7.4
Төв	4.9	1.8	13.3	14.2
Зүүн	1.5	0.7	4.0	5.5
Улаанбаатар	26.3	8.4	71.2	67.4
Нийт	36.9	12.5	100	100

Төвийн бүсэд ажиллах хүчний хомсдол 1.8 мянга хүрч өссөн нь ажиллах хүчний улсын хэмжээнд дэх хомсдолын 13.3 хувь, орон нутгийн ажиллах хүчний хомсдолын 46.1 хувийг дангаараа бүрдүүлж байна.

### Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Ажиллах хүчний хомсдолд өртсөн нийт ААНБ-уудын 35.0 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд ажиллах хүчний хомсдолын 29.2 хувийг тухайн салбарын хомсдол эзэлж байна. Үүнээс гадна барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажил олгогчид ажиллах хүчний хомсдолд өртсөн аж ахуйн нэгжүүдийн 21.4 хувийг эзэлж, эдгээр салбарын ажиллах хүчний хомсдол нийт хомсдолын 32.2 хувийг бүрдүүлж байна. Үүнээс үзэхэд өнгөрсөн жил зөвхөн дээрх салбаруудын ажиллах хүчний хомсдолоос үүдэлтэй 22.6 мянган ажлын байр байжээ. Харин ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, цахилгаан, хий агааржуулалтын салбар, урлаг, үзвэр, тоглоом наадам, уул уурхай, олборлолтын салбарын ажил олгогчид ажиллах хүчний хомсдолд өртсөн тохиодолд эзлэх хувь хамгийн бага байна. Гэвч тухайн салбарын ААНБ-д эзлэх хувиар харвал ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын ажил олгогчдын 33.7 хувь, цахилгаан, хий агааржуулалтын салбарын ажил олгогчдын 30.9 хувь нь ажиллах хүчний хомсдолд өртөж, үүний хүрээнд дээрх 2 салбарт 5.9 мянган ажлын байр сул байжээ.

Хүснэгт 30. Ажиллах хүчний хомсдол, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажиллах хүчний хомсдол		Үүнээс: эмэгтэй	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.2	3.2	0.1	0.7
Уул уурхай, олборлолт	0.9	2.4	0.0	0.0
Боловсруулах үйлдвэрлэл	5.9	16.1	2.3	18.6
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.3	0.7	0.0	0.0
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.3	0.9	0.0	0.0
Барилга	6.0	16.1	0.6	5.1
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ	10.8	29.2	4.3	34.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.4	3.7	0.0	0.4
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1.8	5.0	1.0	8.4
Мэдээлэл, холбоо	1.0	2.8	0.2	1.8
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0.4	1.0	0.3	2.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.4	1.2	0.2	1.4
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.2	3.2	0.3	2.6
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.0	2.8	0.7	5.3
Боловсрол	1.2	3.3	0.7	5.6
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1.6	4.4	1.2	9.7
Урлаг, үзвэр, тоглоомнаадам	0.3	0.9	0.1	0.9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.1	3.1	0.4	3.3
Нийт	36.9	100	12.5	100

Салбарын ажиллах хүчний хомсдолд эмэгтэйчүүдийн эзлэх хувиар харвал хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын ажиллах хүчний хомсдолын 73.9 хувь, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа салбарын 71.5 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын хомсдолын 64.6 хувьд эмэгтэй ажиллагчдын хэрэгцээ байжээ.

Нийт ажиллах хүчний хомсдолд хувийн өмчийн ААНБ-ууд ажиллах хүчний хомсдолд хамгийн их өртсөн бөгөөд нийт хомсдолтой ажиллах хүчний 92.0 хувь болох 34.0 мянган ажилтан авч ажиллуулж чадаагүй бөгөөд үүний 33.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. ААНБ-ын ажиллагчдын тооны бүлгээр харвал хомсдолтой ажиллагчдын 80.9 хувь 30 хүртэлх ажиллагчидтай жижиг аж ахуйн нэгжид харьяалагдаж байна.

### Ажил мэргэжлээрх ажиллах хүчний хомсдол

Ажиллах хүчний хомсдолыг ажил мэргэжлийн хувьд авч үзвэл “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан” бүлгийн ажил мэргэжлийн ажилтны хомсдол 17.8 хувь, “Мэргэжилтэн” бүлэгт хамаарах ажил мэргэжлийн ажилтны хомсдол 17.3 хувь, “Худалдаа, үйлчилгээний ажилтан” бүлгийн ажил мэргэжлийн ажилтны хомсдол 12.8 хувь, “Суурин төхөөрөмж,

машин механизмын операторч, угсрагч” бүлгийн ажил мэргэжлийн ажилтны хомсдол 9.6 хувийг эзэлж буй бол энгийн ажил мэргэжлийн ажилтны хомсдол 30.4 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Эдгээр нь нийт ажиллах хүчний хомсдолын 87.9 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 31. Ажиллах хүчний хомсдол, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр, хувиар

Үндсэн бүлгийн дугаар	Ажил мэргэжлийн ангилал	Дүнд эзлэх хувь
1	Менежер	2.0
2	Мэргэжилтэн	17.3
3	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	8.3
4	Контор үйлчилгээний ажилтан	1.3
5	Худалдаа, үйлчилгээний ажилтан	12.8
6	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	0.4
7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	17.8
8	Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	9.6
9	Энгийн ажил мэргэжил	30.4
	НИЙТ	100

Ажил мэргэжил хувьд хамгийн их хомсдолтой байсан нь үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан, барилгын туслах ажилтан, ачигч, харуул, албан байгууллагын цэвэрлэгч гэх мэт энгийн ажил мэргэжлийн хомсдол 24.3 хувийг бүрдүүлж байна. Түүнчлэн тогооч, жолооч, зөөгч, засалчин, шаварчин, гагнуурчин, дэлгүүрийн кассчин, цахилгаанчин, өнгөлгөөний болон барилга угсралтын мужаан зэрэг ажил мэргэжлүүд 18.2 хувь, механик инженерийн техникч, цахилгааны инженер, сувилагч, арга зүйч, ахлах нягтлан бодогч, малын эмч зэрэг ажиллах хүчний хомсдол 5.6 хувийг эзэлжээ. Дээр дурьдагдсан ажил мэргэжлийн ажиллах хүчин хомсдол 2021 оны ажиллах хүчний хомсдолын 54.2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 32. Хомсдолтой ажил мэргэжил, дүнд эзлэх хувиар

Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь	Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь
1	932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	13.7	11	311513	Механик инженерийн техникч, автомашины	1.4
2	931311	Туслах ажилтан, барилга угсралтын	6.6	12	541411	Харуул, гэрээт албаны	1.3
3	521111	Мухлаг /лангууны худалдагч	5.1	13	711512	Өнгөлгөөний мужаан	1.2
4	343412	Тогооч, ерөнхий	4.9	14	215111	Инженер, цахилгааны	1.2
5	712314	Шаварчин засалчин, засал чимэглэлийн	2.7	15	911214	Цэвэрлэгч, албан байгууллагын	1.2
6	721214	Гагнуурчин	2.6	16	222101	Сувилагч, арга зүйч	1.1
7	833213	Жолооч, ачааны тэрэгний	2.6	17	524212	Борлуулагч	1.1

8	523011	Дэлгүүрийн кассчин	1.6	18	711511	Барилга угсралтын мужаан	1.1
9	933315	Ачигч, агуулахын	1.6	19	241112	Ахлах нягтлан бодогч	1.0
10	741111	Цахилгаанчин	1.5	20	225011	Малын эмч	0.9

Ажил мэргэжлээрх хомсдолын мэдээллийг харахад тухайн онд хомсдолтой байсан ажил мэргэжлийн ажиллах хүчний эрэлт хангагдаагүйгээс судалгааны мэдээлэл цуглуулах үеийн нээлттэй зарласан ажлын байрны мэдээлэлд нэрлэгдэж, түүгээр зогсохгүй ирэх оны ажиллах хүчний эрэлтэд ч өндөр хувьтай дурьдагдаж, хөдөлмөрийн зах зээлд гол нөлөөг үзүүлсээр байна. Энэ нь тодорхой хэдэн ажил мэргэжлийн ажиллах хүчний хүрээнд явагдаж байна.

## 2.5. АЖИЛ ОЛГОГЧДИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ

### Сургалт, арга хэмжээ


Ажил олгогчид ажиллагчдаа чиглэсэн хөгжүүлэх болон мэргэшүүлэх сургалт арга хэмжээ, төлөвлөх, зохион байгуулах нь байгууллагын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг бөгөөд үүнийг тодруулсан үр дүнг авч үзье.

Сүүлийн 12 сарын хугацаанд ажил олгогчдын 19.7 хувь нь ажиллагчдаа чиглэсэн сургалт арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд эдгээрийн 82.5 хувь нь хувийн өмчийн байгууллагууд, 82.5 хувь нь 30 хүртэлх ажиллагчидтай аж ахуйн нэгжүүд байна.

Ажил олгогчдын 19.7 хувь нь байгууллага дотооддоо сургалт зохион байгуулах, гадаад болон дотоодын сургалт, арга хэмжээнд хамруулсан нь өмнөх оны мөн үр дүнгээс 7.2 пунктээр буурсан үзүүлэлт болж байна.

Зохион байгуулсан гадаад, дотоодын нийт сургалт, арга хэмжээний 29.1 хувь нь ажилтныг ажил мэргэжлийн хувьд мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, 25.5 хувь нь хувь хүнийг хөгжүүлэх, 20.0 хувь нь мэргэжил дээшлүүлэх, 19.9 хувь нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлийн сургалт байсан бол 5.5 хувь нь мэргэжил олгох сургалт байна.

Зураг 32. Ажиллагчдад чиглэсэн сургалт, арга хэмжээ, хувиар



Сургалт, арга хэмжээний зардал нь жижиг болон томоохон ААНБ-ын хувьд харилцан адилгүй бөгөөд 1-9 хүртэлх ажиллагчидтай аж ахуйн нэгжийн хувьд

дундаж зардал 13.4 сая төгрөг, 10-29 ажиллагчидтай аж ахуйн нэгжийн хувьд дундаж зардал нь 4.5 сая төгрөг бол 50-149 ажиллагчидтай ажил олгогчдын хувьд 65.0 сая, 150 болон түүнээс дээш ажиллагчидтай ажил олгогчдын хувьд дундаж зардал 27.4 сая төгрөг байна.

### **Ажил олгогчдын шинэ ажилтан авахдаа ашигладаг мэдээллийн эх сурвалж**

Судалгаагаар аж ахуйн нэгж, байгууллагын шинээр ажилтан авахад ашигладаг мэдээллийн эх сурвалж, шинэ ажилтан сонгон шалгаруулж авах, ажиллуулахад тулгардаг хүндрэл бэрхшээл зэрэг асуудлын талаар тодруулдаг.

Өмнөх жилүүдийн адилаар цахим орчинд ажлын байрны мэдээлэл түгээх байдлаар ажилтнаа сонгон шалгаруулж, хүний нөөцөө бүрдүүлдэг арга аж ахуйн нэгж, байгууллагуудад зонхилсон хэвээр байна. Шинэ ажилтан авахад ашигласан мэдээллийн эх сурвалжийн 26.3 хувийг дээрх төрлийн эх сурвалж эзэлж, 19.3 хувийг албан бус байдлаар буюу хувийн харилцаа, холбоогоор, 17.1 хувь нь зар сурталчилгаа, мэдээллийн хэрэгслээр нийтлэх байдлаар сонгодог гэсэн бол ажил хайгч иргэд өөрөө ажил олгогчид хандах нь 11.7 хувийг эзэлж байна.

*Зураг 33. Шинэ ажилтан авахад ашигладаг мэдээллийн эх сурвалж, хувиар*



Түүнчлэн, сургууль, сургалтын байгууллагаар дамжуулан ажиллах хүчнээ сонгох, бусад байгууллагаас туршлагатай ажиллагчийг урих болон бусад эх сурвалжууд 4.0 хувийг бүрдүүлж байна. Харин хөдөлмөр зуучлалын төрийн үйлчилгээ буюу хөдөлмөр, халамжийн хэлтсүүдийн хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системийг ашигладаг байдал 5.3 хувь байгаа бөгөөд 3.3 хувь нь хувийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг нэрлэсэн байна. Нийслэлд хувийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, ажлын байрны яармагаас ажиллах хүч, ажлын байрны хэрэгцээт мэдээллийг авах тохиолдол түгээмэл бол орон нутагт энэ төрлийн төрийн үйлчилгээний хэрэглээ түлхүү байдаг.

### **Шинэ ажилтан авахад тулгардаг бэрхшээл**

Ажил олгогчдод шинэ ажилтан авахад хүндрэл бэрхшээл тохиолддог эсэхийг тодруулахад нэрлэсэн үзүүлэлтийн 20.0 хувийг хүндрэл бэрхшээл учирдаггүй гэжээ.

Харин 17.5 хувийг ажиллагч тогтвортой ажиллах хүсэлгүй байх, 16.9 хувийг ажлын байрны нөхцөл, цалин хөлс голох, 12.8 хувийг ажлын ачаалал

даах чадваргүй байдал, 11.4 хувийг тухайн ажил хайгчийн ажлын туршлагагүй байдал гэсэн бэрхшээлүүд эзэлж байна.

Зураг 34. Шинээр ажилтан авахад болон ажиллуулахад тулгардаг нийтлэг бэрхшээл, хувиар



Шинээр ажилтан авахад тулгарч буй гол бэрхшээл нь дээр дурдсанчлан ажил гориллогчийн хувь хүний хандлага, хариуцлагатай холбоотой асуудлууд байсаар байна. Ажил гориллогчийн боловсролын түвшин болон хэлний мэдлэгийн түвшний хангалтгүй байдал асуудал бэрхшээлийн 8.5 хувийг эзэлж буй бол нас, хүйс болон гадаад төрх, бие бялдрын хөгжилтэй холбоотой асуудал бага хувийг эзэлж байна.

Энэ удаагийн судалгааны дүнгээр хамгийн түгээмэл тохиолддог бэрхшээлд ажиллагч тогтвортой ажиллахгүй байх, ажлын туршлагагүй байдал хэмээн дурдсан бөгөөд энэ нь жил бүрийн судалгааны дүнд тогтмол нэрлэгдсээр байна.

## 2.6. ӨМНӨХ СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгааг бид 10 гаруй жил гүйцэтгэж байгаа нь судалгааны гол үр дүнг өмнөх судалгааны үзүүлэлтүүдтэй харьцуулан үзэхийг боломжийг олгодог.


Жил бүрийн судалгааны түүвэрт 50-аас доош ажиллагчидтай ААНБ-ын эзлэх хувь хамгийн өндөр байдаг бөгөөд энэ жилийн судалгааны хувьд ч ажил олгогчдын 71.9 хувийг эзэлж байгаа бол 50-аас дээш ажиллагчидтай ААНБ 17.8 хувь, 150-аас дээш ажиллагчидтай ААНБ 10.3 хувийг бүрдүүлж байна.

Олон жилийн ажиллах хүчний эрэлтийн ерөнхий чиг хандлага, ажил олгогчдын төлөвлөгөөнөөс дотоодын хөдөлмөрийн зах зээл цаашид өсөн нэмэгдэх, хөгжих боломж харагддаг бөгөөд энэ жилийн хувьд улс орны эдийн засгийн онцгой нөхцөл байдал үүссэн хэдий ч зах зээл эргэн сэргэх хандлагатай байгаа нь ажиллах хүчний эрэлтээс харагдаж байна.

Жил бүрийн судалгааны дүнгээс хөдөлмөрийн зах зээлд улирлын нөлөөлөл байнга ажиглагддаг бөгөөд үүнийг ажиллах хүчний эрэлтээс харж болно. Тухайлбал нэг жилийн ажиллах хүчний эрэлтийн гурван ажлын байр тутмын хоёр нь оны эхний хагас жилд бий болох хандлагатай байдаг нь энэ жил судалгааны дүнд ч хадгалагдсан хэвээр байна.

Сүүлийн 10 жилийн хувьд улсын хэмжээнд ажиллах хүчний эрэлт 52.0 мянгаас 80.0 мянган хооронд хэлбэлзэж, дундаж нь 72.9 мянга байсан болж 2019 онд 69.4 мянга, 2020 онд 52.6 мянга болж буурч байсан нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

Зураг 35. Ажиллах хүчний эрэлт, мянган хүнээр, 2013-2022 он




Хөдөлмөрийн зах зээл урт хугацаандаа тэлэх, өргөжих ерөнхий чиг хандлагатай хэдий ч тухайн үеийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан бага хэмжээний хэлбэлзэл байдаг.

Жил бүрийн судалгаагаар эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын хувьд бөөний болон жижиглэн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудад ажиллах хүчний эрэлтийн хэмжээ өндөр байж, ажиллах хүчний эрэлтийн 50-аас дээш хувийг бүрдүүлдэг. Өмнөх жилтэй харьцуулахад ихэнх салбаруудад ажиллах хүчний эрэлт өссөн бөгөөд барилгын салбарын хувьд ажиллах хүчний эрэлт сүүлийн 4 жилд, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын эрэлт сүүлийн 3 жилд буурсан үзүүлэлттэй байсан ч энэ удаагийн үр дүнгээр өсөх төлөв ажиглагдлаа.

Барилгын салбарын ажиллах хүчний эрэлтийн сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлт нь 14.9 мянга бөгөөд хамгийн бага нь 2017 онд 9.8 мянга, хамгийн ихдээ 2014 онд 22.4 мянга байжээ. Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын тухайд ажиллах хүчний эрэлтийн 10 жилийн дундаж үзүүлэлт нь 9.4 мянга бол хамгийн ихдээ 12.3 мянга, багадаа 6.8 мянга байна.

Зураг 36. Ажиллах хүчний эрэлт, тэргүүлэх салбараар, мянган хүнээр



Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбар нь ажиллах хүчний шингээлт өндөртэй төдийгүй хөдөлмөрийн зах



ээлд гол нөлөө үзүүлэхүйц ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн их, салбарын ажиллагчдын хөдөлмөр эрхлэлт тогтворгүй байх хандлагатай, ажиллах хүчний эрэлт ч жил бүр хэлбэлзлэл ихтэй байдаг. Сүүлийн 10 жилийн хугацаан дахь бөөний болон жижиглэн худалдааны салбарын ажиллах хүчний эрэлтийн дундаж үзүүлэлт 15.8 мянга бөгөөд багадаа 5.5 мянга, хамгийн өндөр нь 24.5 мянга байжээ. Харин 2022 онд эрэлт 23.9 мянга болж өсөх үр дүн гарсан. Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын хувьд 10 жилийн дундаж үзүүлэлт нь 3.5 мянга бөгөөд он хооронд хэлбэлзлэл ихтэй байдаг салбар юм. Хөдөө аж ахуйн салбарын ажиллах хүчний эрэлтийн дундаж 4.9 мянга, хамгийн ихдээ 12.9 мянгад хүрч үүнээс хойш буурах хандлагатай байсан ч сүүлийн 2 жилийн турш өссөн ч энэ 2022 онд буурах төлөвтэй байна. Харин уул уурхай, олборлолтын салбар нь дээрх салбаруудтай харьцуулахад ажиллах хүчний эрэлт төдийлөн өндөр биш, судалгааны үр дүнгийн дундаж үзүүлэлт 2.5 бөгөөд хамгийн ихдээ 4.5 байх төлөв гарч, үүнээс хойш он хооронд харилцан адилгүй өсөх, буурах хэлбэлзлэлтэй байжээ.

Бүс нутгийн хүрээнд авч үзвэл ажиллах хүчний эрэлтийн ихэнх хувийг Улаанбаатар хотын ажиллах хүчний эрэлт бүрдүүлдэг бөгөөд сүүлийн 5 жилийн дунджаар харвал 49.5 мянга байгаа бөгөөд 2021 оны хувьд 37.2 мянга байгаа нь хамгийн бага, 2022 онд 55.2 мянгад хүрэх нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Түүнчлэн, ажиллах хүчний эрэлтэд эзлэх хувийн жин өндөр буюу 70.0 гаруй хувийг бүрдүүлдэг. Бүсүүдээс Төвийн бүсийн ажиллах хүчний эрэлт нийт эрэлтэд эзлэх хувийн жингээр жил бүр өндөр ч, он хооронд хэлбэлзлэлтэй байдаг.


Зураг 37. Ажиллах хүчний эрэлт, бүс нутгаар, мянган хүнээр



Улаанбаатар хотын хөдөлмөрийн зах зээлийн багтаамж 2021 онд огцом буурсан ч 2022 онд эргэн тэлэх, цаашдаа өргөжин тэлэх ерөнхий чиг хандлагатай байгаа нь сүүлийн 5 жилийн үр дүнгээс харагдаж байна. Төвийн бүс, Хангай болон Баруун бүсийн хөдөлмөрийн зах зээлийн багтаамж он хооронд өсөж буурах харилцан адилгүй хэлбэлзлэлтэй байна. Зүүн бүсийн ажиллах хүчний эрэлт нийт эрэлтэд эзлэх хувийн жин төдийлөн их биш, жилийн дундаж 2.5 мянга бөгөөд өсөх хандлагатай байсан хэдий ч 2022 оны байдлаар буурах үр дүн гарчээ.

Судалгааны 10 жилийн дунджаар харвал ажиллах хүчний эрэлтийн 65-аас дээш хувь нь тухайн оны эхний хагаст бий болох үр дүн гардаг. Энэ үзүүлэлт дунджаар 70-аас дээш хувь, хамгийн ихдээ 80-аас дээш хувь байх тохиолдол ч байжээ.


Зураг 38. Ажиллах хүчний эрэлт, хугацаагаар, хувиар



2022 оны хувьд жилийн эхний хагаст харьяалагдах ажиллах хүчний хувь буурсан үзүүлэлт бол эсрэгээрээ оны сүүлийн хагаст харьяалагдах ажиллах хүчний эрэлтийн хувийн жин 2 пунктээр өсөх төлөв гарсан байна.

Жил бүрийн судалгааны дүнгээр нийт ажиллах хүчний эрэлтийн 70-аас дээш хувь нь байнгын ажлын байр байдаг. Энэ үзүүлэлт жил ирэх бүрт өсөх хандлагатай бөгөөд 2022 оны хувьд ажиллах хүчний эрэлтийн хүрээн дэх нийт ажлын байрны 84.3 хувийг бүрдүүлж байгаа нь өмнөх оноос өсөх дүн төдийгүй хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Зураг 39 . Ажиллах хүчний эрэлт, ажлын байрны хэлбэрээр, хувиар



Судалгааны сүүлийн 10 жилийн дунджаар нийт ажиллах хүчний эрэлтийн хүрээнд дэх ажлын байрны 71.5 хувь буюу 10 ажлын байр тутмын 7 нь байнгын ажлын байр байна.

Судалгааны жил бүрийн үр дүнгээр шинэ ажлын байран дахь ажиллах хүчний эрэлт дийлэнх бөгөөд энэ нь хөдөлмөрийн зах зээлд нэн таатай үзэгдэл юм. Ажиллах хүчний эрэлтийг ажлын байрны төрлөөр тооцох үзүүлэлтийг 2014 оноос гаргаж эхэлсэн. Үүнээс хойш 9 жилийн дунджаар ажиллах хүчний эрэлт бий болж буй ажлын байрны 58.2 хувь нь шинээр бий болох ажлын байр байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчний цэвэр өсөлт бий болох боломжийг олгох бөгөөд дотоодын хөдөлмөрийн зах зээл тэр хэмжээгээр тэлэх бололцоотой болж байгаа юм.

Зураг 40. Ажиллах хүчний эрэлт, ажлын байрны төрлөөр, хувиар



Шинэ ажлын байрны ажиллах хүчний эрэлт 2014 онд нийт эрэлтийн 37.0 хувийг бүрдүүлж байсан бол 2022 онд хамгийн их буюу 69.8 хувийг эзэлж байна.

Бид энэхүү судалгааны үр дүнд тулгуурлан хөдөлмөрийн зах зээлийн богино хугацаанд эрэлттэй байгаа ажил мэргэжлийг мөн харьцуулан харах боломж бүрддэг. Энэ нь судалгааны ач холбогдлыг харуулахуйц мэдээлэл болдог.

Хүснэгт 33. Эрэлттэй ажил мэргэжил, оноор

2022 онд эрэлттэй байх ажил мэргэжил		2021 онд эрэлттэй байх ажил мэргэжил	
ISCO	Ажил мэргэжлийн нэр	ISCO	Ажил мэргэжлийн нэр
932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	832211	Жолооч, машины
931311	Туслах ажилтан, барилга угсралтын	931211	Туслах ажилтан, барилгын туслах
833213	Жолооч, ачааны тэрэгний	335916	Мэргэжилтэн, итгэмжлэлийн үнэлгээний, баталгаажуулалтын
212021	Шинжээч, даатгалын тооцооллын	711511	Барилга угсралтын мужаан
521111	Мухлаг /лангууны худалдагч	932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан
911214	Цэвэрлэгч, албан байгууллагын	612111	Мах, цагаан идээ үйлдвэрлэгч
343411	Тогооч	343411	Тогооч
711511	Барилга угсралтын мужаан	541411	Харуул, гэрээт албаны
541411	Харуул, гэрээт албаны	752222	Нарийн мужаан
933315	Ачигч, агуулахын	122111	Дарга, эрхлэгч /менежер/, алба, хэлтэс, тасгийн /борлуулалтын/
524212	Борлуулагч	331314	Нягтлан бодогч, төлбөр тооцооны
513111	Зөөгч	911214	Цэвэрлэгч, албан байгууллагын
522313	Дэлгүүрийн туслах ажилтан	333412	Менежер, үл хөдлөх хөрөнгийн
711411	Арматурчин	523011	Дэлгүүрийн кассчин
933316	Ачигч, дэлгүүрийн	332211	Төлөөлөгч, борлуулалтын
721214	Гагнуурчин	521111	Мухлаг /лангууны худалдагч
941211	Гараар аяга таваг угаагч	122112	Дарга, эрхлэгч /менежер/, алба, хэлтэс, тасгийн /маркетингийн/

816012	Операторч, талх жигнэх машины	721214	Гагнуурчин
911118	Үйлчилгээний болон энгийн ажлын зохион байгуулагч	214111	Инженер, аж үйлдвэрийн
222102	Сувилагч, ерөнхий мэргэжлийн	222102	Сувилагч, ерөнхий мэргэжлийн

Судалгаа хийгдсэн 10 гаруй жилийн хугацаанд ажил мэргэжлээрх ажиллах хүчний эрэлтийг харахад хөдөлмөрийн зах зээлд хэдэн нийтлэг төлөв тогтмол ажиглагддаг. Тухайлбал,

Ажиллах хүчний эрэлт өндөртэй байх салбарын ажил мэргэжлүүд эрэлттэй ажил мэргэжлийн ангиллыг бүрдүүлдэг хэвээр байна.

Сүүлийн 12 сард ажлаас гарсан ажиллагчдын ажил мэргэжлийн хүрээнд эрэлт өсөх хандлага жил бүрийн үр дүнд ажиглагдаж байна.


Бидний нэрлэж заншсанаар нарийн мэргэжил, боловсрол, ур чавдар шаардахгүй энгийн ажил мэргэжлийн ажиллах хүчний эрэлт нийт эрэлтийн ихэнх хувийг бүрдүүлдэг үзэгдэл түгээмэл хэвээр байна. Тодруулбал, барилга болон үйлдвэрлэл аж ахуйн туслах ажилтан, цэвэрлэгч, харуул хамгаалалтын ажилтан нь сүүлийн 10 жил эрэлттэй ажил мэргэжлийн жагсаалтад тогтмол дурдагдаж байна. Энэ нь эдгээр ажил мэргэжлийн ажиллагчидын шилжилт хөдөлгөөн их, хөдөлмөр эрхлэлт тогтворгүй байдагтай шууд хамааралтай юм.

Хөдөлмөрийн зах зээлд дээд боловсролын ажил мэргэжлийн эрэлтээс илүү мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэгддэг ажил мэргэжлийн эрэлт өндөр байх хандлага хадгалагдсаар байна. Тодруулбал, тогооч, зөөгч, жолооч, гагнуурчин, цахилгаанчин гэх мэт ажил мэргэжлийн эрэлт жил бүрийн эрэлттэй ажил мэргэжлийн ангилалд тогтмол нэрлэгдсээр байна. Энэ нь нэг талаас мэргэжилтэй ажиллагчдын хэрэгцээ өндөр мэт боловч, нөгөө талаас эдгээр ажил мэргэжил дэх хөдөлмөр эрхлэлт төдийлөн тогтвортой бус байгааг харуулж байна.

Ажиллах хүчний ажил мэргэжлээрх эрэлтэд өндөр хувийг эзэлж буй мэргэжлийн ажиллах хүчин, нөгөө талаас хомсдолтой ажиллах хүчний жагсаалтад багагүй хувийг эзэлдэг байдал олон жилийн судалгааны үр дүнд хадгалагдсаар байна. Түүнчлэн, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнд оролцогчдод тухайн ажил мэргэжлийн ажиллах хүчин онцгойлон анхаарал татахуйц өндөр байр суурь эзэлж байна. Өөрөөр хэлбэл ажиллагчдын шилжилт хөдөлгөөн тодорхой хэдэн ажил мэргэжлийн ажлын байранд давамгайлж, үүнтэй холбоотой тухайн ажил мэргэжлийн ажиллагчдын хөдөлмөр эрхлэлт тогтворгүй байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий чиг хандлага болоод удаж байна.

Ажиллах хүчний хомсдолын хувьд сүүлийн 9 жилийн хугацааны дундаж үзүүлэлт нь 18.9 мянга бол олон жилийн ерөнхий төлөв нь өсөх хандлагатай байна. Уг үзүүлэлтийн 2017 онд 10.9 мянга болсон нь хамгийн бага түвшин бол 2021 онд 36.9 мянгад хүрсэн нь 9 жилийн хугацааны хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Зураг 41. Ажиллах хүчний хомсдол, мянган хүнээр, 2013-2021 он



Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллын хувьд бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудын ажиллах хүчний хомсдол нийт ажиллах хүчний хомсдолд өндөр хувийг эзэлдэг.

Хүснэгт 34. Хомсдолтой ажил мэргэжил, оноор

2021 оны ажиллах хүчний хомсдол		2020 оны ажиллах хүчний хомсдол	
ISCO	Ажил мэргэжлийн нэр	ISCO	Ажил мэргэжлийн нэр
932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	931211	Туслах ажилтан, барилгын туслах
931311	Туслах ажилтан, барилга угсралтын	832211	Жолооч, машины
521111	Мухлаг /лангууны худалдагч	343411	Тогооч
343412	Тогооч, ерөнхий	523011	Дэлгүүрийн кассчин
712314	Шаварчин засалчин, засал чимэглэлийн	712311	Засалчин, шаварчин
721214	Гагнуурчин	711111	Барилгачин
833213	Жолооч, ачааны тэрэгний	911214	Цэвэрлэгч, албан байгууллагын
523011	Дэлгүүрийн кассчин	541411	Харуул, гэрээт албаны
933315	Ачигч, агуулахын	932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан
741111	Цахилгаанчин	931312	Туслах ажилтан, барилга буулгах
311513	Механик инженерийн техникч, автомашины	833214	Жолооч, тэргэнцрийн /уул уурхайн/
541411	Харуул, гэрээт албаны	241111	Аудитор
711512	Өнгөлгөөний мужаан	122111	Дарга, эрхлэгч /менежер/, алба, хэлтэс, тасгийн /борлуулалтын/
215111	Инженер, цахилгааны	612120	Фермийн ажилтан, мэргэшсэн /сүүний/
911214	Цэвэрлэгч, албан байгууллагын	932112	Савлагч /гараар/
222101	Сувилагч, арга зүйч	513111	Зөөгч
524212	Борлуулагч	752222	Нарийн мужаан
711511	Барилга угсралтын мужаан	751518	Зэрэг тогтоогч, махны
241112	Ахлах нягтлан бодогч	214211	Инженер, барилгын технологийн
225011	Малын эмч	216612	Графикч дизайнч, зураглаач

Ажиллах хүчний хомсдолыг ажил мэргэжлээр харахад туслах ажилтнуудаас гадна сувилагч, нягтлан бодогч, арматурчин, тогооч, зөөгч, жолооч, засалчин, шаварчин зэрэг ажил мэргэжлийн ажиллах хүчний хомсдол байсаар байна. Нийлүүлэлтийн зөрүү байгаа хэдий ч эдгээр ажил мэргэжлийн ажиллагчдын шилжилт хөдөлгөөн буюу эргэлт маш их байгаатай хамгийн их хамааралтай байна.

Тухайн онд хомсдолтой байсан ажил мэргэжлийн хувьд дараа дараагийн оны ажиллах хүчний эрэлтэд нэрлэгдэх үзэгдэл түгээмэл тохиолдсоор байна.

## ДҮГНЭЛТ

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд 2022 онд 78.0 мянган ажиллах хүчний эрэлт үүсэх нь ажиллах хүчний 6.9 хувийг эзэлж байна. Тэдгээрийн 72.9 хувь нь оны эхний хагаст, үлдсэн 27.1 хувь нь сүүлийн хагаст бий болох төлөвтэй байна.

Ажиллах хүчний нийт эрэлтийн 30.7 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, 14.7 хувь нь барилгын салбарт, 13.1 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 5.2 хувь нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар, 4.8 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт бий болно.

Ажиллах хүчний эрэлт бүс нутгийн хувьд нэлээд ялгаатай байдаг бөгөөд ихэнх хувь нь Улаанбаатар хотод харьяалагдаж, Хангай болон Төвийн бүсэд нийт ажиллах хүчний эрэлтийн 20.7 хувь ноогдож байна.

Хөдөлмөрийн зах зээлд шинэ ажлын байрны эрэлт өсөх нь хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн цар хүрээ нэмэгдэх боломж байгааг харуулдаг. Энэ удаад байнгын болон шинэ ажлын байрны эрэлт ажиллах хүчний эрэлтэд өндөр хувийг эзэлж буй нь эерэг хандлага болж байна. Нийт ажиллах хүчний эрэлтийн 84.3 хувь нь байнгын, 15.7 хувь нь түр ажиллах хүчний эрэлт, 69.8 хувь нь шинэ, 30.2 хувь нь сул ажлын байрны эрэлт байна.

Харин сүүлийн 12 сарын шинэ ажиллагчдын хүрээн дэх ажлын байрны 57.7 хувь, нээлттэй ажлын байрны 51.4 хувийг сул ажлын байр эзэлж байна. Энэ нь ажиллагчдын салбарын дотоод болон салбар хоорондын шилжилт хөдөлгөөн их буюу хөдөлмөр эрхлэлт тогтворгүй байх үзэгдэл өмнөх жилүүдийн адил байсаар байгааг илтгэж байна. Ажиллагчдын шилжилт хөдөлгөөн 30-аас доош ажиллагчидтай жижиг болон дунд аж ахуйн нэгжүүдэд зонхилж, улмаар хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой бус байдлыг үүсгэж байна.

Ажил олгогчид ажил хайгчийн мэргэжлийн нарийн ур чадвар гэхээс илүүтэй хувь хүний зөөлөн ур чадварыг хамгийн чухал үзүүлэлт гэж үздэг хандлага хэвээр төдийгүй бие даан ажиллах чадвар, найдвартай, хариуцлагатай байдал, эерэг зөв хандлагатай байдал, харилцааны ур чадвар, цаг ашиглах чадварыг хамгийн ихээр чухалчилж үзжээ. Эдгээр зан чанарын зөв төлөвшил бүхий ажил горилогчид мэргэжлийн ур чадварыг дадлага болон төрөл бүрийн сургалт, арга хэмжээгээр эзэмшүүлэх боломжтой гэж үзсэн хэвээр байна. Харин мэргэжлийн ур чадварын хувьд төдийлөн өндөр шаардлага тавихгүй ч, ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдлэг, ажлын ёс зүйтэй байх, шинэ санаа гаргах чадварыг илүүд үзэж, боловсролын түвшний тухайд тодорхой хэмжээний боловсрол эзэмжсэн байх шаардлагыг түлхүү дурьдсан байна.

Өнгөрсөн онд аж ахуйн нэгж байгууллагуудад нийт 36.9 мянган ажиллах хүчний хомсдол бий болжээ. Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар үзвэл бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбаруудад хамгийн их хомсдол үүссэн ба ажиллах хүчний нийт хомсдолын 61.4 хувь нь ногдож байна.

Ажил мэргэжлээрх ажиллах хүчний эрэлт болон ажиллах хүчний хомсдолын мэдээлэл бусад ажил мэргэжлээр тооцдог үр дүнгүүдээс харахад

хэд хэдэн төрлийн ажил мэргэжлийн ажиллах хүчин аль ч үзүүлэлтэд байнга нэрлэгдэж, энэ үр дүн сүүлийн жилүүдэд давтагдаж байгаа нь онцгойлон анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл тодорхой хэдэн ажил мэргэжил болох тогооч, зөөгч, жолооч, гагнуурчин, барилгын болон бусад туслах ажилтан, цэвэрлэгч зэрэг мэргэжлийн хүрээн дэх хөдөлмөр эрхлэлтийн тогтворгүй байдал нь хөдөлмөрийн зах зээлд нөлөөлөхүйц өөрчлөлтийг харуулсаар байна.



## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- \* Бид энэхүү судалгааны дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргэж байна.
- \* Энэ жил хөдөлмөрийн зах зээлд шинэ ажлын байрны эрэлт өсөж байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн хүрээ нэмэгдэх боломж байгааг харуулж байна. Эрэлттэй байхаар тодорхойлогдсон, ажил мэргэжлийн нийлүүлэлтэд анхааран, хөдөлмөр эрхлэлтийн бодлого, шийдвэрийг чиглүүлэх шаардлагатай байна.
- \* Ажиллах хүчний салбарын дотоод болон салбар хоорондын шилжилт хөдөлгөөн их, сул ажлын байрыг нөхөх ажиллах хүчний эрэлт /labor turnover/ өндөр хэвээр байгааг анхаарч тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- \* Эрэлттэй байхаар тодорхойлогддог, ойрын ирээдүйд эрэлт өсөж буй ажил мэргэжлийн нийлүүлэлтэд анхаарах, МБСБ-ыг түшиглэн залуучуудад зориулсан богино хугацааны сургалтыг зохион байгуулж, төгсөгчдийг ажиллах хүчний эрэлттэй байгаа ААНБ-уудад зуучлах гарцыг бий болгох;
- \* Ажил олгогчдын хүсч буй зөөлөн ур чадварыг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтаар эзэмшүүлэх, төлөвшүүлэхэд анхаарах, мөн хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлбэл зохино.
- \* Хөдөлмөр зуучлалын үйл ажиллагааны олон талт хэлбэрийг сонгох, өөрчлөгдөж буй орчин нөхцөлд уялдуулан, үйлчилгээ арга хэмжээг социал орчинд хөгжүүлэх, нийгмийн харилцааны олон хувилбарыг сонгох;
- \* Хувь хүний хөдөлмөр эрхлэлтийн түүх, ажлын туршлагын талаарх технологид суурилсан мэдээллийн сан бий болгох ажлыг салбарын нөөц бололцоонд тулгуурлан эхлүүлэх;

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН  
БАЙГУУЛАЛТ

## 1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

### Үндэслэл

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны талаар баримталж буй төрийн бодлого, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг оновчтой болгох үүднээс хөдөлмөрийн зэх зээлийн эрэлт, нийлүүлэлтийн талаар суурь судалгааг тогтмол хийдэг бөгөөд энэ үүднээс хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны эрэлтийг тодорхойлох ээлжит судалгааг хийж гүйцэтгэлээ.

### Зорилго

Хөдөлмөрийн зах зээлийн богино хугацаа /2022 он/-ы ажиллах хүчний эрэлтийг ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар тодорхойлж, боловсрол сургалтын, хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид болон судлаачдыг мэдээллээр хангахад оршино.

### Зорилт

Үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- \* 2022 оны ажиллах хүчний эрэлт хэрэгцээг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, ажил мэргэжил, байршил тус бүрээр тодорхойлох;
- \* Дотоодын хөдөлмөрийн зах зээлд өнгөрсөн нэг жилийн хугацаанд үүссэн ажиллах хүчний хомсдолыг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлээр тодорхойлох;
- \* Жил бүрийн судалгааны үр дүнгээр динамик мэдээлэл бэлтгэж, ХЗЗ-ийн эрэлтийн хандлагыг тодорхойлох.

### Судалгааны хязгаарлагдмал байдал

Судалгаа дараах хязгаарлалтыг өөртөө агуулсан болно. Үүнд:

1. Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоог ашигласан учраас албан бус секторын хөдөлмөрийн эрэлт тодорхойлогдоогүй;
2. 2021 онд шинээр үйл ажиллагаа эрхэлж эхэлсэн аж ахуйн нэгж байгууллагууд түүврийн хүрээнд багтаагүй;
3. Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбар, төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгааллын салбарууд нь онцлогтой салбарууд учир түүврийн хүрээнээс хасаж тооцсон.

### Судалгааны ерөнхий зохион байгуулалт

Судалгааны мэдээллийг ААНБ-ын удирдлага, удирдах албан тушаалтан, эсвэл хүний нөөцийн ажилтантай уулзаж, ярилцлагын аргаар цуглууллаа. Мэдээлэл цуглуулахад судалгааны баг дараах зарчмыг баримтлан ажилласан. Үүнд:

- \* Шинжлэх ухааны үндэслэлтэй, нэгдсэн арга зүйг ашиглах;
